





Жеймс Олдриж

ГАЙХАМШИГТ МОНГОЛ МОРЬ

“УЛСЫН ХЭВЛЭЛИЙН ГАЗАР” Улаанбаатар хотноо 1980 онд эрхлэн
хэвлүүлсэн номыг

Цогт охин тэнгэр сангийн захиалгаар Цагаан бамбарууш хэвлэлийн
газарт 2021 онд цахим хэлбэрт хөрвүүлэв.



ЦАХИМ НОМЫН САН: www.e-nom.mn

-

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно.
Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу
орно уу.

БОЛОР ДУРАН 2.0
АЛДАА ШАЛГУУР

**"БОЛОР ДУРАН"
ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ
ПРОГРАМ**

- ✓ 60 сая үгийн сантай.
- ✓ Алдаатай үгсийг илрүүлж, зөв үгсийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үгийн сан үүсгэх боломжтой.

БОЛОР
БОЛОР

ЖЕЙМС ОЛДРИЖ, ТҮҮНИЙ НОМ

(Оршил)

Одоогоос арав гаруй жилийн өмнө олон улсын нэгэн хуралд оролцож явахдаа би Жеймс Олдрижтой анх уулзсан юм. Хурлын завсарлагаар хүмүүс хоёр, гурваараа энд тэнд хар кофе уун, хүүрнэлдэж байх үеэр надтай хамт явсан польш залуу, биднээс холгүй зогсож байсан хоёр хүний нэгийг Английн зохиолч Жеймс Олдриж гэж танилцуулав. Урьд өмнө нүүр учирч, зүс үзээгүй явсан тул би ихэд олзуурхан сонирхов. Дунд зэргийн нуруутай, нимгэн шар царайтай, шөвгөрдүү хамартай сэргэлэн байрын хүн байлаа. Тавиад оны дундуур Москвад Олон улсын харилцааны дээд сургуульд намайг сурч байх үеэр манай сургуулийн оюутнууд Жеймс Олдрижийн «Дипломат» хэмээх романыг ихэд амтархан уншиж, англи хэлний багш нар түүний зарим тууж, өгүүллэгийг гэрийн даалгаварт өгч уншуулдаг байсан нь өөрийн эрхгүй сэтгэлд урган буулаа. Зөвхөн ном зохиолоор дамжин танил болсон тэр хүнтэйгээ ийнхүү нүүр учран уулзах завшаан тохиолдсонд би туйлын баяртай байлаа. Түүнээс хойш дэлхийн олон нийтийн янз бүрийн байгууллагын шугамаар зохиогдсон хурал, чуулган, семинар, симпозиум, уулзалт зэрэгт оролцож явахдаа бид нэг биш удаа уулзаж учирч явлаа.

1973 оны аравдугаар сарын сүүлчээр Москвад болсон Энхийг эрхэмлэгч хүчний дэлхий дахины чуулга уулзалтын «Соёл, боловсролын асуудал» авч хэлэлцсэн комиссын хуралдаанд БНМАУ-ын төрийн шагналт зохиолч С. Удвал гуай бид хоёр оролцсон юм. Тэгэхэд Жеймс Олдриж манай комиссын дарга байж билээ. Тэр бээр хурлыг маш шуурхай, чадмаг удирдаж, үг хэлсэн хүн бүрд оносон товч үнэлэлт өгч, талархал илэрхийлж байснаас гадна баруун орны буруу зөрүү бурахын хэнээ туссан зарим хүмүүсийн «савыг» ч бас хоосон буцаахгүй байж билээ. Энэхүү комиссын хуралдаанд зөвлөлтийн зохиолч Г. Марков, В. Озеров, Борис Полевой, Евгений Евтушенко, Роберт Рождественский, Олжас Сулейменов нарын зэрэг олон хүн оролцсоноос гадна Энэтхэгийн зохиолч Мулк Раж Ананд, Америкийн зохиолч Алберт Кант, Кубын алдарт бүжигчин Алисия Алансо нарын зэрэг олон орны утга зохиол, урлаг, соёлын нэрт зүтгэлтнүүд оролцсон билээ.

Хурлын чөлөө завсраар Жеймс Олдрижтой уулзаж ярилцах хүсэлтэй байсан боловч элдэв асуудлаар түүнийг тойрч бүчсэн хүмүүс бидэнд тийм боломж, зав зай өгөхгүй байлаа.

Харин нэг орой Зөвлөлтийн гадаад орнуудтай найрамдал, соёлоор харилцах нийгэмлэгүүдийн холбоо дэлхийн янз бүрийн орноос их хуралд ирсэн соёл, урлагийн зүтгэлтнүүдэд зориулж «Найрамдлын ордонд» уулзалт үдэшлэг зохиолоо. Энэ үеэр Жеймс Олдрижтой уулзаж тухтай ярилцах боломж бидэнд олдсон билээ. Тэр бээр «Би монгол нөхөдтэй уулзсандаа туйлын баяртай байна. Хэдийгээр би монгол оронд нэг ч удаа очиж үзээгүй боловч танай амьдралыг ихэд сонирхдог. Монгол морины тухай нэг бяцхан тууж бичиж хэвлэлд өгөөд байна» гэж ярьснаа:

— Танайд английн зохиолч Ричард Киплингийн ном зохиолоос орчуулагдсан зүйл бий юу? гэж асуув.

— Бий бий. Түүний хүүхдэд зориулж бичсэн зохиолоос «Шаалуу хүү-Маугли», «Зааны тугал» нэртэйгээр хоёр ч ном манайд хэвлэгдэн гарсан. Түүнээс гадна шүлэг зохиолоос нь ч сонин сэтгүүлд хэвлэгдсэн зүйл бий гэхэд:

— Маш сайн байна. Учир нь гэвэл би монгол морины тухай туужид монгол хүү Баярт, Киплингийн нэгэн шүлгийг уншсанаа санаж байгаа тухай бичсэн юм. Гэтэл редактор маань түүнд эргэлзэж, Монголд Киплингийн тухай мэддэг болов уу? гэж байсан юм. Одоо би түүнд хэлэх үгтэй боллоо. Би «Гайхамшигт монгол морь» туужаа хэвлэгдэн гармагц та бүхэнд явуулна гэсэн. Тэр бээр үнэхээр хэлсэн үгэндээ хүрч Лондонд суугаа манай Элчин Сайдын Яамны нөхдөөр дамжуулан уул номоо явуулсан билээ.

Английн коммунист зохиолч Ральф Уинстан Фокс баруун монголын алдарт туульч Парчинтай уулзсан тухайгаа бичсэн «Ламтай ярилцсан минь» гэдэг өгүүллэг, Айвор Монтегюгийн «Номин тэнгэрийн орон» замын тэмдэглэл номоос хойш Английн зохиолчдоос монголын сэдэвтэй зохиол бичсэн хүн бол Жеймс Олдриж л байх гэж би бодож байна.

Хэмжээгээр төдий л том биш энэхүү туужид манай говийн нэгэн уулнаас тахийн зэрлэг үрээг эрдэм шинжилгээний зорилгоор барьж аваачин Английн Уэльсийн дархан цаазтай амьтан нутагшуулах эдлэн газарт тавьсан боловч тэр үрээ Англи нутагт идээшин тогтохгүй уул ус, уугуул нутгаа эрмэлзэн Франц, Итали, Унгар, ЗХУ-ын нутгийг

дамжин гүйж явахад нь тохиолдсон сонирхолтой адал явдлын тухай монгол хүү Мөнхийн Баярт, англи охин Китти Жемисон хоёрын харилцсан захидлын хэлбэрээр бичсэн юм. Энэ номын зарим хэсгийг орчуулж «Пионерын үнэн», «Залгамжлагч сэтгүүл», «Хөдөлмөр» сонинд нийтлүүлсэн нь манай хүүхдүүд, уншигчдын сонирхлыг нэлээд татсан болно. Уул номыг ЗХУ-ын хүүхдийн хэвлэлийн газраас эрхлэн мөн орос хэл дээр хэвлэн гаргажээ. Жеймс Олдриж хэдийгээр манай оронд урьд өмнө ирж үзээгүй байсан боловч манай орны амьдралыг өөрийн зохиол бүтээлд үнэн зөв, бодит байдлаар тусган гаргах гэж ихээхэн чармайж, монгол орны тухай болон Тахийн амьдралын тухай нэлээд ном зохиол, материал уншиж ашигласан гэж өөрөө сүүлд 1978 онд манайд зочлохдоо ярьсан билээ. Бас түүний ярьсан нэг сонирхолтой зүйл гэвэл: «Би монгол хүний нэг ч нэр мэдэхгүй байсан болохоор зохиолын баатруудад нэр өгөхөд туйлын бэрх байлаа. Англид зочилсон танай парламентын төлөөлөгчидтэй нэг удаа хүлээн авалт дээр тааралдаж хэдэн нэр хэлүүлж авсан боловч түүнийг буруу хазгай тогтоосон тул яг зөвөөр нэрлэж чадаагүй нь мэдээж. Ийм ч учраас би номынхоо оршилд алдаж ташаарсан зүйлийг уучлахыг хүсье гэж бичсэн билээ гэв.

Түүний өгсөн нэрстэй ойролцоо дуудлага бүхий монгол нэр олж оруулаад уул нэрийн жагсаалтыг өөрт нь өгөхөд тэр бээр ихэд баярлаж, англиар дахин хэвлэхдээ яг энэ нэрээр хэвлэх болно гэв. Уул туужийг монгол хэлэнд орчуулахдаа эх зохиолд ганц нэг ташаарсан зүйл тохиолдсоныг зохиолчийн зөвшөөрөлтэйгөөр хасаж өөрчилсөн болно. Тухайлбал: Гүүний сүүгээр бяслаг хийдэг гэснийг зориуд орхиж, Улаанбаатар дахь Гадаад хэлний институт гэснийг Их сургуулийн гадаад хэлний анги болгосон зэрэг болно. Түүнээс гадна зохиолч номоо англиар унших хүнд «Гайхамшигт монгол» буюу «Гайхамшигт монголын...» гэж ойлгогдохоор нэрлэжээ. Харин уул номыг уншаад үзэхэд нэгэн гайхамшигт монгол тахийн тухай өгүүлнэ. Зохиолчоос яагаад ингэж нэрлэсний учрыг сонирхож асуухад: барууны уншигчид ямар нэгэн адгуус амьтны тухай ном байна гэж ойлговол ердөө ч авч уншихгүй гэв. Бид «Гайхамшигт монгол морь» гэсэн гарчигтай хэвлэх гэж байгаа тул танд татгалзах зүйл байна уу? гэхэд уг номын утга санаа нэгэнт тийм болохоор би юунд татгалзах вэ, харин номын чимэг зургийг миний найз, нэгэн сайн зураач хийсэн юм. Хэрэв

та бүхэн энэхүү зураг чимэглэлийг хуулбарлан хэвлэвэл би их баяртай байх болно гэв.

* * *

Английн дэвшилт зохиолч, олон нийтийн нэрт зүтгэлтэн Жейс Олдриж 1918 онд Австралид английн нэгэн сэтгүүлчийн гэр бүлд төржээ. Тэр бээр өөрийн бага насыг Австралид өнгөрүүлсэн бөгөөд 1938 онд Англидаа эргэж ирж Австралид байхдаа эхэлсэн сэтгүүлчийн мэргэжлийн ажлаа үргэлжлүүлэн хийсэн байна. Оксфордийн их сургуульд суралцсаны дараагаар нэг хэсэгтээ Финляндад цэргийн сурвалжлагчаар ажилласан ба дараагаар нь Дэлхийн II дайны жилүүдэд Европ, Ойрх Дорнодын хэд хэдэн оронд фронтын сурвалжлагчаар ажиллаж байжээ. Энэ бүхэн нь түүнд амьдралын том сургууль болсноос гадна түүний бичих ур чадал, туршлагыг улам хөгжүүлжээ. Түүний бичсэн «Кавказын тухай дуу» хэмээх сурвалжилга, «Нэр хүндийн хэрэг», «Далайн шонхор» зэрэг роман, «Хүмүүсийн тухай» хэмээх тууж нь дайны эсрэг, фашизмын эсрэг тэмцэж байсан ард түмний баатарлаг тэмцэл, фашизмын зайлшгүй мөхөх хувь тавиланг тодорхой харуулсан юм. Дайны дараах жилүүдэд Жеймс Олдриж улс түмний эрх чөлөө, энх тайван, аюулгүй байдлын төлөө, империализм, колоницлол, дайныг эсэргүүцсэн тэмцэлд идэвхтэй оролцож байгаагаас гадна энэхүү дэвшилт үзэл санаа нь түүний уран бүтээлд зохих тусгалаа олсон юм.

1946 онд «Дөчин ес дэх муж улс» хэмээх жүжиг бичиж, 1949 онд түүний дорвитой томоохон бүтээлүүдийн нэг болох «Дипломат» хэмээх роман нь хэвлэгдэн гарчээ. Үүгээрээ Дэлхийн энх тайвны зөвлөлийн алтан медаль хүртжээ.

Жеймс Олдриж бол улс түмний үндэсний эрх чөлөөний төлөө тэмцлийн талд бат зогсож, түүнийг шийдвэртэй дэмжигчдийн нэг гэдэг нь түүний «Хоосон цөлийн баатрууд» (1954) «Тэр битгий үхээсэй» (1957) «Сүүлчийн цөлөгдөгч» (1961) хэмээх зохиолуудаас тодорхой ойлгогдож байгаа юм аа. Жеймс Олдрижийн зохиолын гол баатрууд нь жирийн хүн, хөдөлмөрийн хүмүүс байдаг. Тэр бээр Канадын анчны амьдралаас сэдэвлэн «Анчин» (1950) гэдэг роман бичсэн бөгөөд энэ нь амьдралын замд тохиолдсон бэрхшээл зовлонг жирийн хүн ямар тэсвэр хатуужилтай даван туулж байгааг харуулсан байдаг. Сүүлийн жилүүдэд «Алт ба элс» (1960), «Харь нутгийн хүн»,

(1962), «Миний ах Том» (1966), «Аймшигт тоглоом» (1966), «Ой модтой эргийн хүү» (1966) зэрэг олон роман, тууж бичсэн энэ зохиолч өөрийнхөө уран бүтээлд харгис хэрцгий, хар амиа хичээсэн бэртэгчин амьдралыг шүүмжилж, шударга ёс, нийгмийн дэвшлийн төлөө тэмцэж байгаа хүчний ололт ялалт, гэрэлт ирээдүйг тод томруун яруу сайхнаар тусган харуулж иржээ. Түүний зонхилох бүтээлүүд орос хэлээр орчуулагдан гарчээ. 1978 онд түүний 60 насны ойг тохиолдуулан Зөвлөлтийн Зохиолчдын Хорооноос явуулсан баярын бичигт «Далайн шонхор», «Дипломат», «Хоосон цөлийн баатрууд», «Харь нутгийн хүн», «Тэр битгий үхээсэй», «Уул ба зэвсэг» зэрэг нь Зөвлөлт Холбоот Улсад хэвлэгдэн гарсан, зөвлөлтийн уншигчдын талархлыг хүлээсэн таны бүтээлүүдийн бүрэн бус жагсаалт юм аа. Таны баатрууд зөвлөлтийн олон үндэстний хэлээр ярьж, кино дэлгэцээс үзэгчидтэй уулздаг бөгөөд тэд нь бас манай баатрууд болсон юм» гэж дурдсан байна.

Жеймс Олдриж улс түмний энх тайван эв санааны нэгдлийн төлөө, империализм ба дайныг эсэргүүцсэн тэмцэлд олон жил, идэвх зүтгэлтэй оролцсоны учир «Улс түмний хоорондын энх тайвныг бэхжүүлэхийн төлөө» олон улсын Лениний шагналыг 1973 онд хүртжээ. Жеймс Олдриж 1978 онд Монголын Зохиолчдын Хорооны урилгаар манай оронд гэргийн хамт хоёр долоо хоног зочлов. Түүнийг манай оронд байх хугацаанд МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбал хүлээн авч уулзан «Найрамдал» медаль гардуулсан болно.

Жеймс Олдриж «Үнэн» сонинд нийтлүүлсэн «Монголын социалист ирээдүй» хэмээх сэтгэгдэлдээ: ...Танай оронд хоромхон зуур саатахдаа хотод ч, хөдөөд ч янз бүрийн хүмүүстэй уулзаж ярилцлаа... Танай орны хөдөөгийн хөдөлмөрчид, тэр ч байтугай алс говийн малчдын амьдралд ч орчин үеийн нийгмийн ололт амжилт нэвтэрч чадсан нь миний сэтгэлийг ихэд хөдөлгөв» гэж бичжээ.

Жеймс Олдриж манай оронд зочилсон энэ богинохон хугацаандаа өндөр сэтгэгдэлтэй, уран бүтээлийн олз омог ихтэй, заавал дахин ирэх хүсэл эрмэлзлээр дүүрэн буцсан нь мэдээжийн хэрэг билээ.

Уншигч та бүхэнд толилуулан байгаа «Гайхамшигт монгол морь» хэмээх бяцхан тууж нь манай оронд хэвлэгдэж байгаа Жеймс Олдрижийн анхны ном, монголын тухай түүний бичсэн анхны зохиол

бөгөөд цаашид энэ зохиолч манай орны тухай, манай ард түмний амьдрал, хөгжил цэцэглэлтийг тусган харуулсан олон сайхан ном, зохиол бичнэ гэдэгт итгэж байна.

Л. Хуушаан

Эрхэм найз, англи охин Китти Жемисон чиний амрыг эрье!

Би энэ захидлыг чиний өвөө, профессор Ж. Ж. Жемисонгоор явуулав. Учир нь тэр хүн чиний тухай, Пийп хэмээх давжаа бяцхан байдасны чинь тухай надад ярьж өгсөн юм. Өвөө чинь чамд миний тухай ярьсан ч байж магадгүй, гэвч би өөрийнхөө тухай танилцуулъя. Би монгол хүүхэд, миний нэрийг Мөнхийн Баярт гэдэг. Энэ захидлыг миний нагац эгч Сэр-Од англиар бичиж өглөө. Тэр бээр их сургуульд англи хэлний багш хийдэг бөгөөд би хэлэх гэснээ эгчдээ монголоороо хэлж, эгч маань англиар орчуулж өгөхдөө онцын их алдаа хийгээгүй болов уу гэж найдаж байна.

Ингэхэд би чамд өөрийнхөө тухай ярих ч гэсэн хэрэг огт биш. Нэг зэрлэг үрээний тухай л ярих гэсэн юм. Танай өвөө тэр үрээг манай нутгаас Уэльсийн дархан цаазтай амьтан нутагшуулах газарт аваачих юм. Манай нутгийн уулын зэрлэг үрээнд чиний бяцхан Давжаа хань ижил болох юм гэж танай өвөө надад ярьсан. Чиний давжаа Пийп түүнтэй ижилдэн дасна гэж би найдаж байна. Гэхдээ манай уулын зэрлэг адуу бол айхавтар догшин тул чамайг нохой мэт газар сайгүй дагаж явдаг тэр гэрийн номхон байдастай уулзахаараа юу болж таардаг бол гэж би эмээж байна. Манайхан бол удмаараа адуучин улс бөгөөд тэд ч бас л эргэлзэж байна.

Одоо би чамд түүнийг анх яаж олж үзсэн ба барьсан тухай ярья.

Монголын уулын зэрлэг адуу бол дэлхий дээр хамгийн ховор амьтан болох нь хэн бүхэнд ойлгомжтой. Ер нь хамгийн алслагдсан хязгаар нутаг манай говийн ууланд энэ адуу үлдсэн гэдэгт эрдэмтэд ч итгэхгүй байсан юм. Европынхон манай энэ ховор адууг Пржевальскийн морь гэж нэрлэдэг юм. Энэ хүн бол манай нутагт 1882 онд анх түүнийг барьж авсан оросын жуулчин билээ. Харин монголчууд бид бол түүнийг тахь гэж нэрлэдэг. Ийм ч учраас танай өвөө түүнийг тахь гэж нэрлэсэн биз!

Эрт дээр үед манайхан арьс махыг нь ашиглах гэж тахийг агнадаг байсан юм гэнэ билээ. Харин одоогоос тавиад жилийн өмнө эрдэмтэд энэ адуу бол шинжлэх ухаанд чухал хэрэгтэй зүйл, яагаад гэвэл хүн төрөлхтөн бий болохоос өмнө амьдарч байсан нэгэн төрлийн адууны үлдэгдэл гэж нотолжээ. Хүмүүс түүнийг барьж сурган, гэрийн мал болгож чадаагүй учир зэрлэг хэвээр үлдсэн байжээ. Энэ нь францын

нэг агуйгаас олдсон хадан дээрх морины зурагтай ижилхэн байснаар нотлогдсон байна. Манай энэ адуу ямар ховор, чухаг амьтан болохыг мэдсэн тэр үеэс хойш бид түүнийг агнахаа больсон юм. Энэ бол дөчөөд жилийн өмнө, харамсалтай нь тэр адуу бүр цөөрсөн хойно ухаарсан хэрэг билээ. Сүүлийн гучаад жилд манай болон дэлхий дахины олонх эрдэмтэд монголын зэрлэг адуу мөхөж арилсан гэж тооцож байжээ. Тэд манай орноор хэрэн яваад нэгийг ч олж үзээгүй юм. Үлдсэн нэг нь амьтны хүрээлэнд байлаа. Гэхдээ тэр нь жинхэнэ хольцоогүй зэрлэг адуу бас биш байлаа.



Би ч зэрлэг адууг үүний өмнө огт үзээгүй байсан. Бидэрт хүрнээ (миний морины нэр) унаж, биеэ даан тал хөндий, довцог толгодыг дамжин адуу маллах болсон хойноо ч зэрлэг адуутай таарна гэж зүүдлээгүй явсан юм. Учир нь огт үлдээгүй гэдэгт бас итгэж байв. Харин манай эцэг, авга ах, өвөө амьтны хөл хүршгүй өндөр уул, хавцал гуу, уулын энгэр хажуугийн бэлчээрт эрт дээр цагт зэрлэг адуу бэлчиж, идээшилж байсан тухай ярьдаг байлаа.

Нэг удаа би алдсан хоёр морио эрж, адуу бэлчдэг байсан говийн ердийн уулнаас хэтэрч, амьд амьтан баймааргүй асга хадтай гүн хавцлын дэргэд очив. Гэв гэнэт бор шарга зүсний хоёр сонин адуу нүдэнд тусав. Тэд нь илжиг гэж эндүүрмээр биеэр багашаархан амьтад юм. Дөнгөж сая гарсан бололтой нэг унаганы дэргэд тэр хоёр зогсож байлаа. Би өөрийнхөө адууг бол юу андах вэ. Энэ хоёр адуу, тэр унага ямар ч байсан манайх биш гэдгийг тэр дороо мэдлээ. Нэгдлийн алдагдсан адууг эрж сурч энд тэнд явахдаа монголын өргөн уудам тал нутагт аливаа юмыг бид тэсвэртэй, гярхай ажиглаж сурсан улс билээ. Энэ адууны өнгө зүс, байгаа байдал нь нэг л өөр, манай жирийн адуунаас толгой нь арай том болохыг би ажиглав.

Би эргэцүүлэн сайн бодсоны эцэст миний өмнө хэдийн мөхөж арилсан гэж үзэж байсан зэрлэг адуу, монголын жинхэнэ зэрлэг адуу байна гэдгийг ойлгов.

Би анир чимээ гаргалгүй хэвтэж ажигласан боловч өөрийн нүдэнд итгэхэд бэрх байлаа. Энэ хавьд бас ижил сүрэг нь байж магадгүй, иймээс тэр хоёрын хаачихыг сайн ажиглах хэрэгтэй гэж бодов. Харин миний Бидэрт хүрэн гэв гэнэт тэдний үнэрийг авсан юм уу, үргэж тонгочих янзтай. Зэрлэг адуу хэрэв аюул занал учирлаа гэж мэдвэл хүн рүү ч атугай дайрахаас буцахгүй гэж манай эцэг ярьж байсныг санаад Бидэртийн үргэж тэмүүлж байгаа учрыг ойлгов.

Чимээгүй! гэж би Бидэртийг загнав. Гэвч тэд сэжиг авсан бололтой. Унагыг хөл дээр нь тэнцүүлж зугтахыг завдаж байв.

Тэгвэл яв! гэж хэлээд би морио тавив.

Бидэрт холдохгүй гэдгийг би сайн мэдэж байсан тул үлдэж зэрлэг адууны байдлыг жаахан ажиглая, тэд унагаа орхиод холдохгүй гэж би итгэж байлаа. Унага нь турь муутай хөл дээрээ нэг босоод дахин шургаж унав.

Би чимээгүй хэвтсээр л байлаа. Тэд унагыг хөлөөрөө, хошуугаараа түлхэж үзэн, эргэн тойрныг сэжигтэй ажиглана. Дараа нь тэдний нэг аяархан янцгаав (Манай нутагт үүнийг өвсний шугшраа гэдэг юм). Гэнэт би тэдний зүг нэг омголон азарга үрээ давхиж ирэхийг харав. Тэр үрээ хоёр гүүний дэргэд зогсоод миний зүг ширтэн харна. Дараа нь туурайгаараа газар цавчих нь би чиний хаа байгааг чинь мэдэж байна гэх шиг. Холоос хол мөртөө надад заналхийлж байгаа нь илт байв. Энэ завсар хоёр гүү унагыг босгож, тэд аажмаар холдон одов.

Ингэж би анх удаа зэрлэг үрээг харсан бөгөөд энэ маань нөгөө тахь байсан билээ.

Эхлээд би зэрлэг адууны тухай хэнд ч хэлээгүй, ер нь эцэгдээ ч, дүү Минжээ, ах Шинжээ нарын алинд ч хэлэхгүй гэж бодож байв. Би энэ тухай хэнд ч, өөрийн бяцхан эмэгтэй дүүд ч хэлэхгүй гэж шийдсэн маань учиртай юм. Яагаад гэвэл энэ зэрлэг адууг үзэхээр дэлхийн бөмбөрцгийн өнцөг булан бүрээс эрдэмтэд онгоц, нисдэг тэргээр ирж тэднийг айлгаж үргээх болно. Хэрэв тэд айснаас болоод зэргэлдээ их цөл рүү зугтчихвал бид хэзээ ч олохгүй, тэд тэндээ харангадаж үхнэ. Олон жилийн өмнө тэд хүнд баригдахгүйн тулд үхэхээс ч буцахгүй дайжиж зугтсан удаатай юм.

Иймээс би хэнд ч, юу ч яриагүй билээ. Магадгүй, танай Англид адууны тухай өөрөөр ойлгодог байж болно. Харин манай нутагт хүний амьдрал адуу малтайгаа нягт холбоотой. Бид адуугаа маллана, өсгөнө, сүүгээр нь айраг исгэж ууна, махыг нь иднэ. Заримдаа хүмүүс адууны ширээр гэрийн бүрээс ч хийх явдал бий (Бид орон сууцаа гэр гэж нэрлэнэ). Олон зуун жилийн турш манайхан тархай, бутархай амьдарч байсан бол одоо цөм нэгдэлд орсон. Манай амьдрал урьд урьдаас улам аз жаргалтай, соёлч боловсон болж байна. Манай нутаг шиг хүний амьдрал адуу малтайгаа ийм ойр газар дэлхийд хаа ч байхгүй гэж Сэр-Од ажаа ярьдаг юм.

Эрт урьд цагт энэ ховор зэрлэг адууг манайхан ердийн сонирхлын үүднээс биш, зөвхөн амьдралын шаардлагын үүднээс агнаж байсныг эрхбиш чи ойлгосон байх гэж найдаж байна. Манай гэрийн адуу малын хувьд гэвэл бид жилийн дөрвөн улиралд адуун сүрэгтэйгээ хамт бэлчээрийн аль сортой сайхныг дагаж нүүдэллэнэ. Бэлчээр бол олон зуун километр үргэлжилсэн их газрыг эзэлдэг юм. Морь бол бидэнд зөвхөн унаж зугаалах буюу америкийн ковбой маягаар эдлэхэд гол нь биш. Морь бол бидний амьдралын салшгүй чухал хэсэг нь мөн. Иймээс ч би тэр зэрлэг адуунд ямар нэг муу юм учрах бий гэхээс болгоомжлоод байсан хэрэг.

Дараагийн өдөр нь би тэр ууланд дахин ирж, Бидэртийг бяцхан хонхорт тушиж орхиод, өөрөө уулын хяр өөд авирч урьдын танил болсон хавцал руу өнгийн харав.

«Азтай байна» гэж амандаа үглэв.

Тэд уул газартаа эргэж ирсэн байв. Энэ удаа хорин тав орчим тооны адуу байлаа. Зарим нь асгын хооронд зогссон, зарим нь өвсөн

дээр тэрийж хэвтсэн харагдав. Сүрэг дотор дөрвөн унага байлаа. Тийм хөөрхөн унагыг хэн ч амьдралдаа үзээгүй байх. Толгой нь данхар, хөл нь паацгар бүдүүн, үзье гэвэл циркийн алиалагчид морь болж тоглосон инээдэмт үзэгдэл гэмээр. Хоёр хүн хойно урдаа орж зогсоод морь болохоороо ямар байдаг билээ, тэр л гэсэн үг.

Би нөгөө бага үрээг олж харах гэж бодсон боловч тэдний дотор байсангүй. Ойр хавийн газрыг нь сайтар ажиглаж байвал, тэр хавцлын нөгөө хажууд зогсож байгаа харагдав. Тэр толгойгоо хаялан, сүүлээ шарван зогсож байгаа нь яг мөн байлаа. Сүрэгт байгаа залуу морьдын дотроос хамгийн зоригтой, хамгийн ааштай болох нь харваас андашгүй байлаа. Даанч нас нь гүйцээгүй учир сүргийн эзэн болж хараахан чадаагүй бололтой.

Нас гүйцээгүй үрээнүүд сүргийн эзэн болохын тулд яаж тэмцэлддэг, зарим үед бие биеэ алдаг удаатай тухай янз бүрийн сонин зүйл өвөө надад ярьж өгдөг юм. Гүүгээ хураах гэж тэмцэлдэх үедээ л хамгийн аймшигтай тулалдаан хийдэг гэнэ. Сүргийн эзэн болно гэдэг бол бас жирийн хэрэг биш, их үүрэгтэй байдаг. Сүргээ бүрэн бүтэн байлгах, аюулаас сэрэмжлэн зугтаалгах, хэрэгтэй үед зоригтой хамгаалах ёстой. Юуны өмнө сүрэгт аюул занал учруулж болох бүхэнтэй тэмцэх хэрэгтэй. Энэ зэрлэг үрээ хэзээ нэгэн цагт сүргийн эзэн болно гэдэгт би бат итгэж байсан. Учир нь тэр бол их ухаантай бөгөөд зоригтой. Уулын нөгөө хярд намайг байна гэдгийг сүрэг дотроос ганцхан тэр мэдэж, нөгөөдүүл дээрээ давхин очив.

Тэгээд тэднийгээ хазаж, хайрч зугтаалгах оролдлого хийв.

Харин тэд үүнийг нь огт анхаараагүйгээр барахгүй нэг хөгшин морь эргэнгүүт нь түүнийг чанга тангарч орхив. Ер нь морьд зодолдохдоо буюу хэн нэгийгээ залхаан шийтгэхдээ дандаа тэгж тангаралцдаг юм.

Тахь (нөгөө үрээг би цаашид ингэж нэрлэх болно) хариу тангартал тэр хөгшин морь огцом эргэж шилэн дээрээс нь хазав. Бас нэг унагатай хөгшин гүү Тахийг тангарав. Иймээс би тэр сүрэг дотор тахь буурь олж сүрэг тэргүүлэх болоогүй юм байна гэдгийг нь ойлгосон юм.

Чухамдаа бол намайг тэдэнд аюултай байж болно гэдгийг ойлгож адуун сүргээ зугтаалгахыг чармайдаг нь Тахийн түмэн зөв байлаа. Тэд ийнхүү сонор сэрэмж муутай байсан учраас надад тэднийг сайн ажиглах боломж олдсон юм. Зэрлэг адуу, гэрийн адуу шиг номхон

тайван биш, цаанаа нэг л догшин, дэл, ар зооноос хазалцах, тангаралцах, шөргөөлцөх зэргээр бие биеийгээ үргэлж өдөж сэдсэн байдалтай байгаа нь харагдав. Тэднийг ажиглаад байхад туйлын инээд хүрмээр агаад заримдаа би инээдээ барихын тулд ногоон дээгүүр дэмий өнхөрч ч үзэв.

Тэр хавар би өдөр бүр зэрлэг адуу олж үздэг болов. Заримдаа тэд урт хоолой даган бэлчээрлэнэ. Зарим өдөр уул өөдөө гараад явчихна. Би ч гэсэн тэднийг дагаж ууланд гараад өвсөн дотор нуугдан хэвтэж ажигладаг байлаа. Байрыг нь ажиглавал, тэд голцуу шөнө бэлчдэг, тэгээд ч тэр болгон хүнд үзэгддэггүй байжээ.

Тахийн хэвтэж байхыг би огт хараагүй. Тэр адуун сүргээ сэрэмжтэйгээ тойрон явж, ямагт салхи сөрнө. Нэг удаа тэр дөрвөн гүүр таслан авч уулнаас буусан сүүдэрт хөөн оруулав. Гэтэл нэг хөгшин азарга түүнийг мөрөөрөө явагтун гэж сануулж буй байртай ар сэрвээн дээрээс нь хүчтэй нь аргагүй хазав.

Бас нэгэн удаа хэдийгээр би маш хол байсан боловч тахь дахин адуугаа зугтаалгахыг оролдсонд би мэл гайхав. Тэгэхэд түүн рүү нас гүйцсэн дөрвөн азарга зэрэг дайрав. Энэ аймшигтай бөгөөд хөгтэй тулалдаан таван минут хэр үргэлжлэв. Тахийн дөрвөн тал руу дөрвөн азарга зэрэг тангарч гарав. Тахь ганцаараа тэдний эсрэг хариу тангарч байв. Ёстой л цирк тоглож байгаа мэт сонин юм боллоо. Учир нь тахь зогсолтгүй дороо эргэн тангарч байсан юм. Миний бодоход тэд тахийн зугтахыг хүлээж байсан бололтой. Тэд маш хайр найргүй тангарч байв (Тэгэхдээ бүүр гэдэс рүү нь онохыг улайран хичээж байв. Ер нь адуу бие биеийгээ алья гэхээрээ л тэгж тангардаг юм). Тахь хэдий хайр найргүй өшиглүүлсэн боловч зүрх нь харьсангүй, харин ч азаргануудын хөөхөөс байдаг чадлаараа зайлж чадаж байлаа.

Чиний зөв! Битгий бууж өг! Би энд байхад та нар зугтах нь зүйтэй! гэж би шивнэн өгүүлэв.

Тахь ямагт ганцаардаж байсан боловч түүний зориг хэзээ ч мохож байгаагүй. Адуугаа аюулаас зайлуулахын тул уйгагүй тэмцэж байв. Ийм л амьтныг би ууланд орхиод сургуульдаа явсан хүн дээ. Ууланд зэрлэг адуу байна гэдгийг би хэнд ч хэлээгүй, хэлэх ч сонирхол огт байгаагүй. Тахь болон түүний адуун сүргээс хагацахад надад тун харамсалтай байлаа. Түүнийг адуун сүргийнхээ эзэн болж чадах эсэх, үнэнээ хэлэхэд эзэн болохыг нь үзэх хүсэл надад тун их байлаа.

Бэлчээрээс сургууль чухал гэж эцэг маань ярьдаг байв. Хамгийн сүүлийн удаа би тахь нэг хөгшин азаргатай зодолдож байхыг харсан. Гэхдээ тэр? нь сүргийн эзэн биш байсан юм. Тэд бие биеэ тангарч, хазаж байсан. Хэдийгээр би хоёр зуугаад метрийн хол байсан боловч тэдний түлхэлцэх, янцгаалах нь надад ил тод сонстож байв. Тэнд ер бусын юм болсон. Тахь түүнийг урд хоёр хөлөөрөө самран цавчиж эхэлмэгц тэр азарга ум хумгүй зугтсан. Ийнхүү энэ удаа тэр ялсан юм. Гэвч энэ ялалт бол сүүлчийн ялалт биш, иймэрхүү, үүнээс ч ширүүн хатуу тулалдаан нэг биш удаа тохиолдох нь мэдээжийн хэрэг.

Миний Сэр-Од ажаа бичсээр байгаад ядарч байна гэж хэлэв. Манайд ихээхэн алдартай дууч Норовбанзадын дуулахыг радиогоор сонсож, жаахан амарсны нь дараа би захидлаа үргэлжлүүлэн бичье! Би Том Жонс, Битлүүдийн Тухай сонссон байхад, чи түүний тухай бас сонссон ч байж болох юм шүү дээ, тийм үү?

Ер нь ингэхэд, тахь сүргийнхээ ойрхон миний очихыг зөвхөн мэддэг байгаад зогсоогүй, нууцаар миний ойртох явдалд, намайг явах үеэр бүүр дургүйцэхийг байсан гэж би ойлгосон юм. Ийм ч учраас би түүнтэй сүрхий ижилсэн дассан юм. Сүргийн дотроос миний ойртон очиж байгааг мэдэрч чадах ухаантай цорын ганц унага нь Тахь байлаа. Хаврын шувтаргаар тэр бээр миний зүг нэг л янзтай харж «өвсний шугшраагаар» баярлан шившдэг болсон юм. Магадгүй, энэ нь намайг аль болохоор цаашаа холд! гэж сануулсан дохио ч байсан байж болох юм. Хэн мэдэх вэ?

За баяртай

Чиний шинэ танил
Мөнхийн Баярт

Китти Жемисон, сайн байна уу?

Би танай нутагт хэдийнээ хүрсэн байх ёстой тэр тахийг яаж барьсан тухай одоо яриагаа үргэлжлүүлье. Төрсөн нутгаасаа холдож үзээгүй тэр амьтан уул, ус, зэрлэг адуун сүргээ санан мөрөөдөж байгаад би огт эргэлзэхгүй байна.

Түүрүүчийн захидлыг би сургуульдаа явах болсон тухай бичээд төгсгөсөн биз дээ. Өнөө хүртэл хэнд ч нууцыг нь задлаагүй тахь болон түүний зэрлэг сүргийн талаар би хэчнээн ил сэтгэл зовж байсныг чи лав төсөөлж байгаа байх. Дэлхий дээр хамгийн том нууцыг хадгалж яваа хүн би болох нь лавтай. Манай багш эмэгтэй намайг ямар их мартамтгай болчихоо вэ? гэж гайхав. Тэр бол үнэн. Миний ухаан санаа ч ууланд байлаа. Түүхийн хичээл давтаагүй гэж би зэмлэл авсан. Би багшийнхаа заадаг хичээлд сонирхолгүй болж түүнийг гомдоосон байна. Иймээс багшдаа очиж залхуурсныхаа бурууг хүлээх хэрэгтэй гэж ажаа намайг загнав. Хэрэв би түүх мэдэхгүй бол яаж соёлтой боловсон хүн болох билээ дээ!



Зун болохын хооронд өдий төдий он жил өнгөрөх шиг санагдав. Манай нэгдэлд агрономчдыг авчирсан нисдэг тэргээр намайг гэртээ

ирэхэд эцэг маань чи энэ ууланд адуугаа битгий бэлчээ, зэрлэг адуу дайрч ч болно, төөрч ч болно, газар сайгүй өвсөн дотор нуугдмал байдаг нүхэнд унаж ч болно гэж анхааруулав.

— Мэдлээ! гэж хэлээд, — Харин би Бидэртээ унаад цагаан сүүлт тасуудыг үзэхээр явж болно биз дээ?

— Адуун сүрэгт ямар нэг аюулгүй, ил тал газар бэлчиж байгаа үеэр нь болно гэж тэр бээр зөвшөөрөв.

Би адуугаа уул өөд аль болох ойрхон бэлчээх болов. Нүдэнд ил газар адуугаа орхиод, урт хоолой руу Бидэртийн хурдаар жирийнэ. Өдөр бүр улам цаашилсаар байгаад, эцсийн эцэст арай чамай нөгөө зэрлэг адууг дахин олж үзэв. Тэд сахлаг өвстэй уулын огцом өндөр хажууд байлаа. Тэдний дунд тахь толгойгоо хаялан, сүүлээ шарван зогсож байхыг би хармагцаа танив. Тэр толгойгоо тун өвөрмөц цогнойлгож, соргог анчин нохой шиг салхины үнэр шиншилнэ.

Би бүтэн сарын турш, өдөр бүр тахь яаж адуун сүргийнхээ анхаарлыг над руу хандуулахыг оролдож байхыг ажигласан бөгөөд харин тэдний хамгийн ахмад азарганууд, зарим нэг гүү хүртэл тахь өөд хажиглан давшилж байснаас биш, түүний энэхүү сэрэмжилсэн дохиог ойлгосонгүй. Гэсэн ч тахь аажимдаа тэдэнтэй хийсэн тэмцэлд ялдаг болов. Тэр бээр зуны дунд сарын үед гурав дөрвөн гүүг таслан хурааж чадсан боловч азарга болоход арай балчирдаж байлаа.

Хамгийн сүүлчийн өдөр, надад золгүй явдал тохиолдож бэртэхийн өмнөхөн (тэр өдөр би зэрлэг адууг олж харсан юм) надад нэг хөгшин азарга орондоо тахийг бүрмөсөн тавих гэж байх шиг санагдав. Нэг залуу байдас тэдэн дээр сүүлээ шарвалзуулан гүйж ирэх хүртэл тэр хоёр маш найрсгаар зэрэгцэн идээшилж байлаа.

Хөгшин азарга гэнэт тэр байдас руу уурлан довтолж, бөөр дээрээс нь хэгз хазав. Дараа нь тахь юу болж байгааг ухаарахын завдал өгөлгүй тэр бээр дайрч, сэрвээн дээрээс нь шүдээрээ зуун, огцом хүчтэй татсанд тахь тэрийн уналаа. Энэ бол тахид маш аюултай мөч байлаа.

— Босооч! гэж би хашхирав. Би нэг жижигхэн агуйн дэргэд нуугдсан байв. Бидэрт миний ард зулгааж өгсөн ногоог идэн зогсож байлаа.

Тахь босохоор завдах болгонд нь хөгшин азарга түүнийг өшиглөн унагаана. Тахь өвдсөнөөс болоод яраглаж байхыг би сонссон.

— Хэрэв чи босохгүй бол цаадах чинь чамайг ална шүү! гэж би хашхирав.

Хөгшин азарга тахийн дээр мордож зогсоод урд хоёр хөлөөрөө бөмбөрдөнө. Тахь түүнийг нь хазахыг оролдоно.

Хөгшин азарга түүнд босох бололцоо огт олгохгүй байсан бөгөөд ер нь харахад нүд халтирам аймшигтай зүйл энэ байлаа. Китти, хэрэв чи адууны амьдралыг сайн мэддэг бол нэгэнт хажуулдан унасан адуу босох гэж яаж зовдгийг лав ойлгох байх! Эхлээд өвдөглөн өндийж байж дараа нь биеэ дааж босно. Тэр ч байтугай, нэгэнт өвдөг сөхөрсөн адууг хажуулдуулж унагахад тун амархан байдаг. Хөгшин азарга түүнийг өвдөг дээрээ өндийхийг завдмагц нь өшиглөж хазаж, тангарч унагаасаар байв.

Байдал хүнд болов. Хэрэв би яаралтай ямар нэг арга хэмжээ авахгүй бол тахь өнгөрлөө гэж ойлгомгоцоо босон харайж, тэр хавцлын руу «Хайя, хайя, хайя» хэмээн хашхирч хар эрчээрээ гүйв.

Бусад адуунууд нь хэдийнээ намайг хараад үргэн зугтаж байхад, тэр хоёр намайг огтхон ч ажиглах сэхээгүй байлаа. Дараа нь хэдийгээр газар хэвтэж байсан боловч эхлээд тахь намайг харав. Тэр бээр шүдээ ярзайлган часхийсэн огцом нарийн дуугаар унгалдсан нь аюулын дохио байлаа. Хөгшин азарга намайг олж харах ч үгүй, чимээ анир сонсох ч үгүй, зодолдсон хэвээр байлаа. Хэдийгээр тэр бяр чадалтай, хэрцгий догшин, арга зальтай боловч нүд нь муудаж, чих нь дүлийрч эхэлсэн тул адуун сүрэгтээ олигтой өмөг түшиг болж чадахаа больсон нь ойлгомжтой байв. Хэрэв тэр аюул заналыг ухааран мэдрэх чадалгүй болсон бол сүргээ асарч, хамгаалж чадах өөр эзэн томилох шаардлагатай болсон нь мэдээж. Ийм ч учраас тахь удирдлагыг өөртөө авахыг эрмэлзсэн хэрэг биз ээ.

Эцсийн бүлэгт хөгшин азарга намайг ажиглав. Одоо бодоход би маш тэнэг юм хийсэн байна. Тийм ойрхон очоод байхад тэр хоёр хоёулаа над руу дайрч болох байсан шүү дээ. Тэр үед би зөвхөн тахийн тухай л бодож явжээ. Хөгшин азаргыг над руу харах хооронд тахь ухасхийн босов.

Хужирлаг, өндөр өвсөөр бүрхэгдсэн гүнзгий алам нүхэнд хэрэв би гэнэт нисэж унаагүй бол чухам юу болох байсныг хэн мэдэх вэ? Ер нь би тиймэрхүү нүхнээс тун болгоомжилж явдаг бөгөөд хэрэв тахийн төлөө тэгж их санаа тавиагүй сэн бол арай ч нүхэнд унахгүй байсан байх. Би маш эвгүй унасан байна билээ. Ухаан ороход би өөдөө харан

хэвтэж байсан бөгөөд түмэн од гялалзан, монголын тэнгэр нүүрэн дээр минь хүнхийж харлан байв. Эргэн тойрны эзгүй уулсын ялдам намуун цуурай үл мэдэг нүргэлэх мэт. Зарим үед ямар ч анир чимээгүй гайхмаар дүнсгэр байдал нөмөрч, зарим үед алс холд элдэв хачин сонин дуу чимээ гарах мэт сонстоно. Гүнзгий нүхний эрэглэсэн харанхуй хананаас өөр хажууд минь юу ч алга байлаа.

Би хөдлөхийг оролдов. Гэвч бие маш сул байлаа. Толгой өвдөж нуруу хөшөөд хэвтэхээс өөр хийж чадах юмгүй байлаа. Нэлээд удаан хугацаанд ухаангүй байснаа би ойлголоо. Тэгээд сургуульд байхад английн яруу найрагч Р. Киплингийн «Эргэн тойрон хөл толгойгоо алдлаа ч эрхбиш өөрөө чи сэхээтэй байхыг бод...» гэсэн нэгэн шүлгийг цээжилж байснаа санав. Тийм учраас эргэн тойрныг нөмөрсөн энэ замбараагүйдлийн дунд өөрөө би толгойтой байхыг хичээж, Бидэрт маань хаа байгаа бол гэж бодлоо. Тэр лав гэртээ гүйж харьсан бөгөөд манайхан миний хойноос эрэл сурал болж байгаа гэж бодов. Гэхдээ би хэтэрхий алсын ууланд гарчээ. Эргэн тойрны энэ их цавчим оргилуудын дунд, гүнзгий нүхний ёроолд хэвтэж байгаа намайг олно гэдэг бас ч тийм амар ажил ч биш дээ. Ядаж энэ нүх айхавтар гүнзгий, түүнээс өөрийн хүчээр гарах ямар ч найдлага байхгүй.

— Хэрэв тэд намайг л олдог юм бол зэрлэг адууг олж үзэх болно гэж амандаа би үглэв.

Хэдийгээр тэд намайг олоосой гэж маш их хүсэж байсан боловч бас зэрлэг адууг олж үзнэ гэдэгт л тун харамсаж байлаа.

Энд би захиагаа төгсгөхөөс өөр аргагүй боллоо. Учир нь керосин дэнгийн гэрэлд удаан бичих ядаргаатай байна. Нүдний угаар хөшиж өвдөөд, удахгүй нүдний шил зүүх болж байх шиг байна гэж ажаа үглэв. Одоо манайх алс хол уулын зусланд байгаа бөгөөд цахилгаан шугам нааш нь татаж авчрах ямар ч бололцоогүйг чи төсөөлж байгаа биз дээ? Гэхдээ хэзээ нэгэн цагт цахилгаантай болно гэдэгт би итгэж байна. Иймээс захидлаа энэ удаа төгсгөж тахийг яаж барьж авсан тухай дараачийн захидалдаа бичье дээ.

Баяртай

Чиний шинэ танил
Мөнхийн Баярт

Сайн байна уу, Китти!

За, би тэгээд, яаж гардаг билээ гэж бодоод л нөгөө гүнзгий нүхэндээ сууж байтал, ёстой л аз завшаан тохиолдож тэндээс гарав.

Үүр цайх үеэр шүүдрийн усанд би салам норсноос гадна өлссөн гэж тамтаггүй. Би бүтэн өдөр шөнө тэнд суугаад, маргааш өдөр нь миний том ах Шинжээ намайг санамсаргүй олжээ.

Тэр бээр энэ ууланд хэнийх нь үл мэдэгдэх хэдэн адууны мөрөөр хөөсөөр яваад намайг олжээ (Энэ үед аав өвөө хоёр өөр газраар намайг эрж явжээ).

Эхлээд тэр бээр өөрийн адуунаас тасарсан морьдын мөр гэж санаад түүнийг мөрдөөд байжээ. Харин намайг олохынхоо өмнөхөн энэ ууланд бас өөр адуу бий гэдгийг ухаарснаар барахгүй (намайг ч энэ хавьд байх ёстой) гэж таажээ. Өөр адуу гэдэг нь мэдээжийн хэрэг зэрлэг адуу шүү дээ.

Дараа нь Шинжээ надад: би нэг үе балмагдсанаасаа болоод чамайгаа ч бараг мартаж орхисон гэж яриу. Тэр бээр надтай л адилхан урьд өмнө зэрлэг адуу огт үзээгүй бөгөөд харин зэрлэг адуу байгаа газрыг хомоолоор нь тодорхойлдгийг мэддэг байсан тул анхааралтай ажиглаж явжээ. Тэр бээр болгоомжтойгоор яаралгүй хяраас хяр дамжин орчин тойрноо ажиж яваад нэг хэсэг газар шороо манарч байхыг гэнэт олж харжээ. Тэр нь би өөрийнхөө байсан нүхний шороог малтан цацаж байсан хэрэг.

Ах бид хоёр зэрлэг адууны талаар хэрхэн сүртэй маргалдсан тухай би чамд ярихаа больё. Энэ тухай хэн ч мэдэх ёсгүй гэж би зүтгэв. Шинжээ бол надаас насаар ах учир бид энэ тухай засгийн газарт мэдэгдэж, түүнийг улсын хамгаалалтад авхуулах нь зүйтэй гэж хэлэв. Гэхдээ тэр бээр зэрлэг адууг өөрийн нүдээр олж үзээгүй, надаас өөр хэн ч түүнийг олж үзээгүй байсан юм. Бид гэртээ ирсний дараа тэр бээр миний нууцыг хамаг амьтанд задруулснаас болж, хүмүүс надаас элдвийн юм асууж сонирхож эхлэв. Энэ нууцыг хүнд хэлэхгүй удаан дарагдуулсанд аав их уурлав. Хэдийгээр миний нуух оролдлогыг буруушааж байгаа ч гэсэн хэн нэгэн хүн ирж тэдний тайван байдлыг алдагдуулахад аав бас миний адил дурлахгүй байх ёстой гэж би бодсон юм.

Биднийг зун оторт байхад, хэрэв өвдвөл доктор нисдэг тэргээр ирэхээс өөр хүн амьтан бараг үзэгддэггүй юм. Докторыг ирэхэд нь би ухаан алдаж унасан тухай хэлэхэд, нугасандаа гэмтсэн байна хэдэн долоо хоног хөдлөхгүй хэвтэх хэрэгтэй гэв.



Ийнхүү намайг өвчтэй хэвтэж байхад, манайх руу эрдэмтэд цувж эхлэв. Аав зуу гаруй эрдэмтэд ирсэн байх гэж би хэлэх гэтэл Сэр-Од ажаа зөвхөн бүдүүлэг хүмүүс л юмыг өсгөж ярьдаг юм гэж намайг зэмлэв. Эхлээд манай нийслэл Улаанбаатараас эрдэмтэд ирсэн. Дараа нь Москвагаас, Чехословакийн нийслэл Прагаас хоёр, Стокгольм, Гамбургээс тус тус нэг эрдэмтэд ирсэн.

Мэдээжийн хэрэг, надаас: яаж анх би тэр адууг олж үзсэн, тэд ямар шүү зан араншинтай байсан, эрүүл саруул адуу байсан уу, хэдэн тооны адуу байсан, азарга нь хэд, унага нь хэд байсан гэх зэргээр үй түмэн юм асууж гарсан.

Би тэдний бүх асуултад үнэн шударгаар хариулсан боловч чиний тахь гэж нэрлэх тэр үрээний тухай л юу ч хэлээгүй. Хэрэв би түүний зоригтой, ухаантай болох тухай ярьчихвал тэд зөвхөн түүний хойноос хөөцөлдөх болно гэж би айсан юм.

— Та нар зэрлэг адууг барьж авахаар явах гэж байгаа юм уу? гэж би эрдэмтдээс асуув.

— Барьж авахаар биш, хамгаалахаар ирсэн. Энэ адуу бол маш үнэтэй цэнтэй зүйл. Бүрмөсөн сөнөж арилахаас нь урьдчилан сэргийлэх нь чухал! гэж тэд хариулав.

— Та нар тэднийг амьтны хүрээлэнд аваачих гэж байгаа юм уу?

— Үгүй, харин бид тэднийг зэрлэг хэвээр нь байлгахыг хүснэ. Гэхдээ тэдний амьдралыг ажиглах, судлах хэрэгтэй.

— Тэд тун их үргэмтгий. Хэрэв ямар нэг хүн ойртож очвол тэд байгаа газраасаа дайжиж, ус ч үгүй, өвс ч үгүй ууланд гарах юм уу, эсвэл эзгүй цөл рүү зугтана.

— Битгий сэтгэл зов! Бид тэднийг огт айлгахгүй гэж эрдэмтэд намайг тайвшруулав.

Эрдэмтэд мэдэхгүй юм байхгүй, тэд их өргөн мэдлэгтэй. Гэхдээ зэрлэг ч бай, гэрийн ч бай, бэлчээрийн адууны амьдралыг төдий л сайн мэдэх болов уу даа? Адууны дэргэд үргэлж хамт байж, тэдний амьдралыг ажиглана гэдэг чухам юу болохыг тэд ойлгохгүй гэж би боддог. Ингэж ярих нь эвгүй! гэж ажаа намайг зэмлэв. Үнэн хэрэгтээ би адууны санаа сэтгэл, зан араншныг ойлгохын тулд хүн юуны өмнө адуутай хамт амьдарч, түүнийг гардан маллах, сэтгэхүйг нь ойлгох хэрэгтэй гэж л хэлэх гэсэн юм л даа.

Иймээс эрдэмтэд зэрлэг адууг очиж үзэхээр явахдаа намайг орхиход нь тэд яасан ч олохгүй гэдэгт би итгэж байлаа. Тэгээд ч тэд олоогүй юм. Үр дүнгүй хоёр хоног явж ирээд миний ах Шинжээ:

— Ажил бүтэмжгүй боллоо! Хөгшин азарга айхавтар зальтай амьтан байна! гэв.

Би юу ч хэлсэнгүй. Гэвч энэ бол тахиас гарсан ухаан гэдэг нь ойлгомжтой байлаа. Профессоруудын хэн нэг нь миний ярьсан зүйлд эргэлзэж эхлэв. Үүнд нэг талаар миний уур хүрч, нөгөө талаар баяр хүрч байлаа.

Харин манай монгол эрдэмтэд огт шантраагүй юм. Тэд нисдэг тэрэгний тусламжтайгаар дөрвөн хүнийг уулын нөгөө талд аваачиж (манай аав, өвөг ах нарыг) орхиод, хоёр дахь хэсэг нь уулын наад талаас нь эрлээ эхэллээ. Тэр хоёр хэсэг үйл ажиллагаагаа зохицуулан зэрлэг сүргийг олоход хэцүү биш байлаа. Тахь сүргээ онцгой бартаатай хавцалд оруулан, өдөрт нуун амрааж, шөнө болохоор айх аюулгүй уулын хярд гарган идээшлүүлж байлаа (Адуу шөнө бэлчихдээ зөвхөн

өвс олж идэх биш, бас ус олж ундаалдаг. Учир нь шүүдэр унаж өвс норсон байдгийг чи мэдэх үү?).

Мэдээжийн хэрэг, тэд адууг олсон юм. Бүгд хүмүүс эргэж ирсний дараа миний ах Шинжээ: профессорууд адуун сүргийг үргээж цочоохгүйн тулд тун болгоомжтой ажиглалт хийсэн гэж ярьсан юм.

Тэнд адуун сүргийг бидний өөдөөс халз дайрч оруулахыг хичээсэн нэг залуу үрээ байсан. Энэ бол аюулаас өөрсдийгөө аврах цорын ганц зам гэдгийг тэр бээр ойлгосон бололтой. Гэвч бусад нь түүнийг дагахыг хүсэхгүй хий л урагшаа, хойшоо хуйларч давхилдаад байлаа. Адуунууд маш их сандарч тэвдсэн тул профессорууд тэднийг тайвшруулахын тулд түр тэндээс өөрсдөө зайлсан юм.

— Тэр залуу үрээг чамаас бусад нь анзаарсан уу? гэж би Шинжээгээс асуув.

— Хэрэв тэд адууны талаар ямар нэг мэдлэгтэй улс бол ажигласан л байх гэж ах хариулав.

Ямар ч байсан, одоо эрдэмтэд сүрэг дотор хэдэн азарга, хэдэн гүү байгааг л сайн мэдэх болсон. Тэдний сэтгэл маш их хөдөлсөн. Манай энд хэн нэгийгээ үлдээж, сүргийг харуулдуулах өөрөөр хэлбэл ажиглалт хийлгэхээр тогтсон байх. Бид түүнд туслах юм гэнэ.

— Баярт, чи дахиад морь унаж чадах болмогцоо манайд үлдсэн энэ хүнийг дагалдан үйлчилж, уулын хамгийн тохиромжтой замыг олж газарчлахаас гадна, зэрлэг адуун сүргийн байдлыг яаж ажиглахыг түүнд зааж өгөх хэрэгтэй гэж эцэг хэлэв.

— Мэдлээ, аав аа! гэж би хариулав.

Амьтан судлалын мэргэжил бүхий нэг залуу үлдэв. Тэр бээр энэ жил Улсын их сургууль төгсжээ. Түүний нэрийг Гарьд гэнэ.

Би түүнтэй ууланд гарч, яаж нуугдах, яаж чимээ анир гаргахгүй явах, нүхэнд унахгүйн тулд хэрхэн болгоомжлох, уулын хяраас адуу руу яаж ойртох зэргийг зааж үзүүлэн ууланд хамт явах бололцоотой байсан зуны сар хэдийнээ дууслаа. Би түүнд өөрийнхөө юу чаддаг бүхнийг зааж үзүүлэв. Харин тэр бээр надад зэрлэг адууны талаар шинжлэх ухааны өчнөөн төчнөөн сонин зүйл ярьж өгөв. Зэрлэг адууны талаар надаас үнэхээр илүү их зүйл мэдэж байлаа. Тэр бээр надад зэрлэг адууны түүх, янз бүрийн амьтны хүрээлэнд үлдсэн хэд хэдэн янзын зэрлэг морьдын тухай, нэг байранд хамт оруулбал зэрлэг азарга гэрийн сурамгай морийг алж болох тохиолдлын тухай хүртэл ярьж өгсөн болно. Иймд би танай Уэльст байдаг дархан цаазтай амьтан

нутагшуулах байр уудам зайтай байх! гэж найдаж байна. Эс тийм аваас, тахь чиний Давжааг гомдоож мэдэх юм шүү!

Гарьд бид хоёр зэрлэг адууг айлгахгүйн тулд сүрхий болгоомжтой ажигладаг байсан. Гэвч би түүнд тахийг зааж өгөөгүй. Бидний ойртож очихыг тахь ямагт тааварлан мэдэж, адуунуудаа хазах, түлхэх зэргээр холдож зайлахыг шаарддаг байлаа. Хэрэв хөгшин азарга адуун сүргээ тахийн хурц нүд, соргог чих, үнэрч хамарт даатгахыг зөвшөөрлөө ч адуу сүрэг нь тахийн эрхшээлийг дагадаггүй байлаа. Бусад талаар хөгшин азарга сүргийн бүрэн эзэн нь байсан бөгөөд бусад азаргануудын тусламжтайгаар тахийг дийлэх чадалтай хэвээр байлаа.

Ийм байдалтайгаар би зэрлэг адуун сүргийг орхиж, сургуульдаа явах болов. Миний эзгүй хойгуур юу болсон тухай би ярихаа больё, зуны амралтаараа дахиад хөдөө гарч ирэхэд юу болж байсныг өгүүлье!

Тэгэх нь ээ таван профессор ирчхээд хоёр азарга үрээ, хоёр байдас бүгд дөрвөн адуу барьж аваачихаар бэлтгэж байлаа.

Миний танил, амьтан судлалын мэргэжилтэн Гарьдтай би уулзмагц түүнд маш ууртайгаар ингэж хэлэв: «Нэг ч адуу эндээс барьж аваачихгүй гэж чи амласан биз дээ?»

Бид барьж авахаас өөр аргагүй боллоо! гэж тэр бээр гунигтай өгүүлэв.

— Яагаад? Юунд тэр вэ? гэж би асуув.

Өөр хэд хэдэн зэрлэг адуун сүрэгтэй болж болох эсэхийг бид туршиж үзэх хэрэгтэй байна гэж тэр бээр хэлэв.

Харин тэгвэл та, амьтны хүрээлэнд нэг адуу явуулахгүй. Амьтны хүрээлэнд очсон бүх зэрлэг адууны зан араншин нь өөрчлөгдөөд шал өөр болдог гэсэн биз дээ? Тэгвэл яах гэж манай зэрлэг адууг барьж амьтны хүрээлэнд илгээх гээд байгаа юм бэ?

Бид эднийг амьтны хүрээлэнд явуулах гэж байгаа хэрэг биш гэж Гарьд тайлбарлав. Энэ завсар өгүүлэхэд: Гарьд бол маш томоотой, тэсвэртэй хүн. Манайд ирэх хүртлээ огт морь унаж үзээгүй монгол. (сонин хэрэг шүү! Түүний эцэг нь уурхайчин байсан юм). Тэр бээр цааш нь үргэлжлүүлэн ярьсан нь: Бид адуу нэг бүрийг манайхтай газар нутгийн нөхцөл байдлаар төстэй, зэрлэг амьтад нутагшуулах дархан цаазтай газарт явуулна. Нэг азарга үрээг Арал тэнгис (үнэн хэрэгтээ энэ бол томоохон нуур) дэх оросын дархалсан нутагт, нэг байдсыг Герман дахь дархалсан нутагт, бас нэг байдсыг Прагад тус тус явуулна.

Хамгийн сүүлчийн нэг азарга үрээ Английн Уэльст байгуулсан зэрлэг амьтдын нутагших дархан цаазтай газарт очих болно.

— Энэ чинь тэгвэл адуу болгон ганцаараа амьдарна гэсэн үг байна...

— Зөвхөн эхний үед тийм. Хожим бид зэрлэг хань нөхдийг нь явуулах болно. Одоо бид энэ явуулсан хэд маань орчныхоо нөхцөлд хэрхэн идээших нь вэ гэдгийг л туршиж үзэх гээд байгаа юм. Бидний зорилго бол тэднийг амьтны хүрээлэнгийн адуунаас арай өөр, зэрлэг амьдралыг нь алдагдуулахгүй өсгөхөд оршино. За, тэгэхээр Баярт минь, бид тэдний төлөө чадах бүхнээ хийж байгаа нь ойлгомжтой байна уу.

Гэхдээ тэдний өссөн төрсөн өлгий нутаг нь энэ шүү дээ. Ер нь адуу бол өссөн төрсөн нутагтаа амьдрах дуртай. Манай монгол адуу ч тийм. Тэд өлгий нутгаасаа холдохыг хүсэхгүй. Тийм ч учраас энэ уулнаас холдож чадахгүй байгаа юм. Тэд нутгаа санахаар барахгүй, үхэж ч болно биз дээ.

— Болзошгүй. Гэхдээ бидний оролдлого бол зэрлэг адууны үр үндсийг таслалгүй байхын л төлөө юм шүү дээ.

Миний танил Гарьд болон профессорууд зэрлэг адууны үр үндсийг сэргээх талаар чадах бүхнээ хийж байна гэдгийг би ойлгосон учир тэдэнтэй цаашид маргахыг болив. Харин тэдний барих азарга үрээнүүдийн дотор тахь орчих бий гэхээс л би ганц айж байлаа. Уг нь тахь айхавтар ухаантай болохоор тэдэнд арай ч баригдахгүй болов уу гэж итгэнэ. Энэ бүхэн хэдий үнэн боловч тахь баригдаж болох бас нэг шалтгаан байгааг би тооцож үзсэнгүй.

Тэд адууг алсаас тууж нарийхан хавцлын мухарт шахаад нойрны эмтэй сумаар дөрвөн адуугаа буудаж барих арга боловсруулсан байлаа. Эхлээд аав манайхны ердийн морь барих аргаар тэр дөрвийг уургалж барих санал тавьсан юм. Уурга гэдэг бол урт нарийн модны үзүүрт уяа гогцоолдож бэхэлснийг нэрлэнэ. Барих морио унасан мориороо хөөж гүйцмэгц тэрхүү гогцоог нөгөө морины хүзүүнд шидэж оруулан барина. Ингэж морь барих аргад биднийг хүүхэд ахуй цагаас сургана. Гэвч профессорууд нойрсуулагч эмтэй сумаар буудаж барих нь аюулгүй, найдвартай, хурднаас гадна бусад адуунуудыг төдий л их айлгахгүй гэж үзэв. Адууг ангалд хөөж оруулахын тулд 20 гаруй адуучин хэрэгтэй байлаа.

За тэгээд бид ажилдаа гарлаа. Бидний хамт дөрвөн профессор явснаас гадна манай хоёр авга ах нойрсуулагч эмтэй сумаар цэнэглэсэн буу үүрч явлаа.

Зэрлэг адуунууд манай нутгийн нэг хамгийн урт, өргөн хоолойтой зэрэгцэн орших бяцхан хавцалд байгаа гэдгийг бид сайн мэдэж байлаа. Энэ хавцал нь нөгөө хоолойтой огтлолцсон газартаа нэлээд өргөн бөгөөд өгсөх тутам улам нарийссаар эргэн тойрон элгэн улаан хадаар хүрээлэгдсэн мухарт тулна. Энэ бол байгалийн барьсан гайхамшигтай сайхан хашаа. Хамгийн гол нь зэрлэг адуунуудыг тэр хоолой руу оруулаад алдчихгүй байх нь чухал байлаа.

— Баярт, чи энэ уулын замыг хамгийн сайн мэднэ. Тийм учраас эхний хэсэгтэй хамт яв! Харин чи авга ах Равданыхаа үгийг сайн сонсож яваарай! Мэдэв үү? гэж аав надад хэлэв.

— Мэдлээ! гэж би хариулав.

— Тэдэнд аль болохоор сайн туслахыг бод! Цаадуул чинь хамаагүй хөөж зүрхийг нь хөөргөөд хаяж мэдэх улс шүү. Миний бодоход, манай адуучид зэрлэг адууг болчимгүй айлгаснаас ямар хор учрахыг төдий л сайн ухамсарч мэдээгүй явж чадах улс! гэж аав сэмхэн хэлэв.

Мэдлээ ааваа! гэж би хариулав. Харин энэ мөчид миний хамаг ухаан бодлыг ганцхан тахь л эзэлж байлаа.

— Тэдэнд хамгийн шилдэг залуу үрээ, байдас хэрэгтэй юм гэнэ. Аль нь илүү болохыг чи л хэлж өгч тусал!

— «За, ааваа!» гэж би хариулаагүйгээр барахгүй, би ямар ч байсан тахийг зааж өгөхгүй гэж дотроо бодож явлаа.

Өргөн хоолойд бид шөнө болж байхад ирэв. Зэрлэг адууг гэнэдүүлэн дайрахын тулд эндээс өглөө явна гэж би мэдэж байлаа. Харин Гарьд; Бид үд хүртэл эндээ хүлээх хэрэгтэй гэв.

— Шөнөжин идшилсэн адуу яг жин үдэд хэвтэж амардаг юм! гэж тэр бээр хэзээний тайван байдлаараа тайлбарлан өгүүлэв.

Бид хэдэн жижиг хэсэгт хуваагдав. Би, Гарьд, авга ах Равдан нарын зэрэг хүмүүстэй хамт явав. Равдан ах нойрны эмтэй сумаар хоёр азарга үрээг онож харвах, бас өөр нэг ах хоёр залуу байдсыг онох үүрэгтэй явлаа. Гарьд, авга ах Равданд ямар үрээ буудахыг зааж өгөх ёстой байв.

Нойрны эмтэй сум адууг онохоороо яах хэрэг вэ? гэж хоолой гатлаад хавцал руу орж явах замдаа би Гарьдаас асуув. Би тахийн

талаар санаа зовж эхлэв.

— Хэдэн минутын дараа тэр адуу унана гэж Гарьд хариулав.

— Их өвддөг бол уу?

— Огт өвдөхгүй.

— Сум нь яадаг юм бэ?

— Тэр суманд оногдсон адуу ойролцоогоор хоёр цаг унтана.

Баярт, битгий сэтгэл зов! Бид бол тэдэнд ямар нэг хор хүргэхгүй, харин тэднийг хамгаалах, үржүүлэх зорилготой улс шүү дээ.

— Яамай! гэж дуртай дургүй зөвшөөрөв. Гэхдээ надад энэ арга нэг л таалагдахгүй байлаа.

Бид маш болгоомжтой ахин дөхөж явсан тул хавцал хүртэл зөндөө удаан явав. Нэгдүгээр хэсэгт бид арвуулаа байсан ба бусад нь биднээс нэлээд зайтай хойноос дагаж явлаа. Нэг ёсондоо тэд бол адууг өргөн хоолой руу оруулахгүй замыг нь боож явсан санаатай юм. Хавцал өөд өгсөж яваа зэрлэг адууг бидний олж харах үед тахь хэдийнээ бидний чимээг сонссон ч, сэвдээ авсан болох нь тодорхой байлаа.

— Тэдэнд аль болохоор ил харагдахын тулд бид газрынхаа өндрийг барьж явах нь зүйтэй гэж авга ах Равдан надад хэлэв. Энэ нь бас тийм ч амар биш гэдгийг би мэдэж байлаа. Хэдийгээр бид үдийн алдад хөдөлсөн боловч зөвхөн оройн шингэх нарнаар зэрлэг адууг сая нэг гүйцэж, хавцлаас гарах замыг нь бүслэн хаав.

Харав уу, тэнд тахь явна! гэж би бидэрт хүрнийхээ баруун чихэнд шивнэв.

Тахь адуугаа атгын чинээн болтол нь хурааж, мал харагч нохой шиг ууртайгаар тойрон хатирна. Тэр бээр ууртайгаар толгойгоо сэгсчин, сүүлээ шарвана.

Бид жаахан ойртох хэрэгтэй. Нойрсуулагч сум зуун метрээс цааш тусахгүй гэж Гарьд хэлэв.

Зуун метр ий? Бид хэзээ ч тэдэнд тийм ойрхон очиж чадахгүй гэж би дуу алдав.

Очих л болно доо! гэж Гарьд хэлэв.

Энэ мөчид зэрлэг адуунууд урт эгнээ болон унага би гүүнүүдээ дундаа хийж хатирна (зэрлэг адуу бол голцуу цувж явдаг). Азарганууд нь нэг урд нь гарч, нэг хойно нь орж явна. Тахь бүх сүргээ тойрон хурдална. Тэд хавцлын эх рүү улам улам гүн орно. Хавцлын мухарт

тулж, хаашаа ч гарах газаргүй болоход нь л ойртож чадна гэж бид итгэж явлаа.

Одоо аяар! гэж авга ах Равдан тушаахад бид мориныхоо амыг татаж болгоомжлон гэлдрэв.

Бидэрт, зэрлэг адуунаас хэзээний айдаг болохоор, нэг л тайван биш, үргэж хулмалзаж байв.

Тахь адуугаа энэ хадан хавцал руу дагуулж орсноороо айхавтар том алдаа хийлээ гэж би бодож явав. Зэрлэг сүрэг биднээс таван зуун метрийн зайтай болсон бөгөөд бид аажим аажмаар улам ойртож байлаа. Хэдхэн мөчийн дараа тэд занганд орно гэдгийг бид ойлгож байлаа. Эхлээд би сэтгэл зовохгүй байлаа. Яагаад гэхээр гарах ямар ч нүх сүв байхгүй гэдэгт итгэж байв. Харин тэр тохойг тойроод харахад сүрэг ор сураггүй алга болсон байв. Тулж очоод нарийвчлан ажиглавал хавцлын мухарт холоос хүн анзаарахын аргагүй нэг нарийхан завсар байжээ.

— Араараа ганц тавиуллаа шүү! гэж авга ах үглэв. Түүнд бол ханиад, надад бол инээд байлаа.

— Тэд хаа холддог юм бэ, хурдан явцгаая! гэж Гарьд хэлэв.

Бид цогиулж гарлаа. Тэр нарийхан завсрыг гэтэлсний дараа нөгөө сүргээ дахин олж харав. Нэлээд уужим хөндийд тэд манаргаж явлаа. Тэдний хойноос мориныхоо хар эрчээр хурдалж явах зуур:

— Алиныг нь эхлээд буудах юм бэ? гэж авга ах хашхиран асуув.

— Тэр үрээнүүдийн аль залуугийн нь бууд! Аль нь ч яах вэ! гэж Гарьд хэлэв.

Зэрлэг адуунууд бас аль байдаг хурдаараа зугтана. Залуу үрээнүүд нь хамгийн түрүүнд, дунд нь гүү, унаганууд нь, хамгийн сүүлд хөгшин азарганууд нь давхиж байлаа. Харин тахь сүргээ тууж яваа байртай, хазаж хөөхөөс гадна зарим хоцорсны хойноос нь түлхэж байгаа харагдав. Эхлээд зэрлэг адуу бидэнд гүйцэгдэх шинжгүй байснаар барахгүй тэдний хөлөөр боссон тоос эргэн тойронд манараад маш сүртэй байлаа. Бид аажимдаа тэднийг гүйцэх төлөвтэй болов. Учир нь зарим унаганууд нь цуцаж эхлэв.

Хамгийн сул биетэй байсан нэг унага хоцорч эхлэв. Эх нь түүндээ хоргодож, буцаж ухарч байснаас гадна түүнийгээ байн байн янцгаан дуудна. Эхлээд тахь тэр гүүг хоцрохыг хэрхэвч зөвшөөрөхгүй түүн дээр давхцаж ирэнгүүт хүчтэй өшиглөж, зугтахыг шаардана. Бас унаган дээр нь хүрч очоод хошуугаараа түлхэнэ. Гэвч унага босож хэд

харайгаад таварцаглаж унав. Тахь түүнийг орхисонгүй, хэзээ босохыг нь нэг хэсэг хүлээв. Дараа нь хөл дээр нь босгохыг оролдон, түлхэж эхлэв. Унага тун их туйлджээ. Тэр босох болгондоо таварцаглан унана. Тэгэхэд нь унаганы ар сэрвэн дээрээс нь шүдээрээ зууж, сэгсрэн босгоод урагш нь чирэв. Адуу мал ингэж байхыг би хэзээ ч үзээгүй учир тун их гайхав. Тэр унага түр зуур сэргэж, хэд сүрхий харайгаад унав. Дахиад огт босож чадсангүй. Энэ үед бид адуунд гурван зуун метр орчим ойртож очив. Тахь зугтахын оронд гэнэт эргэж бидний зүг толгойгоо тухайлган хурдалж ирэв. Бусдыгаа зугтаалгахын тулд өөрөө бидэн рүү дайрсан нь энэ байжээ. Энэхүү эрэлхэг зоригоосоо болж тэр баларсан юм даа. Манай авга ах мориныхоо амыг татан зогсоож, тахийг бүүр ойртуулж байгаад тухтайхан шагайж буудав.

Нойрсуулагч сум түүнийг оноход нэг зог туссан боловч, зогсолтгүй дайрсан хэвээр байлаа. Авга ахын морийг унатал дайраад хүзүүг нь тас хазах нь гэж би бодож байтал биднээс хориодхон метрийн зайд ирээд гэнэт таварцаглан тэрийж унав.

— Битгий зогсоорой! Бид дахиад нэгийг барих ёстой... гэж Гарьд манай авга ахад хашхиран өгүүлэв. Учир нь бүх хүмүүс тахийн явдлыг сонирхон гайхаж байх хооронд бусад адуу нь зугтаж амжив.

Тэд нөгөө сүргийн хойноос хөөцөлдөн арилахад би үлдэн, мориноосоо буун харайж;

— Босоорой! Аль вэ, бушуул! гэж хашхирав. Тэгэхдээ бас нэлээд холоос шүү!

Тэр бээр хамаг бие нь тоос шороо болчихсон, хяхтнан урт урт амьсгаалж, хойд хоёр хөлөөрөө газар самарч, босохыг оролдон, хоёр зэрлэг нүд нь бүлтэлзэнэ. Шүдээ үе үе тачигнуулан хавирахад нь би айж улам холдоно.

— Аль вэ, түргэлээч! Одоохондоо чамд зугтах бололцоо байна гэж би ууртай хашхирав.

Тэр бээр бүхий л чадлаараа мэрийсэн боловч хойд хоёр хөл нь түүнд захирагдаж өгсөнгүй. Түүнийг айлгаж, үргээхийн тулд би түүн рүү хэсэг шавар чулуудав. Тахь толгойгоо өндийлгөн, дахиж нэг удаа босох оролдлого хийв. Гэвч түүний хүзүү нь сульдаж, хөл нь тэрийж, нүд нь анилдаад ухаан алдав.

Манай нагац эгч намайг одоо захидлаа дуусга, адууны тухай гунигтай, урт захиа бичихээс өөр ажилгүй улс гэж биднийг бодоо юу гэж загнаж байна. Би энэ захидлыг гунигтай болгохыг огтхон ч

хүсээгүй билээ. Энд би ингэж дэлгэрэнгүй бичдэгийн учир бол ямар зоригтой, гайхамшигтай морь танай нугад нутагших болсон ба чиний Пийп хэмээх Давжаа ямар аюултай, зэрлэг найзтай болсныг чи ойлгох нь хэрэгтэй гэж бодсон юм.

Тэр өдөр барьсан дөрвөн адууны хөлийг чөдөрлөж, нисдэг тэргэнд ачиж аваачсан ба үлдсэн сүргийг байнга харуулдаж байх болгов. Ийнхүү би тэр тахийг ор сураггүй алдав. Түүнээс бүүр сүүлд танай өвөөг энд иртэл би тэр тахь хаа байгаа, юу болж байгааг огт мэдэхгүй байлаа. Танай өвөө ирээд тэр залуу үрээ надтай хамт Уэльст очно гэж хэлэв.

Тахийг барьснаас хойш хэдийнээ хоёр сарын хугацаа өнгөрлөө. Өнгөрсөн хугацаанд тэрхүү барьж авсан хэдэн адууг тайвшруулж дасгахын тулд манай нийслэл Улаанбаатараас холгүй орших алсуур нь торлож хүрээлсэн тусгай газарт идээшлүүлж байгаа гэнэ.

Дараа нь адуунуудыг нутагших газарт нь явуулж болно гэж эрдэмтэд үзээд, амласан үрээг авч болно гэж танай өвөөд мэдэгджээ. Тэр бээр эхэлж Улаанбаатарт ирээд дараа нь манайхаар зочилсон.

— Ямар ч байсан наашаа ирж, тэр үрээний тухай чамаас лавлаж авах нь зүйтэй гэж би бодлоо. Ер нь зэрлэг адуунууд нутгийнхаа ууланд амьдрахдаа ямар шүү зан авиртай байдаг тухай өөрийн мэддэг зүйлийг надад хэлж өгөөч! гэж танай өвөө хүсэв.

Энэ явдал надад тун таалагдсан. Тахь маань найдвартай гарт орж дээ гэж би тэгэхэд л ойлгосон. Тэгээд бид танай өвөөтэй ууланд гарч, манай нутгийн зэрлэг адуу байгалийн ямар шуу нөхцөлд амьдардгийг үзүүлсэн. Өвөө чинь надаас мянга түмэн асуулт асуусан. Учир нь түүнтэй уулзсан хүн бүхэн намайг тэр зэрлэг адууны хойноос сар жилээр хөөцөлдөн дагадаг байсан гэж ярьжээ.

Би бас өвөөгөөс чинь танай нутгийн уул, ус, нуга шанд, цаг агаарын тухай болон тахийг ямар шүү нөхцөлд нутагшуулах санаатай зэргийг асууж сонирхох гэж бодсон боловч манай ажаа (бидний яриаг орчуулсан) ийм асуулт тавих нь онц биш гэж намайг хориглож болиулав.

Гэвч танай өвөө надад, Китти, чиний тухай болон чиний хайртай Пийп хэмээх давжаа байдасны тухай ярьж өгсөн. Иймээс хэрэв зав олдвол надад захиа бичиж, танай нутгийн нуга шандын тухай, ер нь байгалийн байдал ямар вэ, цас ордог уу, хүн амьтан олонтой юу, тахийг аваачаад яах гэж байна? Тахь оргож гүйх бололцоо бий юү? Ер нь юм

бүхний тухай өгүүлбэл тун сонин байна. Юуны өмнө тахийн найз болох тэр байдасны тухай бичээрэй!

Үнэнээ хэлэхэд, би танай өвөөгөөс ганцхан асуулт асууж амжсан.

— Танай тэр бяцхан байдас Пийп чинь тэгээд зэрлэг үү, гэрийн мал уу? гэхэд танай өвөө шоолонгуй инээж хариулсан нь:

— Мэдээжийн хэрэг, Пийп гэрийн мал. Китти л хаа явна, түүнийг нохой шиг дагаад салахгүй гэв. Чиний бяцхан байдас гэрийн мал гэдгийг ингэж анх мэдсэн юм. Ганцхан үүнд л би их санаа зовж байна.

— Бяцхан байдас маань гэрийн мал. Иймээс ч тэр маань (танай эндээс байдас аваачтал) тахийг үлгэрлэн дагуулж, манай дархан цаазтай газарт нутагшуулж өгөх болов уу? гэж бид найдаж байна гэж танай өвөө яриагаа үргэлжлүүлсэн юм.

— Тахь бол мах цуснаасаа зэрлэг. Хэзээ ч тэр өөр газар идээшиж чадахгүй. Харин танай бяцхан байдсыг айлгаж, гомдоож магад гэж намайг хэлэхэд танай өвөө намайг аймхай байна гэж шоолоод:

— Манай бяцхан байдас Пийп өөрийн гоо үзэсгэлэн, ялдам зангаар тахийн сэтгэлийг уярааж чадах байх гэж би бодож байна. Тахь түүнийг гомдоохгүй гэж найдаж байна гэв.

Би ч гэсэн бас найдъя. Үнэнээ хэлэхэд, танай өвөө манайханд их таалагдсан. Түүний буурал халимаг, ширвээ сахал, үргэлж инээмсэглэх нүд нь хүнд гэм хор үл хүргэгч, сайхан санаатай ойн хүрэн баавгайг бидэнд санагдуулав.

Захиагаа дуусгахын өмнө дахин хүсэхэд, хэрэв чамд зав олдвол өөрийнхөө тухай, Уэльс нутгийн нуга шандын тухай, чиний бяцхан хүлгийн тухай, юуны өмнө тахь очсоноос хойш юу болсон тухай тодорхой бичээрэй! Чи англи хэлээр бичихэд болно. Манай Сэр-Од ажаа надад орчуулаад өгнө (энэ удаа биднийг ууланд явахад ажаа хамт явалцсан).

Чамаас захиа хүлээж, ахан дүү, анд нөхрийн мэндчилгээ дэвшүүлсэн чиний найз

Мөнхийн Баярт.

Жич: Би өвөөгөөр чинь нэг өвлийн монгол малгай чамд бэлэглэж явуулав. Чамд их таалагдана гэж тэр хэлсэн. Чамд таарах бол уу гэж найдаж байна. Тахь нохойд их өшөөтэй. Ямар нэг нохой түүнд ойртож очвол хэмх өшиглөнө. Хэрэв танайх нохойтой бол тун болгоомжтой байх хэрэгтэй. Чи өөрийнхөө бяцхан хавыг

түүнээс холхон шиг байлгаж үзээрэй! Чиний бяцхан байдасны
талаар, яагаад ч юм бэ, би нэг л сэтгэл зовоод болохгүй байна.

Чиний найз

Баярт.

Эрхэм найз, Баярт аа!

Чиний бичсэн гойд сонин бөгөөд урт захидлуудыг хүлээн авч маш их баярлав. Ялангуяа сүүлчийн чинь захидал тун сонирхолтой бөгөөд уншиж дуусан дуустал түүнээс огт салахын аргагүй байлаа. Шошийн буурцаг цэвэрлэхэд нь би Эванс ахайд туслах ёстой байсан юм. Тэгээд дөнгөж, хоёрхон шошийн буурцаг цэвэрлэж, ганц төмс арилгаад, түүнээ уншиж суутал оройн хоол идсэний дараа унш! гээд чиний захидлыг гараас булааж авав. Тахийн төлөө санаа зовсноос болоод хоол идэх дур ч алга болов. Гэтэл Эванс ахай намайг буурцаг, төмс, нухаш зэргийг заавал дуусгаж идээд, сав суулга угаа! гэж шаардав. Түүний дараагаар сая захидлыг эргүүлж өгөөд зөв сууж, тухтай унш! гэв. Тэгж уншвал надад улам таалагдах юм гэнэ дээ.

Би өөрийгөө төдий л тайван хүн биш гэж боддог. Яагаад гэхээр Эванс авгай, манай өвөө хоёр, хэдийгээр өөрт минь тун тайван байгаа санагдсан чиг л чи тайван биш байна гэж хэлээд байдаг юм. Чиний бүх асуудлыг хариулахад надад нэлээд олон жил хэрэгтэй байх. Хамгийн эхний асуудлыг одоо ч хариулж чадах байна. Энэ юү гэвэл: Тахь одоогоор манай энд хүрэлцэн ирээгүй байна. Түүнийг карантин дээр байлгаж, малын ямар нэг халдварт өвчин байгаа эсэхийг нь шалгаж байгаа юм байх, үнэнээ хэлэхэд би бяцхан байдасныхаа төлөө тун их сэтгэл зовж байна. Энэ тухай өвөөд хэлэхээр шоолох юм.



Баярт, би чамд нэг зүйлийг амлаж чадна. Энэ юү гэвэл; хэдийгээр тахийн өссөн төрсөн уул, уулс нь алс хол байгаа ч гэсэн бид түүнийг энд тун тухлаг тохитой байлгаж чадна. Танай нутгийн сүрлэг уулсыг бодвол эндхийн юм бүхэн нь арай л жол, уйтгартай санагдаж болох юм. Би чамд өөрийнхөө гэр, орон, дархан цаазтай газрын тухай ярьж эхлэхэд: зэрлэг морьдын тулалдаан, хүний хөл хүрээгүй үзэсгэлэнт өндөр уулсын тухай юу ч олж дуулахгүй байх гэж сэтгэл зовох юм.

Би өөрийн өвөө, түүний гэр ахуйн туслагч Эванс ахай нарын хамт манай улсын нэгэн дархан цаазтай амьтан нутагшуулах газарт оршин суудаг юм.

Миний ээж дөрвөн жилийн өмнө нас барсан. Миний эцэг бол геологийн мэргэжилтэй хүн учир Перс, Кувейт (тэнд манай ээж нас барсан) гэх мэтийн оронд ажиллах шаардлагатай байдаг. Ирэх жил манай аав бүрмөсөн эргэж ирнэ. Тэр болтол би өвөөтэйгөө хамт байх болно. Манай өвөө бол зоологийн профессор, зэрлэг амьтан нутагшуулах үндэсний дархан цаазтай газрын эрхлэгчээр ажилладаг. Энэ бол үр үндэс нь тасарч болзошгүй ан амьтанд тусгайлан зориулж байгуулсан цоо шинэ газар. Одоогоор энд төдий л олон амьтан байхгүй.

Манай дархан цаазтай газар Хар ууланд орших бөгөөд гүвээ толгод, бэлчээрийн талбай бүхий өргөн уудам нутагтай. Түүний эргэн тойронд хот, тосгон байтугай, олигтойхон зам ч байхгүй. Манайд очдог цорын ганц замтай. Дархан цаазтай газрын гол зорилго нь адгуусан амьтдын байгалийн дадал заншил, зэрлэг амьдралын нөхцөлийг алдагдуулахгүйд оршино. Ийм учраас тус газрын нутаг дэвсгэр дээр хашаа, хороо огт байхгүй. Харин манайхаас хорин км-ийн зайтай нэг цахилгаанжуулсан хашаа бий. Тэр нь ан амьтныг энэ нутгаас гарч гол зам руу очих бололцоог хаах зорилготой юм. Түүнээс бусад бүх талаараа бид мөрөн голоор хашигдсан нутагт сууж байна. Эдгээр голуудын нэг нь уулын нөгөө хаяагаар урсдаг юм. Иймээс бүхэл бүтэн уул нуруу, бэлчээр нутаг цөм ганцхан тахийн эрх мэдэлд байх болно. Хэрэв хэдэн зэрлэг янгир, дорго, минж, зарим нэг жижиг амьтдыг эс тооцвол манай энд тахиас өөр юү байх вэ? Одоохондоо ердөө л байгаа амьтад нь энэ!

Дархан цаазтай газрын гол дунд нь манай чулуун байшин оршдог. Өвөөгийн ажлын өрөөний цонхыг маш том хийснээс гадна ажиглалтад зориулсан олон тооны яндан дуран, кино аппарат байрлуулжээ. Миний сургууль манайхаас хорин милийн зайтай орших Крикхоуэлд байдаг. Өглөө бүр өвөө намайг 10 милийн тэртээ орших гол зам хүртэл машинаараа хүргэж өгдөг бөгөөд тэндээс би автобусанд сууж явдаг. Өвөөгийн эзгүй үед шуудан хүргэгч ноён Жонс гуай намайг ачааны машинаараа хүргэж өгдөг. Заримдаа их шуургатай өдөр сургуульдаа огт явдаггүй. Хэдийгээр хүмүүс биднийг эзгүй буйд газар амьдардаг гэж үздэг ч гэсэн танай уулыг бодвол энд тийм ч зэлүүд биш. Хүмүүс надаас: «Китти, чи энд уйддаггүй? Чи энд цорын ганцаар шүү дээ» гэж дандаа асууж байдаг юм. Гэвч энэ нутаг надад тун их таалагддаг. Би эндээс хэзээ ч, хаашаа ч явахгүй.

Өвөө, Эванс ахай хоёр надад маш их хайртай. Тэд намайг хэтэрхий эрхлүүлээд байх шиг надад санагддаг. Өөрсдөө бол надад их шаардлагатай ханддаг гэж боддог байх. Тэд үргэлж маргалдаж байдаг юм. Гэхдээ энэ нь ааш араншны зөрөө маргаан биш. Харин зүгээр зуршил болчихсон юм.

Эванс ахай ямар нэг зүйл дээр өвөөг зэмлэхэд өвөө:

— Энэ авгай намайг нэг үхүүлж амарна шүү! гэж үглэх дуртай. Бас өвөө ямар нэг зүйл дээр Эванс ахайг зэмлэхэд, Эванс ахай: — Энэ өвгөн, юмны буруу зөвийг ялгаж байсан удаа огт үгүй! гэж яншина.

Дараа нь тэд бие биедээ үргэлж «утгагүй юм» гэж хэлэх дуртай. Тэдний маргалдахдаа хэрэглэдэг гол үг нь «утгагүй юм» гэдэг үг. Би энэ хоёрт хоёуланд нь хайртай. Энэ хоёрын хэн нь ч чамгүйгээр амьдарч чадахгүй гэж шуудан зөөгч ноён Жонс ярьдаг юм. Ийм учраас тэд хоёулаа надад хатуу шаардлагатай байх, намайг тайвшруулах (яагаад ингэдгийг нь би ойлгодоггүй юм) дуртай. Энэ бүхэн бол миний төлөө тавьж байгаа тэдний халамж гэдгийг би сайн мэдэж байна.

Харин би тэднийг халамжлах хэрэгтэй гэдгийг бас ойлгодог юм. Манай өвөө юманд айхавтар салан палан. Тэр бээр ном, газрын зураг, картын сан, гэрэл зураг юу ч байсан хэрэглэж дуусаад л шал, сандал, ширээ, шат аль тааралдсан газраа орхичихно. Дараа нь би тэр болгоныг нь цуглуулж түүний ажлын өрөөнд оруулж тавина. Бас тэгээд үүнийг хийж явахад харвал үглэнэ.

Эванс ахайн хувьд гэвэл хараа муутай. Ер нь тун муу даа. Тэр авгай өөрийнхөө өмнөх өчүүхэн жижиг зайд байгаа юмыг л харна. Маш зузаан шил зүүнэ. Ийм учраас тэр авгайн замд тааралдах ширээ, сандал (өвөөгийн номыг хүртэл) зэргийг үргэлж би зайлуулж тавих хэрэг болдог. Тэгэхгүй бол тээглэж уначих гээд болдоггүй юм. Мөн гал тогооны өрөөнд байдаг халбага, таваг, хутга, сэрээ, хоолны цагаан сав, нэхмэлийн утас зэрэг бүх зүйлийг нүдэнд нь харагдахуйц газарт ил тавих ажил надад ноогдоно. Хэрэв аль нэг нь байдаг газартаа эс байвал хэзээ ч түүнийг олохгүй. Миний бодоход, түүний нүдний өмнө ямар нэг кино хальс шиг юм харагддаг байх. Тэр бээр үргэлж тоос сорогч авч явдаг. Яагаад гэвэл бохирдсон цонх угааж байгаа мэт, өмнөх агаараа үргэлж соруулж явдаг юм.

Чиний бодоход, би их азтай байгаа биз дээ. Энэ бүхний тухай яагаад бичиж байна вэ гэхээр, тахь ямар шүү айлд очоо вэ гэдгийг чи бас мэдэх хэрэгтэй.

Хамгийн эгзэгтэй асуудал бол миний хайртай Давжаа байдасны тухай асуудал юм. Яагаад гэвэл тахитай тэр бээр нөхөрлөх ёстой болж байна. Түүний төлөө сэтгэл зовохгүй байна гэж хэлэхийг би хүсэж байна. Гэхдээ энэ үг бол үнэн байдалд нийцэхгүй юм. Миний Давжаа бол хүний зөнгөөр, итгэлтэй сайхан зантай амьтан. Тэгэхээр яаж энэ маань тэр зэрлэг азаргатай хамт байх болж байна? Миний санаанд огт багтахгүй байна.

Нэг жилийн өмнө өвөө анх Пийпийг гэртээ авчрахдаа энэ маань Монголоос олодох байх гэж найдаж байгаа Азийн зэрлэг азарганы хань

болох юм гэж хэлсэн билээ. Гэвч Пийп надад туйлын номхон бөгөөд эелдэг зантай амьтан санагдсан учир би өвөөгөөс яагаад ийм номхон дөлгөөн байдас тийм зэрлэг азарганы хань болдог билээ? гэж асуусан юм.

— Яагаад гэхээр тэр зэрлэг азарганд бид өөрсдийгөө түүний найз гэдгийг ойлгуулах хэрэгтэй байна. Тэр бээр бидэнд итгэх ёстой. Бид түүний амьдралд аюул занал учруулахгүйгээр үл барам, харин тусална. Адуу малтай хүний хэлээр ярилцан тохирч болохгүй биз дээ? Түүнийг манай эндхийн уул усанд дасгахын тулд бидэнд ойр дотно дассан, бидэн дээр өөрөө хүрээд ирдэг, хоёулаа хамт байхдаа уулын хажууд биднийг үзмэгц зугтаад явчихгүй, ухаалаг бөгөөд ааш зан сайтай хань олж өгөхөөс өөр ямар сайн арга байна вэ.

— Монголоос зэрлэг адуу олдохыг та яаж мэдэж байгаа юм бэ? Тэд чинь аль хэдийнээ устаж арилсан биш үү? гэж би асуув (энэ бол нэг жилийн өмнөх хэрэг).

— Эрт орой хэзээ нэгэн цагт зэрлэг адуун сүрэг олдоно гэдэгт би бат итгэж байна. Хорь гаруй адуу бүхий нэгэн сүргийг хэрэв олж чадвал надад нэг азарга үрээ өгнө гэж Монголын Шинжлэх Ухааны Академид ажилтай анд нөхөд маань надад ам өгсөн юм.

— Дараа нь тэгээд яах юм бэ, Пийп бүхэл насаараа тэр зэрлэг адуутай хамт байх хэрэг үү?

— Үгүй. Тэр зэрлэг бидэнд итгэж дастал хамт байх болно. Тэр цагт бид монголоос бас нэг зэрлэг байдас олж ирнэ. Тэгээд л чи Пийпийгээ буцааж авна.

— Тэр бээр даанч хүний зөнгөөр номхон амьтан гэж би өвөөд давтан хэлэв.

— Тэгэх тусмаа сайн. Китти, чи түүнийг улам ойр дотно дасгахын тулд гэрт оруулах, унах хоёроос бусад бүх зүйлийг хийх хэрэгтэй.

Нэг жилийн өмнө Пийпийг бид олж авсан билээ. Түүний жинхэнэ нэр нь Петить бөгөөд Шотландын нэг давжаа адуу франц нэртэй байхдаа яах вэ гэж би үзээд жаахан өөрчилсөн юм. Петить үнэхээр бяцхан бөгөөд өхөөрдөм, Тэр байдсыг англиар шууд «Пийп» гэж нэрлэх нь зүйтэй санагдав. Ууланд зугаалахаар явахдаа эхлээд би Пийпийг гэртээ орхиж, зөвхөн Скип нохойгоо (үсрэх, цовхрох гэсэн англи үгээс гаралтай нэр. Орчуулагч) дагуулж явах гэж оролдов. Скип буюу скай-терьер гэртээ байхдаа ч жирийн байдлаар алхаж явах

дургүй. Тэрээр бяцхан бөмбөг шиг нэг газраас нөгөө газарт үсэрч цовхорч явна. Нэг өдөр Пийп биднийг дагав. Тэгэхээр нь би түүнийг оролдож, төөрч гэж айлгахаар зориуд нуугдав. Ингэж тоглох явдал түүнд таалагдсанаар барахгүй, сүүлдээ бүр хэвшил болов. Одоо Пийп бид хоёр гэртээ ч тэгж тоглодог болсон. Бид бие биеэрээ үргэлж оролдож байдаг. Тэр бээр аливаа тоглоомоос хоцрох тун дургүй тул харин дандаа гэрт орох гээд байх болсон. Хэрэв түүнийг оруулахгүй хаалгаа хааж орхивол тонгочих, уурлаж янцгаах зэргээр бүхнийг хийнэ.

Хэзээ нэгэн цагт гэрт ороод, хэрэв түүнийг Эванс ахай тэр дор нь олж харахгүй бол чухам ямар хэрэг тарьж хөглөх бол гэхээс миний айдас хүрдэг юм. Хэрэв тэрээр өвөөгийн албан тасалгаанд орвол бүх бичиг, захидал, газрын зураг зэргийг нь зажлаад хаях вий. Тэрээр цаас идэх их дуртай. Хэрэв тэр гэрт орвол задгай галтай зуухны аман дээр нохой шиг ээж хэвтэх эсвэл хивсэн дээр муур шиг атирч хэвтэх байх гэж би хувьдаа боддог ч гэсэн зүрхэлдэггүй бөгөөд түүнийг гэрт оруулахгүй байна гэдэг бол наддаа маш том ажил болдог.

Өчигдөр Эванс ахай өвөөгийн албан тасалгаанд цонхны нойтон хөшиг барьж ороод:

— Танай Давжаа байдас юу хийснийг харж байна уу? Энэ хөшигнүүдийн үзүүрийг тас татаад идчихсэн байна.

Өвөө тэр хөшигнүүдийг үл хайхарсан янзтай харж:

— Миний бодоход, Давжаа цонхоор орох гэж оролдсон байна.

Өөр тэр бид хоёр яах л гэв гэж хэмээн өгүүлэв.

— Огт тийм биш. Муу Давжаа намайг гэрт оруулахгүй байгаад өширхөж, миний уурыг барах санаатай байгаа юм. Нэг өдөр гал тогооны өрөөнд орчихсон байхаар нь би хөөж гаргасан чинь харин шалны жижиг хивсийг зуугаад гол руу зутаасан.

Өвөө тохуурхангуй инээж,

— Тэгвэл өөртэй чинь нөхөрлөх л санаатай байгаа юм байна. Өөр яах вэ! гэв.

— Хорон санаа нь л түрүүлж байгаа байх! Энэ охиныг та эрхлүүлж, энэ охин байдсыг эрхлүүлсээр эвдэж гүйцлээ! гэж Эванс ахай яншив.

— Хоёулыг нь та л эрхлүүлж байгаа байх! гэж өвөө ууртай өгүүлэв.

Дараа нь тэд ердийн заншлаараа бие биедээ нөгөө «утгагүй юм» гэдэг үгээ хэлэв.

Тэр хоёрын маргалдахад би байсан байгаагүй ялгаагүй. Дараа нь хэн юу гэж хэлснийг нь дуулна. Эванс ахай өвөөд юу хэлснээ, өвөө Эванс ахайд юу гэж хариулснаа аль аль нь надад ярьчихдаг юм.

За, миний ам халж, яриа ихэдлээ. Одоо захидлаа дуусгая. Эванс ахай, өвөө хоёр намайг чалчаа гэдэг юм.

Тахийн талаар сэтгэл зоволтгүйг чамд ойлгуулахын тулд Давжаа байдас, манай дархан цаазтай газрын тухай би тодорхой ярьж өгөх хэрэгтэй биз дээ.

Танай Сэр-Од ажаа миний бичгийг гаргах ч байх, чамд бүгдийг орчуулж өгөх зав түүнд олдох ч байх гэдэгт би найдаж байна.

Тахийн ирэх өдрийг би тэсэж ядан хүлээж байна. Харин Давжаа тэр хоёрын нөхөрлөл юу болдог бол гэж сэтгэл их зовж байна. Тэр хоёр уулзаад хэрхэхийг үзэх сэн гэхээс ёстой л байж цөхөж байна. Тэд чинь хүн биш адгуус гэдгийг эрхбиш чи ойлгомоор юм даа гэж өвөө үглэх юм. Тэр нь энэ талаар чи битгий их нялуурч, тэнэгэрхээд бай! гэсэн утгатай үг юм байна. Би хичээж үзье. Гэхдээ Давжаад хэтэрхий их хайртай над шиг хүнд тийм ч хялбар зүйл биш байхаа!

Одоохондоо баяртай! Тахийг энд ирмэгц захиа бичихийг чамд би амлая!

Чиний шинэ найз
Китти Жемисон

Жич: Монгол малгай ёстой гайхамшиг. Ийм малгай үзсэн хүн манай энд огт байхгүй юм. Сургуульдаа өмсөнө гэж өвөл болохыг тэсэж ядан хүлээнэ. Хариуд нь ядаж чиний бэлгийн хагастай тэнцэх юм олох гээд чадахгүй байна.

Китти.

Эрхэм найз Баярт!

Тахь энд ирэв!

Беркширт байдаг улсын карантинаас өнгөрсөн тав дахь өдөр мал тээврийн бүхээгт машинаар тахь ирлээ.

Бүхээгт чиргүүлийг «Лэнд рова»¹ хэмээх машинаар манай гадаа чирч авчраад малын эмч өвөөгөөс тахийг гаднаа буулгах уу, ууланд аваачиж буулгах уу? гэж асуув. Өвөө түүнд:

— Энд буулга, наанадаж бидний байдаг газар, цаанадаж биднийг харж аваг!

Би яахыгаа ч мэдэхгүй байлаа. Пийп миний ард зогсоод намайг хошуугаараа нударна. Скипийг хуцаж магадгүй гээд гэртээ түгжиж орхисон. Энэ бүхэн нь надад нэг л ер бусын санагдсан. Тахийн барааг ч хараагүй байж миний сэтгэл догдолж байлаа. Миний бодоход Пийп чиргүүлийн бүхээг дотор түүнд хамаатай ямар нэг үл таних зэрлэг амьтан бий гэдгийг тааварлаж байсан байх. Тэр бээр миний суга руу хошуугаа шургуулж, ууц руу нудрах нь хоёулаа эндээс холдье гэх шиг санагдав.

— Чийш! гэж би Пийпийг түлхэн уцаарлангуй шивнэв. Яагаад ч би шивнэсэн юм бэ, бүү мэд. Тахь ямар нэг аюул болох нь гэж гадарласан байртай бүхээг дотор ууртайгаар амьсгаадаж, бас янцгаан, туурайгаараа цавчиж, өшиглөж байгаа нь сонстов.

— Китти, хол бай! гэж өвөө хэлээд, малын эмчийг бүхээгийн арын хаалгыг онгойлго! гэв.

Малын эмч арын түгжээг тайлж байх зуурт Пийп нэг хэсэг хотолзож байснаа, гэнэт эргэн шогшиж байшингийн араар оров.

Өвөө түүнийг харж инээгээд:

— Удахгүй санаа сэтгэл нь өөр болно гэв.

Бүхээгийн ар тал нээгдэж, тахийн бие ямх ямхаар цухуйж ирэхэд, урьд өмнө үзэж хараагүй, хачин муухай зэрлэг амьтан харагдах шиг болов. Би өөрийн эрхгүй ярвайж: «Энэ чинь ёстой л хүн аймаар амьтан байна» гэв. Тийм боргил булиа, бяр чадалтай, сахлаг үстэй, толботой ч юм шиг, үс нь (жирийн адууны үстэй адилгүй) зарим газраа зулгарч унасан сонин адуу үзнэ гэж би огт бодсонгүй. Дэл нь хүртэл ер бусын, яг л шүдний сойзны үс шиг санагдав. Хамгийн сонирхолтой нь толгой

томтой юм. Үнэхээр энэ үрээ нь өвөөгийн ажлын өрөөний хананд өлгөөтэй байдаг эрт балар үеийн адууны зурагтай тун төстэй байлаа.

Хоёр шанаандаа хууз сахалтай юм. Хууз сахалтай морь би хаа ч үзээгүй. Тахийг гараад ирэхэд нь өвөө:

— Ёстой л нэг адууны хүү байгаа биз! гэж дуу алдав.

— Галзуу солиотой юм шиг. Үнэхээр аймаар амьтан. Сүнс зайлчих шахлаа! гэж би санаандгүй хэлчхэв.

— Гайгүй ээ, чиний үзэл өөрчлөгдөнө гэв.

Тэр бээр довтлохоор зэхэж байгаа юм шиг толгойгоо духайлган биднийг гөлрөн харж хөдлөхгүй зогсож байсан тэр мөчид үнэхээр миний үзэл санаа өөрчлөгдөх шиг санагдсан. Яагаад гэхээр тэр бээр аймшигтай, ширүүн догшин мэт харагдсан боловч түүний тухай эрэлхэг зоригтой, эрс шийдэмгий, ялагдашгүй амьтан гэж чиний бичиж байсныг би өөрийн эрхгүй санав. Тэр гоё ч бай, муухай ч бай надад огт хамаагүй.

Харин би өвөөд ингэж хэлэв:


— Өвөө, энэ морь энд хэзээ ч жаргахгүй. Яагаад гэвэл энэ чинь шал өөр, мах цусны зэрлэг амьтан байна. Манай энд яасан ч идээшихгүй.

— Харж л байя! гэж өвөө хариулав. Энэ мөчид тахь үсрэх гэж байгаа том муур шиг биеэ хурааж харагдав. Гэвч үсэрч ирсэнгүй, хар хурдаараа нугын зүг давхиж одов. Өөрийн хачирхалтай пагдгар хөлөөр газрын хөрсийг давтахаар мэрийж байгаа юм шиг давхиж одов. Удсан ч үгүй нэгэн хоолой руу ороод бараа сураггүй болов. Цаашаа улам улам хурдалсаар байгаа байх гэж би бодов.

— Гайхамшигтай! Бахархалтай! Ёстой л нэг адууны сор! гэж манай өвөө дуу алдав.

Би эрэл сурал болж, нөгөө муу Пийпийгээ хайв. Тэр маань айсандаа байшингийн ард нуугдсан байв. Өвөө маш баяртай, хоёр өвдгөө алгандан, ширвээ сахлаа гозолзуулан инээж:

— Одоо бид Питер юү гэж мэдээлэхийг сонсоно. Би түүний «хэрээний үүр»-тэй холбоо барьж, энэ үеэс эхлэн хоёр нүдээ нээлттэй байлга! гэж хэлье.



«Хэрээний үүр» гэдэг нь дархан цаазтай газрын хамгийн өндөр ууланд байгуулсан ажиглалтын шилэн цамхаг. Түүнийг барьсан талбай өөд авирч гарахад тун бэрх, өвөө намайг тэр өөд авирахыг зөвшөөрдөггүй юм.

Питер гэдэг нь өвөл зунгүй тэнд сууж, адгуусан амьтны хойноос ажиглалт хийдэг өвөөгийн туслагч. Тэндээс эргэн тойрны олон миль газрыг ажиглаж болно. Ирэх жилээс «Хэрээний үүр»-т телевизийн төхөөрөмж тавих бөгөөд тэгэхээр бид өвөөгийн ажлын өрөөнөөс хаа юу болж байгааг шууд харна. Манай өвөө их настай болсон тул тийшээ зөвхөн нисдэг тэргээр очдог юм.

Тэгээд бид Питертэй тусгай дамжуулагчийн тусламжтайгаар радио холбоо барихаар нөгөө байшин руу явж байхдаа Пийпийн хажуугаар өнгөрөхөд бид түүнд ямар нэг муу юм хийсэн янзтай анх удаа биднээс зугтаж байлаа.

— Хэдийнээ ойлгож байна гэж өвөө өгүүлэв.

— Юу ойлгож байна гэж?

— Наадах чинь одоо тайван биш байна. Юу болоод байгааг Пийп хэдийнээ ойлгосон байна. Үнэхээр ойлгожээ...

— Пийп юу ойлгосон юм бэ гэж би асуусангүй. Гэхдээ л энэ бол эхлэлт мөн.

Яагаад ч юм бэ, тэд хэзээ ч хамт байхгүй юм шиг надад санагдана. Пийп хэзээ ч гэрийнхээ гаднаас холдохгүй, тахь хэзээ ч

гэрийн хаяанд ирэхгүй. Тэр ч байтугай тахь оргох арга бодож байгаа гэдэгт би итгэж байна.

Харин өвөө «тэсвэр хэрэгтэй, хонгор минь!» гэж хэлээд, Питер чи, тахийг олж хармагцаа бидэнд яаралтай мэдэгдээрэй гэж гуйв.

— Таны бодоход, зэрлэг адуу хаа явж байх ёстой вэ? гэж дуу өсгөгчөөр Питерийн хоолой цуурайтав.

— Үнэнээ хэлэхэд мэдэхгүй байна. Хаа л холдов гэж дээ. Ямар нэг нууцхан газар олж аваад л нэг хэсэгтээ тэнд хорогдох бол уу? гэж өвөө хэлэв.

Тахь яг л тэгсэн байв. Дараа өдөр нь бид өглөөний цайгаа ууж суутал «Хэрээний үүрнээс» Питер яаралтай ярив (Питер биеэр бага, бүжиглэх онц дуртай. Тэнд ганцаар байдаг болохоор, үргэлж бүжиглэж байдаг юм. Шотланд бүжиг, орчин үеийн бүжиг, тэр ч байтугай «орос», «унгар» бүжиг хийж чадна гээч! Мэдээжийн хэрэг, өөрөө өөртэйгөө л бүжиглэнэ шүү дээ).

— Профессор би тэр зэрлэг адууг олж харлаа. Тэр бээр гарах газар хайж байгаа, адуун сүргээ үгүйлж байгаа, ийш тийшээ зогсолтгүй хөлхөж байна.

— Сайн байна. Харин түүнийг хараанаасаа алдаж болохгүй шүү гэж өвөө хариулав.

Түүнээс хойш өдөр, шөнийн аливаа цагт Питер утасдаж, тахь хаа, юу хийж явааг байнга мэдээлж байлаа. Питер ямагт их тэвдүү ярина. Тахийг хараад л яагаад ч юм бэ, сэтгэл нь их хөдөлдөг бололтой. Тэр бээр тахийг ямар нэг ер бусын буюу аймшигтай хэрэг тарина гэж айдаг байх. Надад ч гэсэн тэгж санагддаг. Өвөөд ч бас адилхан байх.

— Хөөрхий муу тахь энд ганцаардахын зовлонг ч ганц үзэж байгаа байх гэж нэг удаа би өвөөд хэлээд тавьчихав.

— Тэр үнэн. Тахь бол сүргээр амьдардаг адгуусан амьтан. Тийм учраас адуун сүргээ мөрөөдөж байгаа. Бид Давжаа байдсыг түүн дээр очуулахын өмнө түүнд аль болохоор ганцаардахын зовлонг үзүүлэх ёстой гэж өвөө өгүүлэв.

Би юу ч хэлсэнгүй. Яагаад гэхээр Давжаа Пийп хэзээ ч түүнтэй нийлэхгүй, хэзээ ч түүн дээр очихгүй гэдэгт бат итгэж байлаа.

Питер түүнийг бүтэн долоо хоног ажиглажээ. Тэр бээр дархан цаазтай газрын бүх дэвсгэрийг хэрэн хэсэж гүйцээд (заримдаа огт харагдахгүй алга болдог болжээ) усгүй шахам, тачирхан, хужирлаг

ургамалтай, элсэрхэг хөрстэй нэгэн бяцхан хоолойд байршихаар шийдсэн бололтой.

- Түүнийг харуулдан ажиглахад тун сонирхолтой. Тэр бээр үргэлж сүүлээ шарваж, толгойгоо ууртайгаар хаялан, ямар нэг юм хайж байгаа юм шиг гүвээ толгодыг нэг нэггүй нэгжинэ. Тахь замдаа тааралдсан морь мал, хонь ямаа шувууг хүртэл хөөж үргээн, өчигдөр тэр бээр янгир ямаатай хөөцөлдөн уул өөд гарахыг нь би харлаа. Бөөн хар турлиах руу дайрахад нь тэд чөтгөрт хөөгдсөн юм шиг нисэж арилна. Гайхамшигтай морь. Эгнэшгүй амьтан. Барих гэж оролдсон хүний хөлсийг шавхах уужим хоолойд тэрээр байрласан байна гэж Питер радиогоор бидэнд мэдээлэв.

Нэг өглөө Питерийн энэхүү сэтгэл хөдөлсөн, ээлжит мэдээг сонссоны дараа өвөө эрс шийдэмгий дуугаар:

— Сайн байна. Бид өнөөдөр үдээс хойш Давжааг түүнтэй нийлүүлнэ гэж хэлээд хэвшил болсон ёжтой инээдээрээ инээж, хоёр өвдгөө алгадаад цааш хэлсэн нь:

— Тэр хоёр улаан нүүрээрээ уулзаад чухам яахыг үзэхийн тулд би баруун гараа гайд гаргахад бэлэн байна. Давжаа маань давна гэдэгт эргэлзэхгүй байна.

— Харин тахь түүнийг хэмх өшиглөвөл яана? гэхэд

— Үгүй. Амьтны хүрээлэнд байгаа бол магадгүй. Ийм ил задгай газар тэгэх ёсгүй гэж өвөө хариулав.

— Энэ чинь муу Давжааг үг чиггүй тэнд аваачиж орхино гэсэн хэрэг үү?

— Тийм! Хонгор минь, одоо туршиж үзэх хугацаа боллоо гээд өвөө санаа алдав.

— Дэндүү хатуу сэтгэл гаргасан хэрэг байна! гэж би дургүйцэн өгүүлэв.

Өвөө гэнэт маш төв байдалтай болж,

— Үгүй. Хатуу сэтгэл гаргаж байгаа хэрэг огт биш. Китти, адгуусан амьтан бол хүн биш шүү дээ. Давжаад ч гэсэн нохой шиг биш, адуу шиг амьдрах нь дээр шүү дээ. Үзэж л байж л мэдье!

Давжааг бүхээгтэй машинд ачаад тахийн байршиж байгаа Тирионы хөндий рүү явахад надад тун эвгүй санагдаж билээ. Давжаад ч гэсэн энэ бүхэн огт таалагдаагүй. Бид түүнийг арай чамай нэг барьж аваад, маш зовж байж машинд ачсан. Машин хөдлөхөд тэрээр тун ууртай янцгаав. Давжаагийн талаар дандаа гомдол мэдүүлж байдаг

Эванс ахай хүртэл бид ямар нэг аймшигтай зүйл үйлдэж байгаа юм шиг үүдэн дээрээ зогсчихоод толгой сэгсэрч байлаа.

Өвөө газрын зураг үзэж байснаа Давжааг тахийн одоогийн байршиж байгаа шинэ нутгийн нь цаад захад гаргаж тавихаар шийдэв. Учир нь тэрээр гэр өөдөө гүйхдээ тахийн байгаа газрыг дайрч гарах ёстой байв.

— Давжаа маань тахийн байгаа хоолойд үдшийн бүрий болох үеэр ирэхээр бодож тааруулах хэрэгтэй. Тэгвэл харанхуйд тахь айх ичих зүйлгүй өөрийнхөө зочинтой учрах болно гэж өвөө хэлэв.

Давжааг орхих хэсэг модтой газарт хүрч очоод байхад:

— Давжаа маань айгаад үнхэлцэг нь хагачих байх! гэж би уйлах шахам өгүүлэв.

— Огт ажрахгүй! Давжаад ч гэсэн тахитай уулзахад сонин байх болно. За та нар харж л байгаарай! гэж өвөө хэлэв.

— Тахь чинь зэрлэг амьтан шүү дээ! гэж би эсэргүүцэв.

— Түүний зэрлэг нь тэдэнд их саад болохгүй байх! гэж би бодож байна гээд ёжтой инээмсэглэж, миний толгойг илбээд:

— За, за тайвширч үз! гэв. Бүхээгээс Давжааг гаргаад, явахаар завдаж байхад би:

— Тахь үүнийг алчихна даа! гээд уйлав. Давжаа ямар нэг аймшигт мангас үзсэн юм шиг хөдлөхгүй биднийг гөлрөн харж зогсоно. Бид энэ амьтныг зовоож байдаг ёстой мангас юм даа гэж бодогдов.

Тэндээс хөдлөхөд би малгайдаа нүүрээ нуугаад уйлж гарав. Бид хурдаа төдий л нэмээгүй байхад тэр биднийг дагаж давхисаар байсан боловч дараа нь аргагүй хоцров. Арай далд ороогүй байхад тэр уйтгартайгаар бидний хойноос гөлрөн зогссоор байлаа.

— Тэр чинь төөрчихнө шүү дээ! гэж би нулимсаа асгаруулан байж үглэв.

— Алзахгүй. Гэртээ харих замыг адуу, нохойноос амархан олдог юм. Давжааг Шотланд оруулаад тавьчихсан ч гэрээ олоод л ирнэ гэж өвөө намайг тайтгаруулан хэлэв.

Хэрэв би энэ эзгүй ууланд Давжаагийн оронд Азийн тэр зэрлэг үрээтэй хоёулхнаа хаягдсан бол яана гэж бодоход, хэдийгээр би биеэ барьж чадахгүй тэнэг байна гэж буруугаа ойлгосон ч харин өвөөгийн хэлсэн надад огтхон ч падгүй санагдав.

Баярт, өнөөдөртөө миний чамд бичих зүйл ердөө л энэ байна. Би тун их ядарч байна. Орон дээрээ босож суучхаад энэ захидлыг бичиж байна. Шөнийн нэг цаг болж байна. Харин миний нойр хүрэхгүй байна. Муу Давжаа маань гэртээ харих замаа олох гэж ууланд яаж будилж яваа бол гэж бодож сууна. Одоо энд аймшигтай аадар цутгаж, цахилгаан цахилан, тэнгэр дуугарч, цахилгааны гэрэлд тал хөндий, гүвээ толгод өдөр шиг тодхон харагдаж, бороо хувингаар ус асгах мэт цутган орж байна. Газар дэлхий нурж байгаа юм шиг тэнгэр сүртэй дуугарч байна. Энэ захидлаа бушуухан дуусгаад, аймшигт цахилгааныг үзэхгүй, тэнгэрийн дууг сонсохгүйн тулд хөнжлөөрөө толгойгоо битүү хучаад хэвтэнэ.

Хэд хоногийн дараа дахиад бичнэ. Давжаа Пийпийг ууланд орхисноос хойш үнэнээ хэлэхэд, би түүний амьд явааг дахиж хэзээ ч үзэхгүй гэж бодогдох болов. Харин дараачийн шөнө нь хоёр цагийн үед цонхны цаана шугтнах чимээ гарахад нь сэрээд харвал Давжаа маань хошуугаа цонхоор оруулахыг оролдож байлаа. Дараа нь аймшигтай чангаар янцгаав. Түүнийг нь сонсоод Скип айж орон доогуур шургав.

— Пийп, чи эргээд ирэв үү? гэж би хашхирав. Тэр бээр над руу гайхсан янзтай харах нь «Тийм эргээд ирлээ, Харин чи намайг яах гэж тэнд орхисноо урьдаар хэлчих» гэж асуух мэт санагдав.

Дараа нь цонхоор үсрэн гарч, хүзүүдэн тэврээд, энд тэнд нь шарх сорви байгаа эсэхийг цонхны гэрэлд нарийвчлан шалгав. Түүнийг би хөл нүцгэн хөтөлж саравчинд нь оруулахаар явахад, Скип бас түүний хөлөөс зуухыг оролдоход нь «жов!» гэж хөөв. Түүнийг бяцхан байранд нь оруулж өгөөд, эргэж цонхоороо үсрэн орж, сэтгэл амраад маргааш өглөө нь сургуульдаа явах цаг болтол нам унтсан байлаа.

Мэдээжийн хэрэг, «би чамд эс хэлж үү!» гэж өвөө өгүүлэв. Пийпийг ч гэсэн өвөө их сүрхий анхаарч, урьд намайг ёотон өгөхөөр зэмлэдэг байсан хүн чинь өөрөө хэдэн ёотон аваад өгч орхив.

Пийпийн бие ямар ч осол гэмтэлгүй байсанд би сэтгэл хангалуун баяртайгаар сургуульдаа явлаа. Орой гэртээ эргээд ирсэн чинь Пийп бас алга болсон байлаа.

— Пийп дахиад нөгөө хоолойдоо очсон гэж өвөө хэлэв.

Би дахиад сэтгэлийн зовлонд учирч, газар зүйн хичээлийн гэрийн даалгавар хийгээгүйгээс болж шийтгүүлэв. Маргааш орой нь Давжаа

Пийп эргэж ирсэнгүй. Эванс ахай надад нэг аяга халуун какао цай авчирч өгөөд шивнэж:

— Чи өнөө шөнө Скипийг өрөөндөө авч унтвал унт, өөрөө л мэд! гэв.

Скип шөнө болгон миний орон доогуур унтдагийг Эванс авгай мэдээгүй байв. Би түүнд «Их баярлалаа!» гэж аяархан хэлээд, үнссэн чинь харин сэтгэл жаахан тайвшрав.

Энэ удаа Давжаа бүтэн хоёр хоногийн дараа эргэж ирэв. Хамаг бие нь шавар шавхай болчихсон маш аймшигтай харагдав. Түүний өрөөсөн бөөр дээр нь ямар нэг амьтан арьсыг нь өм хазсан юм шиг хэсэг шалбархай байсныг өвөө надад зааж харуулав.

— Энэ чинь шүдний хазсан ор байна. Лав тахь дайрсан байх! гэж би хэлэв.

— Алзахгүй! Энэ бол зүгээр нөхөрсөг маажилтын ор байна гээд радиогоор Питерийг дуудаж хэлсэн нь:

— Удахгүй чамд тэр хоёр хамт яваа нь харагдах магад. Иймээс чи дурангаа нөгөө хоолой руу чиглүүлж зоох нь зүйтэй.

— Ёстой зөв! гэж Питер хариулав.

— Давжааг дахиад нөгөө газарт аваачиж тавина гэж өвөөг ярихад нь би эсэргүүцэж:

— Ингэж дахин дахин аваачиж тавиад, та түүнийг ганц тамлах нь дээ гэв.

— Давжаа дуртай цагтаа хэвтэж, амарч болно. Бас энэ боломжийг ашиглаад тахь түүнтэй танилцах ч юм билүү, яаж мэдэх вэ? гэж өвөө хэлэв.

Үргэлж цаашлуулсаар байгаад өвөө намайг бүүр залхааж гүйцлээ. Тэрээр надад Давжааг өрөвдөж хайрлах бололцоо огт олгодоггүй юм.

Товчхон өгүүлбэл: Бид Давжааг хоолойн нөгөө талд таван долоо хоног дараалан тав дахин аваачиж тавихад тав дахин буцаж ирэв. Харин сүүлчийн хоёр удаад нь тус бүр дөрөв хонож ирсэн бөгөөд түүний байдал төрх шал өөр болсон байлаа. Хагас, бүтэн сайн өдөр бид түүнд жаахан амрах боломж олгодог байсан бөгөөд тэр бээр урьдын адил намайг дагаж явдаг байлаа. Харин байшинд орох гэж оролдохоо бүрмөсөн больсноор барахгүй нэг удаа өөрийнхөө хүслээр уул өөдөө буцах нь уу гэмээр байшингаас үнэхээр холдож одсон

байлаа. Түүний хойноос цонхоор ажиглаж байсан өвөө сэтгэл хангалуун:

— Уухайдаа. Ингэх л ёстой! гэв.

— Тэр бээр биднийг хэзээ ч орхихгүй гэж би маргав.

— Энд, гэрийнхээ хажууд байхдаа биднийг орхиод хол явчихгүй нь магад. Харин дараа нөгөө хоолойгоо дахин гатлах үед яахыг хэн мэдэх вэ дээ? гэж өвөө нэмж хэлэв.

Дараачийн нь даваа гаригт түүнийг дахин авч явахад ямар нэг аюул учирна байх гэж би огт сэтгэл зовсонгүй, харин Давжааг алдах нь зайлшгүй боллоо гэдгийг ойлгоод сэтгэл нэг л эвгүй байлаа. Би яг мэдэж байжээ.

Энэ удаа тэрээр эргэж ирсэнгүй. Дөрвөн өдөр, таван өдөр, нэг долоо хоног өнгөрсөн боловч ирсэнгүй. Нэг өглөө долоон цагийн үед радиогоор Питерийн бачимдаж сандарсан дуу хангинаж: Нөгөө хоолойд тэр хоёрын явааг тодорхой харлаа гэж мэдээлэв.

— Зэрлэг үрээ түүнийг хөтлөх мэт үүгээр түүгээр дагуулан явах бөгөөд Давжаа нь сүүлдэхийн дагаж явна. Тэдний байдал нь: жижигхэн хаан өөрийнхөө шинэхэн танилцсан сүйт хүүхэнд эдлэн газраа танилцуулж яваа мэт харагдана гэж тайлбарлав.

— Тун сайн байна. Тэдний яаж байгааг нарийн нягт ажигла! Хэрэв чамд тодорхой мэдэгдэж байвал, явж байгаа зүг чигийг нь сайн тэмдэглэж ав! гэж өвөө хэлж байхыг нь харахад ёстой нэг сайхан зантай баавгайтай адил санагдав.

— Тахь эргэн тойрноо нэг л ажиглаад, аль хэр хол явж болохыг тамтаж байгаа нь надад илэрхий байна. Арай гол гатлаад явчихгүй байгаа? гэж Питер асуухад:

— Үгүй. Зэрлэг адуу уснаас маш их айдаг юм гэж өвөө хариулав.

— Миний бодоход, тэр бээр гарах газар л эрээд байх шиг байна.

Бүх л газрыг тойрон шинжлээ гэж Питерийн өгүүлэхэд:

— Үнэхээр тийм байж болно. Тэгэхдээ Давжаа түүний санаа бодлыг өөрчлүүлж чадах байх! гэж өвөө хэлэв.

Чухамдаа бидний гол сонирхол, Давжаа тахийг энэ нутагт үлдэхэд нөлөөлж чадах нь уу? гэдэг л байлаа. Давжаа ганц үүнийг л хийх ёстой байлаа.

Тэр шөнө би өөрийнхөө сайн мэдэх хуучин Давжаагийн тухай болон өнөө ууланд зэрлэг үрээг дуулгавартай дагаж яваа шинэ Давжаагийн тухай бодоод сэмхэн уйлав. Би санаа сэтгэлээр аль

болохоор унахгүй байхыг хичээсэн боловч нэг л болж өгсөнгүй. Миний Давжаа хэзээ ч хуучин хэвдээ орохоос өнгөрсөн гэж өөртөө давтан өгүүлэв.

Скип орон дээр үсрэн гарч миний нүүрийг хэд дахин долоов (Скип давстай юманд их дуртай, хүний нулимс их давстай байдаг). Өвөөг хүрч иртэл нь би уйлсаар байлаа. Тэрээр миний толгойг илбэж, бувтнан хэлсэн нь:

— За, боль, боль. Хонгор минь, ямар чамайг тэнд аваачаад орхичихсон биш, Шотландын давжаа, арц далинд дуртай, ууланд байх заяатай амьтан.

Ер нь намайг ч түүнтэй хамт аваачихад хамаагүй санагдаж, энэ бүхнийг үзэн ядав. Хэрэв дэндүү ядраагүй байсан сан бол дахиад уйлж гармаар байлаа. Энэ завсар Эванс ахай ирж, хөөрхий муу адгуусанд хэтэрхий өрөвч сэтгэлгүй хандсан гэж өвөөг зэмлэв. Тэгэхэд өвөө «утгагүй юм» гэж хэлээд тэд тарч одов. Тэд гал тогооны өрөөнд маргалдсаар байлаа. Скип миний хөлд цагариглан хэвтэж, би ч унтав.

Ийнхүү бид Давжааг хүлээсээр байв. Эхлээд Давжаа байшинд огт ойртохыг больсон ба Питерийн мэдээлснээр, тэр хоёр ямар нэг юм эрж буй мэт уул, хөндийг хэрэн тэнэдэг байжээ. Тэд үргэлж яарч тэвдэж явдаг бөгөөд Давжаа заримдаа түүнээс хоцрохгүйн тулд хатирч явахад хүрдэг байжээ. Питер тэднийг хэд хоногоор олж харахгүй болсон боловч Тахийн байнгын байр болсон Тирионы хөндийд тэд ямагт эргэж ирдэг байв. Хожим Питер дахиад л тахь оргох бодолтой байгаа тухай мэдээлэх болов.

— Профессор, энэ зэрлэг азарга үрээг юу ч, манай муу Давжаа ч хоргоож чадахгүй нь байна. Тэр бээр зугтахаас өөр юм бодохоо больжээ гэхэд:

— Харж л байя! гэж өвөө өгүүлэв.

Нэг долоо хоног өнгөрсөн боловч Питер тэднийг огт олж харсангүй. Өвөө хүртэл сандарч эхлэв. Манай гэрээс хол биш байдаг нэгэн бяцхан толгой дээр би үе үе гарч ойр хавийг харуулдавч юу ч олж харсангүй. Тэд бараа сураггүй арилсан байв.

Нэг удаа шөнийн хоёр цагийн үед Скип ямар нэгэн юмнаас айсан юм шиг миний оров доогуур орж, хуцаж эхлэв. Би сэрж, түүнийг дуугүй бай гэж зандрав. Гэтэл энэ мөчид цонхны цаана ямар нэгэн юм бүртэлзэх шиг болов. Би түүнийг олж харахаар босов. Гэтэл энэ нь Давжаа байлаа. Хэдийгээр би Скип нохойдоо «чимээгүй», «энэ чинь

Давжаа эргэж ирсэн байна шүү дээ» гэж хэлсэн боловч Скип хуцсаар л байлаа. Юу болсныг мэдэхийн тулд би цонхоор гарав.

Давжаагийн хамаг бие нь шавар шавхай болсноос гадна учиргүй айж тэвдсэн байдалтай байлаа. Эхлээд тэрээр намайг биедээ ч огт хүргэхгүй байлаа. Дараа нь Скип ямар нэг юм олж үзсэн мэт харанхуй руу хуцаж давхихад нь өвөө сэржээ. Тэрээр үүдний шатан дээр гар чийдэн барьсаар гарч ирэн, энэ хүйтэнд чи дан бошинзтой, хөл нүцгэн юу хийж байгаа юм бэ гэж асуув.

— Давжаа энэ байна... гэж би хэлэв.

— Нээрэн тийм байна. Яагаад эргэж ирсэн нь сонин байна гэж өвөө өгүүлэв.

— Ганцаараа л биз дээ! гэж би мэдэмхийрхэн өгүүлэв.

— Гайгүй байлгүй гэж хэлээд, өвөө Давжаад ойртох гэтэл тэр бээр зайлсхийн холдов. Чи хүрэх гээд үз! Яасан их ууртай байх юм бэ? гэв. Би түүнд болгоомжтой дөхөж очих зуур:

— Давжаа нэг л өөр болжээ гэж өгүүлэв. Хэдийгээр намайг очиж дэлээс нь барихад хөдлөөгүй ч гэсэн нэг л үргэж хавчин гараас мултрах гэж оролдоод байв.

— Давжаа чи яагаад байна гэж би ууртай асуув.

Дараа нь би түүнийг хөтөлж өвөө дээр авчрахад тэрээр гар чийдэнгээ өөдөөс тусгав. Давжаа хагас зэрлэг адуу болсон санагдав. Урьд нь маш цэвэр цэмцгэр амьтан байсан бол одоо харин бүх бие нь хатуу ширүүн, өрвөгөр сэрвэгэр, энд тэнд нь өвс өргөс, шавар шохой наалдсан байлаа.

— Нэг л юм болж дээ! гэж өвөө хэлээд түүнийг нарийвчлан ажиглав. Гар чийдэнгээ эхлээд түүний цээжинд, дараа нь хүзүүн доор нь тусгаж үзээд, чи хараач! гэв. Тэнд хөнхийж харлаад, нарийхан зурвас газар гүнзгий зүссэн байхыг би олж харав.

— Тахь үүнийг дахиад бэртээсэн байна гэж би хэлэв.

— Үгүй, үгүй. Энэ бол төмөр утсанд хага зүссэн байна. Магадгүй торон хашаанд шүргэсэн байж болно.

— Цахилгаан тог гүйлгэсэн торон хашааг та хэлж байна уу гэж намайг асуухад,

— Харин тийм гэж өвөө хариулав.

— Тэгвэл үүнийг яз түлсэн байж таарна.

— Хаанаас даа! Үүнийг зөвхөн хайраад өнгөрөх ёстой. Харин тийм гүнзгий сорви авсныг бодоход хар эрчээрээ торон хашаа руу

дайрсан байж таарна.

— Энэ бол тахийн нөлөө байх гэж би ууртай хэлэв.

Харанхуйд Скип мөн хуцсаар л байлаа.

— Мэдээжийн хэрэг эндээс холгүй тахь байна. Чи Скипийг дууд! Хэрэв түүн дээр давхиж ирвэл... тоглоом биш нохойгоо дуудаж ав! гэж өвөө хэлэв.

Би Скипийг авчрахаар гүйлээ. Тэр бээр чихээ биедээ наачхаад юу ч үл үзэгдэх зүг рүү харж зогсолтгүй хуцаж байгаа нь нэг бодлын зоригтой ч юм шиг, нэг бодлын аймтгай ч юм шиг санагдав. Түүнийг шүүрч, дуугүй болгох санаатай биедээ нааж чанга тэвэрсэн боловч тэр хуцсан хэвээр л байлаа.

— Чи ч гэсэн гэртээ харьсан чинь дээр байх. Зэрлэг азарга яахыг хэн мэдэх вэ? Давжаа наашаа ирсэн явдал түүнд таалагдаагүй нь магад. За, чи орж унт!

— Тэгээд Давжааг яах гэж?

— Би түүний шархыг угаагаад явуулна.

Би дахиад цонхоороо үсэрч орох гэтэл өвөө намайг болиулж, битгий цонхоор ор! Гал тогооны өрөөгөөр дамжаад орох үгүй юү гэв. Би гал тогооны өрөөний үүдэн дээр очтол Давжаа намайг хошуугаараа үл мэдэг нударав. Түүний зовлонг би бас хуваалцах ёстой гэж хэлсэн үг гэж ойлголоо. Тэгэхээр нь би түүнийг хүзүүдэн тэвэрч хайрлав. Түүний сэтгэл ханасан байртай холдон одов.

— Тэр бээр өөрөө яахаа ч мэдэхгүй явах шиг байна даа гэж би гунигтайгаар өгүүлэв.

— Тахь та хоёрын хэн хэнийг, ойрхон байгаасай гэж цаадах чинь хүсэж байна. Магадгүй бүх юм түүний хүслээр болж байж ч мэднэ. Бид ялж байна гэж өвөө өгүүлэв. Гэтэл харин, Баярт минь, яагаад ч юм бэ, надад «бид ялагдлаа» гэдэг бодол төрөв. Өвөө Давжаагийн шархыг угааж өгөөд дараа нь миний өрөөний гэрлийг унтрааж, түүний хойноос цонхоор ажиглав. Тэр бээр нэг хэсэг бодлогошрон зогсож байснаа, цонхны дэргэд эцсийн удаа тулан ирснээ шийдсэн байдалтай гэнэт эргэж зугтав.

— Миний бодоход энэ бол эцсийн удаа Давжаа эргэж ирсэн хэрэг байх! Мэдээжийн хэрэг, тэр бээр тахийг авчирч бидэнтэй танилцуулах гэж олон удаа оролдсон байх!

Нэгэн удаа намайг сургуульдаа явахаар завдаж байтал өвөө намайг ажлын өрөөндөө дуудаж: «Китти хараач!» гэв.

Түүний ажлын өрөөний цэлгэр цонх руу намайг гүйн очтол өвөө тэр хоолойн нөгөө талын уул руу гараараа заав. Уулын эгц орой өөд Тахь, Давжаа хоёр авирч байлаа. Нэг том чулууны дэргэд очоод тэд зогсов. Тахь, яг чиний дүрслэн бичсэнээр, толгойгоо ууртай нь аргагүй сэгсрэв. Бодоход өвөө бид хоёрын үнэрийг салхиар авсан бололтой.

Давжаа гэрээ санасан ч, гэнэт эргэж гүйв.

— Одоо л харж байя! гэж өвөө өгүүлэв.

Бидний харсаар байтал: Тахь түүний хойноос гүйцэж ирээд хоншоороороо хүчтэй нь аргагүй нудраад авав. Давжаа хэсэг зуур эргэлзэж байснаа түүний хойноос даган одов.

— Тахь түүнийг өм хазах шиг боллоо гэж намайг хэлэхэд:

— Арай ч үгүй байх. Харин түүнийг ялимгүй хэгзэлсэн байж мэднэ гэж өвөө түүнийг өмөөрөв.

— Давжаа бидэн дээр ирэхийг бодсон байх гэж би хэлэв.

— Мэдээжийн хэрэг. Удахгүй цаадах чинь бүүр ойрхон хөтлөөд ирнэ. Ямар ч байсан одоохондоо энэ хоолойд түүнийг нутагшуулж эхэлсэн байна. Ингэсээр ингэсээр манай амьдралд дасна гэж өвөө өгүүлэв.

Гэвч, Баярт минь. Питер бид хоёр түүнд тууштай итгэхгүй байлаа. «Хэрээний үүрнээс» Питер бидэнд мэдэгдэхдээ: Тахь сүрхий доголж байна. Хашаа ч, ямар нэг юманд хөлөө цохисноос зайлахгүй гэв.

— Миний бодоход хашаа эвдэхийг оролдсон байх. Эвдэж л байж санаа нь амарна! гэж Питер хэлэв.

— Чи миний толгойг битгий эргүүлээд бай! гэж өвөө уцаарлав. Гэсэн ч тэрээр бүх хашааг шалгаж үзэхээр ноён Сэлвийг явуулав (энэ нь замын ойролцоо суудаг ойн цагдаа билээ).

Одоо би энэ захиагаа дуусгая. Үүнийг уншаад чи нэг их балмагдахгүй байх! гэж найдаж байна. Миний хувьд гэвэл, Тахь, Давжаа хоёрын хэн нь дийлдэг бол гэж бодохоос тун их сэтгэл үймэрч байна.

Яагаад ч юм бэ бүү мэд, бид бүгдээрээ тахийн ямар нэгэн ер бусын үйлдэл хийхийг мэдэж байгаа мэт хүлээж суух юм. Ямар нэг хэрэг мандах нь ч мандах л байх. Хэдийгээр, чухам ямар хэрэг мандахыг төсөөлөхгүй байгаа ч гэсэн бидэнд нэг л тэгж санагдаад байна! Харж л суухаас өөр арга алга!

Манай энд анхны цас орлоо. Муу Давжаа маань дулаан байр ч үгүй, өвс ч үгүй, бид түүнд хааяа нөмөргөдөг нэмнээ нь хүртэл энд үлдсэн юу болдог бол доо гэж миний сэтгэл зовж сууна.

Хэрэв чамд бололцоо гарвал захиа бичээрэй! Тахийн эзгүйгээр нөгөө зэрлэг адуунууд нь яаж байгааг би мэдэхийг хүсэж байна. Чи тэднийхээ төлөө санаа тавьдаг хэвээр л биз дээ.

Ганц мөр ч болсон бичээрэй! (Хэрэв чиний нагац Сэр-Од тун завгүй биш бол).

Гэрийнхэндээ миний чин сэтгэлийн мэндчилгээг дамжуулаарай!

Сэтгэл түвшин биш байгаа чиний англи найз,

Китти Жемисон.

Миний эрхэм найз Китти!

Чиний бичсэн онцын сонирхолтой захидлууд, мэдээжийн хэрэг, цөм надад ирсэн. Харин миний нагац эгч Сэр-Од Свердловск яваад эзгүй байсан тул тэрхүү захидлуудыг унших, хариу бичихэд надад туслах хүн олдохгүй хэцүү байлаа.

Би тэр захидлуудыг англи хэлийн багшдаа авч очоод уншуулж болох байсан. Гэтэл манай ээж зөвхөн уншуулаад өнгөрөх нь найзыгаа хүндлээгүй хэрэг болно гэсэн тул би ямар ч байсан Сэр-Од эгчийг ирэхийг хүлээхээр шийдсэн юм.

Одоо эгч маань эргээд ирсэн. Чамд мэнд дамжуулж, мөн чиний зарим захидлыг өөрийнхөө оюутнуудад уншиж өгөх зөвшөөрөл гуйж байна (тэр бээр төгсөх ангийн оюутнуудад багшилдаг юм).

Хэрэв чамайг зөвшөөрвөл эгч туйлын их баярлах болно. Яагаад гэвэл энэ нь манай хоёр ард түмэн бие биеэ нөхөрсгөөр ойлгоход туслахаас гадна танай жижигхэн арлын амьдрал байдлын талаар манай залуучууд ихийг мэдэж авахад хэрэгтэй.

Харин Тахь ба Давжаа Пийпийн тухай чиний бичсэн бүхнийг уншаад би туйлын их гайхаж байв. Яагаад гэвэл манайхтай адил задгай бэлчээр нутаггүй, Английн бяцхан цэцэрлэгт (бидний уншиж ойлгосноор бол) Тахь дасаж амьдарна гэдэг бол гайхалтай хэрэг. Харин Гарьд (зоологч залууг санаж байна уу?) надад ярихдаа: Тахийг аваачиж байгаа нэг шалтгаан бол танайхыг хэдийгээр цаг агаарын хувьд өөр боловч манай байгалийн нөхцөл байдалтай төсөөтэй, гайхамшигтай сайхан дархан цаазтай газартай гэсэн. Тийм учраас би Тахийн талаар төдий л их санаа зовоогүй юм.


Чиний туйлын нямбай дүрслэн бичиж байгаагаас үзэхэд: Оргох боломж олдох тэр цагийг Тахь тэсэн ядан хүлээж байгаа бол уу гэдэг ойлголт төрмөөр байна. За тэгээд тэр оргодог юмаа гэхэд, Китти минь, хаашаа явдаг бол? гэдэгт л миний сэтгэл зовж байна.

Танай бяцхан орны газрын зургийг ажиглахад газар сайгүй түмэн зам, мянган тосгон байх юм. Хэрэв тэр үнэхээр оргодог юмаа гэхэд, энэ олон салаа замыг гаталж яваад дайруулбал яах вэ? Түүнээс гадна зарим нэг фермер (тариачин) түүнийг аюултай амьтан гэж бодоод буудвал яана.

Миний сэтгэлийг бас нэг зовоож байгаа зүйл бол, тэр хэзээ ч гол мөрнийг сэлээд гарч чадахгүй.

Танай өвөө нэг удаа манай зэрлэг адууг уснаас их айдаг гэж хэлжээ.

Тахийг явснаас хойш түүний сүрэг хүртэл нэг л биш. Тэр бол адуун сүргээ ямар нэгэн аюулаас чадамгай сайн хамгаалдаг байсан бөгөөд түүний явснаас хойш сүрэг нь эзэнгүй болсон мэт санагддаг. Харин тэгэхдээ сүрэг адуу нь тоо толгой бүрэн мэнд хэвээр. Хэрэв энэ жил л туйлын хатуу ширүүн өвөл болчихгүй бол тэд алзахгүй.



Монголын засгийн газар манай эндхийн уулсыг зэрлэг адууны дархан цаазтай нутаг болгон зарласан. Дараа жилээс эхлэн энд зэрлэг адуунд зориулсан хашаа хороо барихаас гадна өвс тэжээл хүртэл зэхэж базааж өгнө. Тэгэхээр тэдэнд ямар ч улирлын хатуу ширүүн нөхцөл аймшиггүй болно.

Миний тухайд гэвэл, сургуульдаа идэвх хичээлтэй суралцаж байна. Тахийг авч явснаас хойш өдөрт энэ хүүхдийн бодол санааг эзэмдэх зүйлгүй болж амарлаа гэж эгч ярьдаг юм. Гэсэн ч шөнийн цагаар байн байн нойр хулжиж, нутаг орноосоо холдож одсон Тахь маань яаж байгаа бол гэж дурсан санадаг юм. Чиний боддогийн нэгэн адил бас, хэрэв би түүний оронд очсон сон бол, төрөлх нутаг усаа эргэж хэзээ ч үзэхгүй гэж бодохоос түмэн зовлон эдлэх нь мэдээж гэж боддог юм.

Эх нутагтаа эргэж очих сон гэж тэр маань туйлын их хүсэж байгаа байх даа!

Сэр-Од эгч энэ захидлыг Улаанбаатарт аваачиж шууданд өгөөд ирсний дараа би чамд дахин захидал бичнэ.

Манай гэрийнхний өмнөөс өөрийн гайхамшигтай өвөө, Эванс ахайдаа том мэнд дамжуулаарай!

Чиний захидалд Эванс ахайн тухай дурдсан хэсгийг ээж Сэр-Од эгчээр дахин дахин уншуулаад санаа алдаж толгой дохиод байсан бодвол, Эванс ахайн ажил явдал түүнд нэн ойлгомжтой байсан нь мэдээж. Скин нохойдоо бас мэнд хүргээрэй!

Чиний алс холын найз

Баярт.

(Зургаадугаар ангийн сурагч)

Жич; Манай эгч чамд монгол англиар бичсэн хэл зүйн хамгийн амархан сурах бичиг явуулна гэж ярьж байна билээ. Би ч гэсэн одоогоос эхлэн англи хэлийг бүр нэг нухацтай сайн оролдъё гэж бодож байна. Чиний захидлыг өөрөө уншаад, хариу бичиж чаддаг болохоос нааш миний сэтгэл амрахгүй.

Өнгөрсөн жил ахынхаа шинэ мотоцикл дээр сууж байгаад авхуулсан нэгэн зургаа явууллаа. Одоогоор би түүнийг унаад явж чадахгүй ч, яаж хөдлөгдөг арга учрыг нь сайн мэднэ.

Миний зүүн гарт сууж байгаа бол охин дүү Минжээ. Тэр намайг үнэхээр асаагаад явах нь гэж ойлгосон учир их тэвдсэн байдалтай харагдаж байна.

Баярт.

Эрхэм найз Баярт!

Энэ бол туйлын уйтгартай захидал шүү. Урьдаас учрыг ойлгож сэтгэлээ барь!

Чамайг уншиж эхлэхээс өмнө өөрийнхөө бичиж байгаа энэ зүйлийн талаар би уучлалт гуйх хэрэгтэй болж байна.

Юу болсныг чи бараг тааварлаж байгаа байх даа. Тахь нөгөө Давжаа байдсыг дагуулаад оргочихлоо. Энэ хэрэг явдал болсон тэр мөчид би чамд бичээгүйн учир бол эхлээд үүнд хэн ч итгээгүй бөгөөд ямар нэг хэрэг явдал гарна гэж үргэлж сэжиглэж байсан Питер ч итгээгүй. Гэтэл үнэхээр ийм хэрэг явдал боллоо. Би хамгийн эхний шинж байдлаас эхлэн бичье! Тэгэхгүй бол эх адаг нь ойлгогдохгүй бөөн будилаан болохоор барахгүй нус нулимстай хутгалдсан заваан юм болно. Давжаа байдас Тахийг гэрийнхээ гадаа нэг удаа дагуулж ирсэн тухай бичсэнийг чи санаж байгаа биз дээ? Бид түүнийг сайн юмны шинж тэмдэг гэж найдаж байлаа. Түүнээс хойш арав хоног, бид ч, Питер ч тэдний барааг олж харсангүй. Бид сэтгэл зовж эхэллээ. Гэтэл тэд Питерийн «Хэрээний үүр» хэмээх ажиглах цамхаг байдаг өндөр уулын ноён оргилд гарсан байлаа.

Цасанд дарагдсан тэр уулын оройд гарсныг нь Питер нэгэн цэлмэг өдөр олж хараад өөрийнхөө хоёр нүдэнд ч итгэхгүй байжээ.

— Ийм өндөрт авирч гарна гэдэг хүний санаанд багтахгүй хэрэг! Гайхалтай юм даа! гэж тэр бээр радиогоор мэдэгдэв.

— Тэнд идэх өвс байдаг юм бол уу! гэж өвөө хэнэг ч үгүй асуулаа.

— Энэ солиотой адуу юу хийх гэж тэнд гараа бол? гэж Питер гайхан өгүүлэхэд,

— Хай бүү мэд! Ёстой л морины хүү байна даа! гэж өвөө шагшрав. Би ч өөрийн муу давжаа байдсыг л өрөвдөж байлаа. «Хөөрхий муу Пийп! Тахь түүнийг айлган сүрдүүлж хүчээр дагуулж яваагаас зайлахгүй!» гэлээ.

Өвөө сүрхий уурлаж, «Хүний ухааныг чи битгий адууны толгойд суулгах гээд бай! гэж би чамд хэчнээн удаа хэлж байна вэ?» гэж загнав.

Тэднийг дахин бараа харагдахгүй болтол нь Питер харуулдан ажигласаар байжээ. Бид дахиад л сэтгэл түгшиж эхлэв. Учир нь салхи ширүүсэж, хүйтний эрч эрс нэмэгдэв. Хүйтэн бороо орж эхэлснээр

барахгүй, нүүрний арьсан дээр дуссан нь мөсөөр хайрах мэт аймшигтай байлаа.

Өглөө бүр өвөө:

— Битүү манаан! гэж толгой сэгсэрнэ.

Тэнгэрийн ийм муухайд бид Тахь, Давжаа хоёрыг олж харна гэж горьдохын ч хэрэггүй байлаа. Питер өөрийнхөө «Хэрээний үүр» хэмээх үүлний цаадах цэнхэр тэнгэрийн бяцхан орчлонд амьдарч (магадгүй бүжиглэж) байхад бид энд өтгөн манан бүрхсэн ус чийг үнэртсэн уйтгартай хөндийд амьдарч байлаа. Хэд хоногийн дараа цаг агаар зохирч, бид дахиад Тахь, Давжаа хоёрыг эрж гарлаа. Миний бодоход, Тахь Давжааг шөнө бэлчиж, өдөр нуугдах аргад сургасан шиг байна. Энэ бол зэрлэг адууны ердийн зан араншин! гэж өвөө нэг удаа хэллээ. Ойн цагдаа нарын дотор ч тэднийг олж харсан хүн үгүй байлаа. Харин хөдөөгийн бяцхан байшинд амьдардаг ноён Сэлби тэднийг уулын хяр дахь салхи үл үзэх бяцхан хавцалд хэвтэж байхад нь нэг удаа таарчээ. Тэд ноён Сэлбийг харангуутаа ухасхийн босож ум хумгүй зугтжээ.

Бид дахин тайвширч, тэдний алга болсон явдлыг анзаарахыг ч болилоо.

Тэд өдөр нуугдаж, шөнө бэлчиж байгаа гэдэгт итгэж байлаа. Тийм учраас тэдний барааг олж хараагүй дараачийн хоёр долоо хоногт туйлын тайван байлаа. Дахиад нэг долоо хоног өнгөрлөө. Тэд огт үзэгдсэнгүй. За, энэ үед бид үнэхээр сэтгэл түгшиж эхэллээ.


Тэглээ гээд бид яах билээ?

Одоо харин өвөө тахийн ааш араншин, түүний нугаршгүй зөрүү занг дутуу үнэлсэндээ өөрийгөө зэмлэнэ. Нөгөөтээгүүр тэднийг хаа нэгтэйгээс гарч ирнэ гэж дэндүү удаан хууртаж, цэргийн нисдэг тэрэг дуудаагүйдээ харамсана. Ойн цагдаа нар дархан цаазтай газрын бүх нүх сүвийг нэгжив. Ноён Сэлби морио унаад хөндий хоолой болгоныг хөндлөн гулд гатлав.

Питер өөрийн өндөрлөгөөс хүчирхэг том дуран (бараг сандлын хэртэй) мөн зоолттой яндан дуран зэргийг ашиглан аль холын бараа, уулын хярыг ажиглав. Өвөө өөрийн эзэмшлийн талбайн аль байж болохуйц өнцөг булан нууцгай хэсгийг шалгав. Эванс ахай хүртэл өвөөгийн кабинетад үе үе орохдоо том дуран авайг ашиглан ийш тийш хайгуулдан харав.

«Байшингийнхаа эргэн тойронд өвс тэжээл арвихан тавьчихвал Давжаа байдас гэртээ эргэж ирнэ» гэдэг ухаан толгойд чинь орохгүй байна уу?» гэж Эванс ахай нэг удаа өвөөд хэлэв. Өвөө цочмог уурлаж, элдвээр дайрснаас болж тэдний хооронд аймшигтай маргаан дэгдэв. Тэд миний урвагар царайг хараад бүүр ч сэтгэл нь зовсон дог. Би ч гэж нэг тэнэг юм. Урвайж байхын оронд урагштайхан сэргэлэн байсан бол хаанаас тэд тэгтлээ балмагдах билээ.

За тэгээд, нөгөө хоёрын тухай ямар ч мэдээ сураг гарсангүй. Өвөө Шинэ-портод байдаг хатан хааны нисэх хүчний аврах нисдэг тэрэг бүхий станцад утасдаж тусламж гуйлаа.



Дархан цаазтай газрын дээгүүр нисдэг тэрэг явуулахад тэндхийн ан амьтныг үргээж цочоодог учир бид төдий л дуртай биш байдаг. Харин цаг агаар муухайд янгир ямаанд өвс тэжээл хүргүүлэх зорилгоор л нисдэг тэрэг ашиглах явдал гардаг.

Хатан хааны нисэх хүчний газраас бидэнд хоёр нисдэг тэрэг ирүүлж бидэнд зөвхөн хоёр хоног үйлчлэх тухай мэдэгдэв. Нэг нисгэгч нь намайг хамт явахгүй юу гэсэнд би баярлан, тэд хэлсэн үгээ буцахаас нь урьтаж:

— Мэдээжийн хэрэг! гэж хэлээд шат өөд нь хурдан авирч машинд нь орж суулаа. Нисдэг тэрэг хөөрлөө. Ямар нэг нисдэг таваг дээр суусан бөгөөд тэр тавгийг асар том амьтан толгой дээрээ эргүүлж

байгаа юм шиг надад санагдаж байлаа. Бид хөндий хоолой руу ямагт дурандана.

Хоёр хоног эрэл хайгуул хийсний дараа Тахь, Давжаа хоёр дархан цаазтай газрын нутаг дэвсгэр дээр огт байхгүй гэдгийг бүрэн нотлов. Хоёр дахь өдөр ноён Сэлби дархан цаазтай газрын зүүн үзүүрийн уулын хэсэгт төмөр утсан тор тасарсныг олж үзсэн тухайгаа мэдэгдэв. Үдшийн бүрий болж, амьтан хүмүүс ядарсан үе байсан боловч өвөө нисдэг тэрэгний нэг жолоочийг тэр газарт биднийг хүргэж өгөхийг гуйв. Бид хагас цаг хүрэхгүй хугацаанд тэнд очив. Эртний уурхайн үлдэгдэл (эртний Кельтууд алт авч байсан уурхайн) бат бэх чулуун хана, цахилгаан гүйлгэсэн төмөр утсан тортой нийлсэн газрыг тэд эвдлэн гарсан байлаа.

— Зөвхөн төмөр утсан тор биш, тэд чулуун ханыг эвдсэн байна гэж ноён Сэлби зааж үзүүлэв. Төмөр утсан тор дуусаж, өндөр чулуун хана эхэлсэн газраар цөм цохиж цоолсон байлаа. Баярт, хэрэв чи түүнийг үзсэн бол тийм ханыг бульдозероор ч эвдэж цоолсон гэхэд үнэмшихгүй байсан байх!

Том том чулууг хэмх цохиж, энд тэндгүй тарааж хаясан бөгөөд зарим нэг нь ханан хашааны нөгөө талд 20 ярд² хэртэй хол чулуудагдсан байлаа. Нүх нь төдий л том биш ч гэсэн түүгээр адуу багтаж гарахуйц байлаа. Тахь төдий л өндөр биш, гэтэл тийм нүх малтаж гаргасан гэхэд үнэмшихийн аргагүй байлаа.

— Үнэмшихийн аргагүй юм байна! Тэр үүнийг эвдэх гэж мөн ч олон хоног ноцолдсон байх даа. Чухам хэчнээн удаан хөлөөрөө цавчиж, тангарч эвдсэнийг бурхан тэнгэр л гэрчилнэ байх! гэж өвөө шагшрав. Бид хананы нөгөө талд байгаа чулууг үзэхэд зарим чулуу нь цустай байлаа.

— Тэр лав туурайгаа бяцартал цохисон байх! гэж ноён Сэлби хэлэв.

— Тэгснээс зайлахгүй! гэж өвөө гунигтай өгүүлэв.

Энэ үеэр бүүр харанхуй бүрэнхий болсон тул эрэл хайгуулыг цаашид үргэлжлүүлэх боломжгүй боллоо. Нисдэг тэрэг биднийг гэрт хүргэж өгөв. Ханын цаад талын гүвээ толгодоор эрэл хайгуул хийхийн тулд нисдэг тэрэгний ажиллах хугацааг бас нэг өдрөөр сунгуулах гэж өвөө маш их хөөцөлдөв.

Чухал чухал албаны хүмүүст утасдаж байж зөвхөн дараачийн өдрийн өглөө хэрэглэх зөвшөөрөл олж авав.

— Энэ нь адаглаад бидэнд ялимгүй найдлага төрүүлж болох юм гэж өвөө хэлэв. Би ч итгэхгүй л байлаа. Учир нь Тахь дархан цаазтай газрын ойролцоо саатаж дэмий цаг алдахгүй гэдгийг би мэдэж байлаа.

— Миний бодоход, тэр хэдийнээ талийж өгсөн байх! гэж би өвөөд хэлэв.

— Хаашаа тэр вэ? Хаашаа талийна гэж чи бодож байна? гэж өвөө ууртай асуув.

— Мэдэхгүй байна. Хэрэв тэр нэгэнт л оргохоор шийдсэн бол яагаад ч зогсохгүй гэж би бодож байна гэж хэлэв.

— Чиний хэлдэг зөв ч байж магад. Харин Давжаа л түүнийг ялимгүй саатуулж мэдэх юм гэж өвөө бодлогошрон өгүүлэв.

Өглөөний тав хагасаас өдрийн нэг хагас хүртэл бид ойр орчны гүвээ толгод, фермийг агаараас шалган нэгжиж, энд тэнд морь мал, давжаа адуу олныг олж харсан боловч тэдний дунд Тахь, Пийп хоёр лавтай байхгүй нь бүрэн ойлгомжтой болов.

Тахийн үс хөөвөр нь гуужиж, хүрэн бор зүстэй, ер бусын амьтан болсон бөгөөд түүнийг юутай ч хутгаж эндүүрэхийн аргагүй байлаа.

Бүтэн сайн өдөр бид гэр рүүгээ нисэж явахдаа хүн бүхний санаа сэтгэл гонсгор байсан бөгөөд «Хэрээний үүрний» тэндээс авч тэнд нь эргүүлэн буулгаж өгсөн Питер хүртэл сэтгэл туйлын дундхан байлаа.

Дархан цаазтай газрын өнцөг булан бүрийг шиншилж үргэлж ямар нэг юм эрэн хайж явдаг Тахь үгүйгээр эндхийн амьдрал шал уйтгартай боллоо гэж тэр бээр хэлсэн билээ.

— Битгий сэтгэл зов! Тэр эргэж ирнэ! гэж өвөө батлан хэлэв.

Би ч түүнд итгэхгүй байна. Намайг адгуу тэвдүү гэж өвөө, Эванс ахай хоёр хэлдэг ч үнэн шүү. Би үнэхээр адгуу хүн гэдгээ ойлгодог юм. Гэсэн ч би бас Тахийг бид яагаад ч олохгүй гэдэгт бүрэн итгэж байгаагаа өвөөд шуудхан хэлчхэв. Тэр орой өвөө миний унтлагын өрөөнд орж ирээд «Азийн зэрлэг адуу» хэмээн номоос нэгэн хэсгийг уншиж өгөв. Түүнд Прагийн амьтны хүрээлэнд байсан Торнадо гэдэг нэртэй нэг морь зуун хорин км газар зугтан гүйсэн тухай өгүүлсэн байлаа.

— Энэ бол манайх шиг ийм хүн ам шигүү бус суудаг оронд болсон явдал. Бид бол оргодлыг амархан илрүүлнэ гэж өвөө хэлэв.

Өвөө бол зөвхөн миний сэтгэлийг тайтгаруулаад зогсохгүй бас өөрийнхөө сэтгэлийг тайтгаруулж байгаа гэдгийг би сайн ойлгож байлаа. Дараачийн өдөр нь (нэг дэх өдөр) намайг сургуульдаа явсан

хойгуур, өвөө ойр хавийн бүх цагдан сэргийлэх болон фермийн эздэд утасдаж сурагласан байлаа. Бүүр сүүлдээ тэр бээр бүх мужийн цагдан сэргийлэхийн дарга нарт утасдаж юу болсныг тайлбарлаад, гүйлгэж алдсан хоёр адууг сайн ажиж байхыг захижээ. Түүгээр зогссонгүй бас зэрлэг адгуусан амьтныг сонирхогчдын нийгэмлэг, жуулчдын клуб, фермүүдийн байгууллага зэрэг өөр газруудад ч бас утасдсан байлаа. Тэр бээр бүтэн өдөр утсаар ярьчихаад орой унтахдаа айл зэрэглээ бүх муж, районтой ярьж асар өргөн хэлхээ холбоо тогтоосон учир эрт орой хэзээ нэгэн цагт тэр хоёр адууны сургийг заавал гаргана гэж бат итгэж байсан байх. Баярт минь, энэ явдал одоогоос хорин гурав хоногийн өмнө болсон бөгөөд өнөөгийн байдлаар хэнээс ч, ямар ч мэдээ огт аваагүй байна. Ёстой хүн үнэмшмээргүй юм. Тахь, Давжаа хоёр газар доогуур орсон мэт ор сураггүй алга боллоо. Энэ тухай ярих болгондоо би сэмхэн уйлдаг боллоо. Энэ хуудсанд бичсэн инээдтэй сонин өгүүлбэрүүд бол миний хэрхэн маанагтаж байгаагийн нотолгоо билээ. Энэ бол тэнэг хэрэг гэдгийг мэдсэн мөртөө би биеэ барьж чадахгүй байна. Би ч бас яах вэ, манай өвөө л туйлын өрөвдөлтэй байна. Тэр бээр өөрийн хамгийн үнэтэй адгуус амьтнаасаа (дархан цаазтай амьтны хүрээлэнд ажиллах болсноосоо хойш ямагт хүсэж мөрөөдөж байсан) хагацсанаас гадна үргэлж түүний харамсаж байдаг зүйл нь «миний найз нөхөд монголын эрдэмтэд надад итгэж найдаж өгсөн тэр ховор, гайхамшигтай амьтныг нь алга болгочихлоо. Би их тэнэг хүн» гэж үглэнэ.

Би түүнээс тайвшрахыг гуйхад тэр бээр, «Би тэр морины зан араншин, бодол санааг л дутуу үнэлснээс боллоо. Одоо ч гэсэн мэдэхийг хүсэж байгаа нэг зүйл бол, тэр чухам ямар бодол, зорилгын үүднээс, чухам юу бодож үүнийг үйлдэв? гэдэг л сонин байна» гэж үглэнэ.

Баярт минь, тэр хоёр ийнхүү орголоо. Алиныг нь илүү үгүйлж, санаж байгаагаа ч би одоо ойлгохыг байлаа. Хаагуур яаж эрж сурахаа ч бид мэдэхгүй байна. Нэг удаа манай өвөө «Ленд Рова» машинаар бүх Глостерширийг туулаад, Беркшир хүрч замдаа тааралдсан фермийн эздэд, тосгон суурины хүмүүсээс хоёр адуу үзэгдэв үү? гэж асууж сурч явсан байна. Тэд ямар нэг орхигдсон уурхайд унасан? Эсвэл гол мөрөн, тэнгист живсэн байж болох юм? Тэднийг ямар нэг тариачин буудаж алав уу? Машинд дайруулсан ч байж мэднэ? Эсвэл хаа нэгтээ баригдав уу? (Үгүй байхаа. Тахь баригдана гэж ярихгүй). Тэд төөрчхөв үү?

(Хаа?) Эс бол тэднийг шархдуулав уу? Өвчлөв үү? Миний чамд хэлж мэдэгдэх бүх зүйл энэ байна. Би бас арайхан горьдлого тасраагүй л байна. Тахь бол их зөрүүд, эрс шийдэмгий морь гэдгийг бид ойлгож байна. За, би захиагаа дуусгая. Эсвэл дахиад уйлж мэдэх нь байна. Баярт минь, чи энэ бүхний төлөө намайг уучлаарай!

Бид ямар их уйтгар гунигтай байгааг ойлгож байгаа гэдэгт би итгэж байна.

Чиний маш их уйтгарт англи найз

Китти Жемисон.

Жич: Бид ямар нэг мэдээ сонсмогц чамд яаралтай захиа бичнэ.

Би чамд өөрийн гэрэл зургийг явуулж зүрхэлсэнгүй. Учир нь чи одоо түүнийг авахыг төдий л сонирхохгүй байх!

Китти.

Сайн байна уу, Китти!

Тахь алга болсны төлөө өөрийгөө битгий зэмлэ гэдгийг чи өвөөдөө хэлэх нь зүйтэй. Яагаад гэвэл тахь оргож гүйхээр нэгэнт шийдсэн бол та нар урьдаас хэчнээн болгоомжлоод ч нэмэргүй. Энэ бол түүний төрөлхийн араншин. Үүнийг өвөөдөө хэлж ойлгуулаарай!

Тахь чиний бяцхан байдсыг хэрхэвч хаяж орхихгүй. Адуу мал нэг ижилсэхээрээ бие биедээ туйлын үнэнч байдаг юм. Чиний Давжаад халдсан бүхэнтэй Тахь хайр найргүй тулалдах болно.

Харин Тахь цаг агаар, авто машин, золгүй явдалтай л тэмцэж чадахгүй гэж миний нагац эгч хэллээ. Би түүнийг үхсэн гэж бодохгүй байна. Амиа алдах тэнэг амьтан даанч биш.

Битгий сэтгэл зов! Гэрэл зургуудаа ирүүлэхийг хүсье! Би чиний зургийг үзэхийг маш их хүсэж байна.

Чамайг өрөвдөн хайрлагч найз

Баярт.

Жич: Миний нагац эгч Уэльсийн нэрт зохиолч Гвин Томас,
Ричард Левеллин нарын хэд хэдэн сонин номыг орос хэл дээр олж ирсэн. Надад уншиж өгөх болно.

Эрхэм найз Баярт аа!

Хэдийгээр би чиний сүүлчийн захидлыг аль хэдийнээ (гурван сар, хорин хоёр хоногийн өмнө) хүлээн авсан боловч чамд өнөө хүртэл хариу бичсэнгүй.

Би захидал бичиж зүрхлээгүй учир бол чамд сонсгох ямар нэг мэдээ сэлт дуулдаагүй байлаа.

Харин одоо бол сонинтой. Тэгэхдээ тэр нь аль хэр үндэстэй болохыг бүү мэд. Ямар ч гэсэн олон долоо хоног огт сураг чимээгүй байсны дараагаар одоо гэнэт бүх Британийн газар бүхнээс Тахь, Давжаа хоёрын тухай олон зуун (олон зуун гэдгийг ойлгож байгаа биз) мэдээ сэлт хүлээн авч эхэллээ. Зарим нь цагдан сэргийлэх газраас, зарим нь зэрлэг адгуусан амьтан сонирхогчдоос, зарим нь фермийн эзэд, хөдөө тосгоныхноос хоёр адуу алга болсныг сонссон бусад хүмүүсээс ирсэн байна. Энэ тухай нэгэн сонинд «Англид нэгэн зэрлэг амьтан алдагдав» гэж алиалсан гарчигтай өгүүлэл нийтлэгдэв. Өвөөгийн ганц хийдэг ажил нь утсаар ярьсны хариу хэлэх, Эссэкс, Норфолк тэр байтугай Шотланд хүртэл үүгээр түүгээр эрэл хайгуул хийж явах боллоо. Одоогоор ямар ч үр дүнгүй байна. Дэмий сандаргасан худал мэдээ л их ирж байна. Зөвхөн нэг эмэгтэй тэр хоёрыг үнэхээр харсан байлаа. Манай дархан цаазтай газраас холгүй байдаг жижигхэн шувуун фермийн эзэн энэ эмэгтэй эхлээд бид Тахь, Давжаа хоёрыг эрж сурч байгааг мэдээгүй гэнэ.

Тэр хоёрыг тэнд үзэгдэхээ болиод нэлээд удсаны дараа тэр эмэгтэй хэн нэгэн хүнээс ийм явдал болсныг дуулсан юм санжээ.

Тэр хоёрын оргосон анхны шөнө л тэр эмэгтэй үзсэн бололтой. Шөнө нохой хуцах чимээгээр тэр авгай сэрээд тахианы байр руу үнэг гэтэв үү гэж бодоод буутайгаа, гар чийдэн аваад гарчээ. Хаягдал хийдэг сагс савыг гэрэлтүүлээд үзтэл, түүний цаанаас хоёр аймшигтай амьтан цааш зугтахад нь буудсан байна. Оносонгүй гэдгээ ч тэр ойлгожээ. Дараа нь бодоод байх нь ээ нэг нь шотланд давжаа адуу, нөгөө нь морины төстэй боловч үл танигдах маш аймшигтай амьтан байсан гэж Тахийн тухай тэр авгай бичсэн байлаа.

Хоёр адуу агшин зуурт, харанхуйд алга болжээ. Хатагтай Жексоны (тэр эмэгтэйн нэр) бичсэнээр бол, чухам аль нь байсныг тодорхой санахгүй байгаа боловч нэг нь сүрхий доголж байсан байна.

Тэр эмэгтэй тэднийг шархдуулж чадаагүйдээ бат итгэж байгаа ч гэсэн нэг нь сүрхий хүнд шархадсан байдалтай хөдөлж цөхөж байсныг ажиглажээ.



Өвөө тэр нь лав Тахь байсан байж таарна. Учир нь гэвэл чулуун хана эвдлэхдээ хөлөө шархдуулснаас зайлахгүй!» гэж тааварлаж байгаа юм.

Хэдийгээр хэд хэдэн долоо хоног өнгөрсөн боловч бид Тахь, Давжаа хоёр тэндээс чухам хаашаа явсан мөр сургийг гаргах гэж оролдоод дийлэхгүй байна.

Өвөө нэг өглөө Бордо хотын амьтны хүрээлэнгийн орлогч захирал, үл таних ноён Фанон гэдэг хүнээс франц хэл дээр нэгэн захидал хүлээн авсанд; Танай дархан цаазтай газраас алдагдсан монголын зэрлэг морь ямар нэг замаар Францад ирсэн байж болох уу? гэж асуужээ. Ноён Фанон бичихдээ; тэр бээр ийнхүү морь алдагдсан тухай мэдээг францын нэгэн зоологийн сэтгүүлээс уншсан гэжээ.

Гавра хотоос (францын Порт хот) амьтны хүрээлэнгийн зэрлэг амьтдад зориулж мах бэлтгэдэг хүнтэй саявтархан уулзахад, Англиас ирсэн адуун сургийг Кильбеф хотын мал нядалгааны газарт тушаахад тэдний дотор хачин адуу нэг байсан гэж ярьсныг өвөөд яаралтай мэдэгдэхээр шийдсэн байна. Тэрхүү мах бэлтгэгчийн ярьж байгаа

нөгөө «хачин адуу» гэдэг нь үс ноолуур нь гуужсан монголын зэрлэг адуу болохоос зайлахгүй гэж ноён Фанон боджээ. Тэр нэлээд дэлгэрэнгүй бичихийг хичээсэн боловч мах бэлтгэгчээс дуулсан зүйл маань ердөө л энэ болохоор яаж ч чадсангүй гэж бичжээ.

«Таны зэрлэг адуу Францад ирсэн байх нь болзошгүй гэж та үзэж байгаа бол би эрэл хайгуулыг үргэлжлүүлье. Гэхдээ хэрэв тэр нь нөгөө зэрлэг адуу мөн гэж та үнэхээр итгэж байгаа бол шүү!» гэж тэр захидлаа төгсгөжээ.

Өвөө тэр захидлыг уншмагцаа ноён Фанонд яаралтай цахилгаан илгээж, тэр зэрлэг адуу яаж Франц хүрсэн нь ойлгомжгүй байна гээд цааш нь бичихдээ, Ла-Маншийн хоолойг гаталж чадвал түүнд өөр хүрэхгүй газар байхгүй нь үнэн гэдгийг батлав. Иймээс ноён Фанон өөрийн эрэл сурлыг хэрэв цааш үргэлжлүүлбэл туйлын их талархах байна гэдгээ өвөө бас илэрхийлэв. Энэ хооронд тэрхүү зэрлэг морь ямар замаар Франц очсон байж болохыг өвөө өөрөө судлах болно гэдгээ мэдэгдэв.

Баярт минь, сүүлчийн сонин гэвэл энэ л байна. Энэхүү мэдээ нь нэг талаар найдвар төрүүлж, нөгөө талаар айлгаж байна. Хэрэв тэр нь Тахь ба Давжаа байсан бол яагаад тэд нядалгааны газар очих адуун сүрэгтэй нийлдэг билээ (Энэ тухай бодоход ч аймшигтай байна!). Тэд тэгээд дуусах гэж үү? Нядалгааны газарт шүү!

Би түүнд огтхон ч итгэхгүй байна. Итгэхийг хүсэх ч үгүй! Ноён Фанон, өвөө хоёр энэ талаар юу олж тодруулахыг л бид одоо хүлээж сууна. Харин миний хувьд гэвэл тэд ямар нэг зүйл олж мэдсэн нь дээр үү, огт мэдээгүй нь дээр үү гэдгийн аль нь илүү болохыг хэлж мэдэхгүй байна.

Эванс ахай чамд халуун мэндчилгээ дамжуулж байна. «Би монгол хөвүүнийг огт үзээгүй» гэж тэр өчигдөр орой хэлэв. Тэгэхэд нь би чиний зургийг үзүүлэв.

Энэ удаа би чамд хэдэн зураг явуулав. Нэг зураг дээр бид цөм хамт байгаа нь тэр! Нью-Порт хотын Вулворта хэмээх дэлгүүрт байдаг автомат гэрэл зургийн аппаратад Эванс ахай зориуд авхуулсан зураг ч бий. Эванс ахай гэртээ жирийн байдлаар байгаа нь энэ зураг дээр гарснаас хамаагүй дээр! Харин энэ зураг дээр өвөө, Давжаа, бид гурав нэлээд зүгээр гарчээ. Ялангуяа Давжаа маань тоглоомын жижигхэн морь шиг маш хөөрхөн гарсан. Үнэн биз дээ?

Муу мэдээ дуулдахгүй байх гэдэг итгэлтэйгээр ёсолсон ямагт
чиний найз
Китти.

Жич: Манайхан чиний нагац эгч Сэр-Одод том мэнд хүргэж
байна. Эгч чинь чамд туйлын хайртайгаас гадна англиар
гайхамшигтай сайн бичдэг юм байна. Надаас ч илүү бичдэг
юм байна. Эгч чинь ер нь Англид ирж үзсэн үү?
Та бүхнийг цөмөөрөө энд ирнэ гэж найдаж байна. Тахь, Давжаа
хоёрыг олсон цагт лав ирнэ байх.

Китти.

Сайн байна уу, Китти!

Чамаас ойрд захиа аваагүй бөгөөд ямар нэг сураг мэдээ сонсохыг
тэсвэрлэшгүй их хүсэж байна Францын нядалгааны газарт очсон тэр
«хачин» адуу чинь Тахь байсан уу, өөр адуу юу? Би сургуулийн номын
сангаас газрын зургийн атлас авч маш анхааралтай судлав. Тахь Франц
орсон байна гэхэд итгэхийн аргагүй санагдав. Усан онгоцон дээр зэрлэг
адууг тийм ч амархан гаргахгүй дээ? Тэгэхээр яаж тэр нь Тахь байж
таарах билээ?

Чиний захидлыг хүлээн авснаас хойш бид ганцхан энэ тухай л
бодож байна. Аав, өвөө, ах, эгч, нагац эгч Сэр-Од, ээж хүртэл цөм өөр
өөрийн нэг таамаг бодолтой байна. Ээж бидний бүх бодож байгааг шал
тэнэг зүйл гэж зэмлээд «тэр бол Тахь мөн» гэж үзэж байна. Тахийн
нууцыг би мэднэ, тэгэхдээ одоо хэлэх болоогүй гэв. Ээж ямар нэг
жижиг нууц мэдэхээрээ бидэнд хэлэхгүй их зовоодог хүн л дээ. Цаг нь
ирэхээр л би та нарт тэр нууцыг хэлнэ гэх юм. Түүний амнаас барагтай
хүн үг цухуйлгахгүй л дээ. Ээжийн хэлдэг л үнэн байх болтугай! Зав
зай гарвал захиа бичиж байгаарай!

Эванс ахай, өөрийнхөө өвөө, хэрээний үүрэнд суудаг Питер,
Скип нохойдоо цөмд нь мэнд хүргээрэй!

Чиний найз
Баярт.

Жич: Нэг хуучин хайрцгаас олсон жаазанд, бид чиний зургийг
хийж тавьсан. Тэр жаазыг бид бүүр мартсан байжээ. Түүнийг

адууны дэлээр сүлжиж хийсэн бөгөөд дээр үед бурхан сахиус хийж зүүдэг байсан ба одоо бол хэрэгцээгүй болсон эд байв. Ийм адууны дэлээр сүлжсэн жаазанд хийлээ гэж чи уурлахгүй биз?

Баярт.

Сайн байна уу, Баярт аа!

Өдий хүртэл чамд захиа бичиж чиний сэтгэлийг амраагаагүйдээ уучлалт гуйя! Учир нь цаг ямагт ямар нэг ер бусын сонин учрал болж толгой эргүүлсээр байв. Зарим үед би алинд нь ч огт итгэдэггүй байлаа.

Дөнгөж сая ширээний ард суугаад чамд сүүлчийн сонссоныг бичих гэтэл бас нэг сонин явдал болжээ.

Ноён Фанон захиа бичиж, Тахь ямар нэг замаар Франц орсон байж болох уу? гэж асууснаас хойш өвөө алдарт Шерлок Холмсын аргыг хэрэглэн нэгэн адал явдалт зохиолын (100 жилийн өмнө нас барсан гол баатрын нэр) тэрхүү асуудлын талаар өөрөө судалгаа хийхээр шийдсэн юм.

— Юуны өмнө хамгийн боломжтой зүйлийг судлах хэрэгтэй гэж Холмс шаарддаг байсан гэж өвөө хэлээд, энэ учраас Тахийг үнэхээр нядалгааны газарт зориулж явуулсан сүргийн хамт Францад очсон гэж үзье! Тэгэхээр одоо Английн чухам ямар газраас Францын ямар газарт адуу явуулсан байна вэ? гэдгийг л тодруулах хэрэгтэй.

Товчхон өгүүлэхэд, энэ асуудлаа тааралдсан бүхэнд тавьсаар өвөө Английн өмнөд эргийг хэрэн хэсжээ.

Тэр бээр хэдэн арван захиа бичиж, зогсоо жолоогүй ийш тийш нь утасдаж байж сая: Англи ба Ирландаас Франц, Бельгийн нядалгааны газруудад эрэмдэг зэрэмдэг, хөгшин хөвөө адуу явуулдаг болохыг олж мэджээ.

Нэг удаа би сургуулиасаа иртэл (монгол орныг сонирхож эхэлснээсээ хойш би танай орны тухай урьд урьдаас улам илүү сайн мэддэг болсон ба ер нь газар зүй бол миний ганц сайн мэддэг хичээл болсон) өвөө өөрийнхөө өрөөний шалан дээр эргэн тойрон өдий төдий газрын зураг тавьчихсан сууж байлаа.

— Юу болсон учрыг одоо л нэг олох шиг боллоо. Адууны панз үсэргэдэг Спэк гэдэг хүн Ньюбери хотод суудаг юм байна. Тэр хүн

газар сайгүй хоёр том ачааны бүхээгтэй машинаар хэсүүчлэн явж, эрэмдэг зэрэмдэг, хөгшин хөвөө, бас эрүүл залууг ч ялгахгүй аль тааралдсан адуугаа худалдан авч яргын газарт ачуулдаг байна. Мөн бас давжаа адуунуудыг ч голохгүй худалдаж авдаг гэнэ. Хүлрийн намгийн хавиар нутагтай зарим тариачид ярих нь зэрлэг давжаа адуунуудыг шөнө дүлээр сэмхэн хэдэн арваар нь барьж аван бүхээгтэй машинууддаа ачаад явдаг гэнэ. Энэ мэтчилэн Спэк сар болгонд хорин тав орчим адууг үсэргэдэг гэнэ.

— Сар болгонд оо?

— Тийм, сар болгонд!

— Нядалгааны газарт зориулж уу?

— Тийм. Харин Спэк адууг, худалдан авахдаа ямар зорилгоор авч байгаагаа хэнд ч хэлдэггүй гэнэ. Бас надтай хэдэн үг солихоос ч татгалзсан. Харин би адууны панзчидын нэгтэй хууч хөөрсөн юм. Тэр бээр нохойн хоолонд зориулж нядлах адууг олж бэлтгэдэг хүн. Тэрний ярьж байгаагаар бол, Спэк жилдээ таван зуу орчим адууг Ньюберигээс Франц, Бельгид гаргадаг гэнэ. Эрэмдэг зэрэмдэг хөгшнүүдийг нь ан амьтан, нохойн хоолонд зориулж, эрүүл залууг нь хүний хүнсэнд зориулж хоёр анги бэлтгэдэг гэнэ. Адууны махыг Франц Бельгид дуртай иддэг бөгөөд «Шевалин» адууны мах гэсэн хаягтай дэлгүүрүүдэд худалддаг юм. Залуу морь мал ба давжаа адууны мах тэнд л очдог байна.

— Тахь Давжаа хоёрыг та энэ замаар орсон гэж бодож байна уу?

— Болох л юм. Болохоор барахгүй. Китти минь, биеэ барьж үз!

Ямар би орилж чарлаад унасан биш өвөө ингэж хэлэхийн хэрэггүй байлаа. Гэсэн ч би ёотонгийн сав руу бас нэг нулимс унагаад л авсан л даа (би оройн цай ууж суусан юм).

— Тэд яаж Тахийг барьж авч ачааны машин, усан онгоцонд ачсан байгаа гэж та бодож байна? Хэзээ ч тэд түүнийг барьж авахаар барахгүй хорьж хоргоож тогтоохгүй. Тэр ч ёстой галзуу юм шиг үзэлцэнэ гэж би асуув.

— Тэр шөнө ферм дээр очсон хоёр адууны нэг нь сүрхий доголж байсан гэж хатагтай Жексон ярьж байсныг чи санаж байна уу? — Санаж байна.

— Тахь нөгөө чулуун ханыг эвдэхдээ маш ноцтой шархдаж гэмтсэнээс болоод хөдөлж чадахгүй байсан ч байж болно.

Миний бодоход тэр Эксмут, Дартмут хүрсэн байх. Тэнд түүнийг бусад давжаа адуунуудын хамт барьж авсан байж таарна. Нэгэнт тэр бээр тийм айхавтар доголж байсан юм чинь түүнийг амархан барьж аваад хүлчихнэ шүү дээ.

— Гэлээ ч гэсэн тэр тэмцэлдэнэ.

Тэмцэх тэнхэл байсан бол уу даа. Ямар үед тэмцэхээ бас мэднэ байх шүү. Ямар ч гэсэн энэ бүх мэдээг би ноён Фанонд явуулна. Түүний хариуг л сонсьё.

Бид нэг их удаан хүлээсэнгүй. Яагаад гэвэл ноён Фанон бас л энэ талаар мэдээ сэлт цуглуулж байсан үе билээ. Ноён Фаноны ирүүлсэн захидалд юу гэж өгүүлснийг нэг охин бидэнд орчуулж өгсөн нь: «Кельбефийн нядалгааны газарт явуулсан сүргийн дотор байсан «хачин, сэгсгэр адуу»-ны учрыг олж мэдэхээр өнгөрсөн долоо хоногт би Бордо хотоос мордлоо. Энэ хачин адууны тухай урьд нь надад ярьсан манай амьтны хүрээлэнгийн мах бэлтгэгч надтай хамт явлаа. Долоо хоног бүрийн баасан гаригт тэр уул нядалгааны газар очиж манай арслан, бард өгөх махыг авдаг юм. Би тус нядалгааны газарт ажилладаг түүний танилуудаас маш ултай асууж судлав. Тэд ярих нь: Үнэхээр нэг хачин зүс буруу намхан морь, сэгсгэр үстэй «цыган охин» шиг царай муутай шотландын давжаа байдас хоёр байсан гэнэ. Эрхэм профессор, таны захидалд дурдсанаар анхаарал татсан нэг зүйл бол муухай зүстэй, намхавтар биетэй үрээ айхавтар доголж байснаас гадна түүнтэй цуг яваа «цыган охин» шир байдас түүнээс алхам ч холдохгүй дагаж явсан гэнэ.

Миний бодоход, таны хайртай, монголын зэрлэг үрээ л найзаа дагуулж явснаас зайлахгүй».

Энэ бол зөвхөн анхны захидал байсан бөгөөд одоо бол манай өвөө энэ талаар өөрийгөө алдаагүй гэдгийг лавтай мэдсэн болно. Тахь манай дархан цаазтай газраас оргохдоо ноцтой бэртсэн бөгөөд харин түүний дараа Эксмурин давжаа адууны дунд нуугдан байж харин нэлээд тэнхэрчээ. Тэнд түүнийг барьж аван бусад адууны хамт ачуулсан байна. Дараа тэднийг усан онгоцонд ачиж Гаврт хүргэсэн нь мэдээжийн хэрэг. Тахийн хөл бэртэнгэтэй байсан. Давжаа түүнээс салахгүй байсан. Тэгээд хоёулыг нь бариад авахгүй юу даа.

За, тэр ч яах вэ тийм байж гэж бодъё. Кильбефийн нядалгааны газар юу болсон гэж санана? Ноён Фанон өөр нэг захидалдаа бичсэн нь: «Цаашаа юу болсон тухай би нарийвчлан сонирхоход: «Ер бусын

сэгсгэр» намхан бор, түүний найз хоёрыг алсан эсэхийг хэн ч мэдэхгүй байлаа. Би тэдний зүс тэмдгийг маш дэлгэрэнгүй хэлж сураглахад адуу нядалдаг хүмүүс тэр суурийг нядалснаа хэдийгээр сайн мэдэж байсан боловч чухам тэр хоёрыг яаснаа санахгүй байлаа. Яргачид адууг нэг нэгээр хөтөлж аваачиж нядалдаг хамгийн сүүлчийн хашаанд тэд орсон байсныг би мөрдөн мөшгөж мэдэв. Тэгэхээр асуудал иймдээ тулаад байна. Ер бусын сонин адууг хүмүүс санаж болох уу? Болохоор барах уу, тэгэх тусмаа алсан адуу заавал санаанд үлддэг гэж яргачид өөрсдөө ярьж байна.

За, тэгэхээр би ийм дүгнэлтэд хүрээд байна. Монгол морь, шотланд байдас алин ч энэ хашаанаас нядалгаанд лав өртсөнгүй. Тэгээд тэд хаачив? Ямар сонин хэрэг болох нь энэ вэ? Тэд оргож амжив уу? Эсвэл хэн нэгэн хүн тэднийг аваад явав уу? Энэ мэтчилэн хэчнээн ч асуудал тавьж болно.

Профессор Жемисон, энэ асуудлуудыг би нядалгааны газарт ажиллаж байгаа бүх хүнд тавьсны эцэст нэгэн зүйлийг олж мэдсэн нь: нэг шөнө гурван адуу (тэгэхдээ хоёр биш) хүн үнэмшмээргүй тохиолдлоор тэр хашаанаас оргожээ. Тэдний аль нэг нь хашааны ёроолоор гүнзгий нүх ухсан бөгөөд тэр нүхээр гурвуул нохой мэт шурган гарсан байв» гэжээ. Өвөө энэ мөрүүдийг уншиж дуусахад бид цөм нэгэн дуугаар тэр бол ухаантай амьтан, мэдээжийн хэрэг тахь л байж таарна гэв.

Одоо би ноён Фаноны захидлын үргэлжлэлийг энд сийрүүлэе, «Нядалгааны газар Кильбеф хотоос нэлээд зайтай оршдог байлаа. Адуунуудын шургаж гарсан газраас би хол зайдуу зогсоод, тэд чухам аль зүгт явсныг тодруулах гэж оролдов. Хүний нүдэнд үзэгдэхгүйн тул тэр монгол морь чухам ямар арга заль хэрэглэхийг би мэдэж байсан тул голын эрэг дагуу ургасан хэсэг төгөл, түүнээс цааш үргэлжлэх чихрийн манжингийн талбай дундуур зүсэж гарсан замыг барьж мөрдөв. Зам гудасын дагуу тааралдсан тариачид, тосгоны хүн амьтнаас морь мал үзэв үү? гэж би сурагласаар явлаа.

Ашгүй тэгтэл тосгоны шуудан түгээгчтэй тааралдав. Тэр бээр өглөө эрт анд явж байгаад Кильбефээс хориод км-ийн зайтай төглийн захад гурван давжаа адуу байсныг харжээ. Түүнийг хармагцаа морьд зугтаасан бөгөөд тэдний нэг болох намхавтар үзэшгүй муухай амьтан (тэр ингэж дүрслэв) хойд талын нэг хөлөө чирч, гурван хөл дээрээ хурдалж байжээ. Тэдгээр адуу байсан газар түүнийг очих гэж явтал тэд

хуй салхи шиг хурдлан жирийж нэгэн хэсэг модны цаагуур далд оржээ. Өвөө «энэ ч бас муугүй!» гэж хоёр өвдгөө алгадан, Франц руу яаралтай явахаар юм хумаа зэхэж эхлэв. Бид хоёр хэн хэн нь туйлын баяртай байсны учир гэвэл эрт орой хэзээ боловч тэднийг эгүүлэн олж авна гэж итгэж байлаа.

Одоо бид ноён Фаноны захидлын үргэлжлэлд оръё. «Би шуудан түгээгчээс, эдгээр морьдыг харсан тухайгаа хаа нэгэн газар мэдэгдсэн үү? гэж асуухад тэр бээр энэ морьд нядалгааны газраас оргосон гэдгийг тааварласан боловч хэнд ч хэлсэнгүй. Тэр бол шувуу, молтогчин туулайг ердийн сонирхлын үүднээс агнахаар явснаас биш, тэр гурван адууг нядалгааны газар эгүүлэн хүргэхэд хэн нэгэн хүнд туслахаар яваагүй ажээ. Хэрэв тэр гурван адууны нэг нь туйлын чухал амьтан байсан бөгөөд хэрэв тэр гурвыг барьж авбал шагнал өгнө гэдгийг сонсоогүй байсан бол энэ тухай чамд ч ярихгүй байсан» гэж тэр хэлжээ.

— Харин би тэр тухай бодоогүй юм байна. Шагнал байлгүй яах вэ. Наад зах нь зуун фунт стерлингийн, шагнал байх ёстой... гэж өвөө өгүүлэв.

Баярт минь, ингээд эцсийн дүнд юу болов гэвэл, ноён Фанон тэдний ул мөрийг даган км хэртэй газар хөөжээ. Тэд зүүн өмнө зүгийг барин голцуу шөнө явжээ. Дараа нь тэдний ул мөрийг бүрмөсөн алджээ. Лот голыг гаталснаас хойш тэднийг хэн ч олж харсангүй, ямар ч мэдээ сураг сонстохыг больжээ.

«Үр ашиггүй нэлээд хөөцөлдсөний дараа би ихээхэн хэмжээний газрыг хамарсан орон нутгийн үндэсний цагдаагийн газарт мэдэгдээд, Бордо хотноо өөрийн үүрэгт ажлыг гүйцэтгэхээр эргэж ирэхээс өөр аргагүй боллоо. Би Ай, Прованьс, Лион, Авиньон, Арле, Ниме, Вэзон Ромэн зэрэг мужийн эрдэмтэд, ойн цагдаа нарт захиа бичиж, тэр гурван аялагчдыг олоход бүхий л талаар туслахыг хүсэв. Тэд тусална гэж найдаж байна, профессор минь. Ямар ч байсан би таныг баяртайгаар угтан авч өөрийнхөө чадах чинээгээр бүхий л талын туслалцаа үзүүлэхэд бэлэн байна. Түүгээр ч барахгүй, тэднийг сүүлчийн удаа хүн олж харсан нөгөө гол хүртэл би таныг дагаж үйлчлэхэд бэлэн байна.

Баярт минь, одоохондоо ийм л сонинтой байна. Тахь л шархтсанаас биш тэд хоёул амьд мэнд байгаа юм байна. Нэгэнт тэд тийм хол явсныг бодоход Тахийн хөлийн шарх амархан эдгэрсэн байж

таарна гэж өвөө ярьж байна. Харин тэдэнтэй бас нэг хээр зүсний давжаа нийлжээ.

— Зам зуураасаа хань олж цуглуулсаар байгаад тахь лав сүрэг адуутай болно байх! гэж өвөө хошигнон өгүүлэв. Би өвөөг тийм хөгжилтэй байхыг хэзээ ч үзээгүй. Тахь, Давжаа хоёрыг алга болсноос хойш тэр тун цөөхөн удаа инээсэн байх. Харин одоо тэр надаар үргэлж тоглоом тохуу хийдэг болсон бөгөөд хоёр өвдгөө алгадан «Эгнэшгүй морь!» «Гайхамшигтай амьтан!» гэж бахархан дуу алдана.

Эрлээ үргэлжлүүлэхээр маргааш тэр бээр Франц руу явна. Намайг хамт авч яваач! гэж би түүнээс гуйсан боловч тэр бээр миний хичээлийг таслуулахаас болгоомжлоод зөвшөөрсөнгүй. Сүүлийн үед би голдуу сайн дүн авдаг болсон. Ялангуяа англи хэл, газар зүй, түүх, франц хэлийн хичээлүүдэд эрс сайжирсан юм. Би франц хэлийн оронд монгол хэл үзсэн болоосой гэж боддог юм. Танай нагац эгч Сэр-Одын явуулсан сурах бичгээр монгол хэл сурахыг чармайн оролдох бодолтой. Чангаар ярьж, хариулахыг чагнаж засах хүнгүй бол үг тогтооход ч бэрх байдаг. Миний ярих хэлэхийг чагнаж засаж туслах, заримдаа алдаа ташаа хэлэхийг минь шоолж суухад чи болон танай нагац эгч Сэр-Од надад туйлын их хэрэгтэй байна. Эванс ахайтай би унших туршлага хийж үзэв. Монгол үгийг дуудах гэж миний хөглөж байгааг сонсоод тэр бээр учиргүй инээдэг бөгөөд би өөрөө инээдээ барьж чадахгүй, тэгээд хоёулаа элгээ хөштөл хөхөрдөг юм. Ийм хэцүү монгол хэлээр ярьдгийг бодоход тэд цөмөөр туйлын ухаантай улс байж таарна гэж Эванс ахай ярьдаг юм.

Сонирхуулж бичих зүйл одоохондоо энэ л байна. Би туйлын их ядарлаа. Орондоо хэвтэж байгаад бичиж орхисон чинь гар бүүр хөшчихсөн байна... Бичгийн хэв муухай болсныг ч хэлээд яах вэ. Скин нохой маань нойрондоо хулган хөөж байгаа бололтой. Хачин гийнаад байна. За, баяртай.

Чиний нойрмог боловч туйлын азтай найз

Китти Жин Жемисон.

(Миний овог нэр бүтнээрээ байгаа нь энэ).

Жич: Хэрэв чи надад орчин үеийн монголын эстрадын ямар нэг дуучны пянзыг ирүүлбэл, би чамд манай дуучдаас «Том Жонс», «Ролин Стоунз», «Пинк Флойд» бас чиний хүссэн хэн нэгэн хүний дууны пянзыг явуулна.

Kummu.

Сайн байна уу, Китти!

Тахь, Давжаа хоёрын талаарх «сэтгэлийн айхавтар зовлонгоос ангижруулсан» явдалд би чамд туйлын их талархаж байна. Энэ бол маш сонин хэллэг. Хэрэв түүнийг монгол руу орчуулбал би элгээ хөштөл инээнэ. «Монголоор бол бид сэтгэлийн цангаа тайлсанд их баярлалаа» гэж хэлдэг юм. Тахь, Давжаа хоёрыг би нядалгааны газарт өнгөрнө байх! гэж бодож байсан юм.

Харин ганцхан Тахийг эрэмдэг зэрэмдэг болчхоогүй байгаа гэж сэтгэл зовж байна. Морь малд хөлөө гэмтээнэ гэдэг туйлын бэрх зовлон байдаг. Заримдаа зэрлэг адуу хөлөө гэмтээх, хугалсны дараа нэг хэсэгтээ ажрахгүй явдаг боловч сүүл сүүлдээ шаналж сульдсаар унаж тусаад бүүр босож өндийж чадахаа ч больдог явдал бий. Дараа нь, мэдээжийн хэрэг, үхдэг юм. Тахийг арай тийм байдалд хүрээгүй байх гэж найдаж байна. Хэрэв тэр зөвхөн туурайгаа гэмтээсэн бол ч амархан эдгэнэ.

Китти, одоо чамайг манай нутгийнхан андахгүй мэддэг болсныг би чамд дуулгахыг хүсэж байна. Чиний захидлыг цөм сайн мэднэ. Нагац эгч Сэр-Од чиний захидлыг монгол хэл дээр орчуулан уншихыг сонсох гэж хүмүүс манай гэрт (одоо бол зун шүү дээ) цуглардаг боллоо. Тэд заримдаа хэдэн цаг суудаг юм. Яагаад гэвэл тэд чиний захидалд бичсэн зүйлийн талаар заримдаа санал солилцох, маргалдах ч удаа бий. Хөгшчүүл барагтай бол дуугарахгүй, харин бусад нь маргаан үүсгэх их дуртай. Чиний захидлыг уншихад манай ээж туйлын дуртай, цаашаа юу болохыг нь мэдэж байгаа юм шиг үргэлж толгой дохиж суудаг юм. Ядаж нагац эгч Сэр-Одод хэлчих! гэж би гуйсан боловч ээж маань Тахийн талаарх нөгөө алдартай «нууцаа» одоо болтол тайлж хэлээгүй л байна. Аав ээж хоёр шөнө дүл болсон хойно нэг юмны тухай ярьж инээлдээд байлаа. Би түүнийг нь чагнаад ээж биднээр хэрхэн тоглоом тохуу хийсэн тухайгаа ярьж байна гэдгийг таамагласан юм. Тэр бээр тоглоом тохуу хийхдээ их дуртай. Тэр нууцыг чинь би хэзээ нэгэн цагт заавал олж мэднэ гэж намайг хэлэхэд бас намайг танай өвөө шиг даапаалан инээдэг юм.

Чиний захидлыг анхааралтай сонсож байсан хүмүүсийн дотор Улаанбаатараас ирсэн зоологийн мэргэжилтэн хоёр хүн байлаа. Танай өвөө тэдэнд Тахь алга болсон тухай бичсэн боловч тэд нарийн учрыг

олж сонсоогүй явлаа. Чиний захидлыг уншиж байхад тэдэнд учирсан явдлын талаар тэд ямар нэг зүйл тэмдэглэж байлаа.

— Китти бас чиний адил зоологийн мэргэжилтэн болох талаар бодвол яасан юм бэ? гэж нэг удаа Сэр-Од эгч хэлэв.



Зэрлэг адууны талаар ажиглалт хийхээр манай энд зоологийн мэргэжилтнүүд дандаа ирдэг юм. Одоо манай энд ууланд явдаг арав гаруй тусгай зам маршрут бий болсноос гадна адуун Сүргийг айлгаж үргээхгүйгээр эрдэмтэд ажиглалт хийхэд зориулсан таван харуулын өндөрлөг цамхаг бий болов. Манай найз Гарьд энэ маршрут замыг тогтоохоор ирэхэд нь би тусалж яваад өнгөрсөн улирлын амралтаа дуусгасан. Гарьдын тухай чи санаж байгаа биз дээ? Тэр маань одоо жинхэнэ адуучин болсон.

Адуун сүрэг энэ талаар огтхон ч сэжиг авахгүй, ууландаа тавлаг сайхан амьдарч байна. Тэр бээр одоо 26 адуу байна гэдэг тоо гаргаад байгаа бөгөөд миний бодоход хаа нэгтээ бас өөр таван адуу байх ёстой. Би анх зэрлэг адуун сүрэг үзэхдээ түүнийг тоолж, нөгөө авч одсон дөрвийг оролцуулаад гучин тав болгосон юм. Тэгэхээр одоо хорин зургаа биш, гучин нэг байх ёстой. Иймээс би нөгөө дутаад байгаа тавын хойноос эрэл сурал болж байна.

Тахийн тухайд гэвэл түүнийг та нар хэзээ барьж авсан гэж мэдээлэх бол гэж тэсэж ядан хүлээж байна. Гурав дахь нь юун адуу вэ? Европ тивд ч болов өөрийн сүрэгтэй болох санаа Тахид төрөөгүй байгаа. Харин Гарьдын ярьж байгаагаар бол энэ ч бас тийм гайхалтай хэрэг биш бололтой. Яагаад гэхээр зэрлэг адуун сүрэг мянган жилийн турш Европоос Ази, Францаас Хятад хүртэл энэ уудам нутаг дэвсгэрт нааш цааш хэрэн хэсүүчилж явсан түүхтэй ажээ.

Харин бидний хувьд гэвэл: Сүргийн дотор Тахь нэг л үгүйлэгдээд байгаа юм. Тэрхүү сүрэгт нэг сайн газарч, ирээдүйн удирдагч-азарга болох ухаантай бөгөөд зоригтой унага хараахан төрөөгүй л байна. Зарим нэг залуу үрээнүүд хөгшин азаргыг айлгах санаа байгаа боловч тахь шиг ухаалаг, зоригтой, шийдэмгий байж бас л чадахгүй байна.

Иймээс түүнийг барьж авангуутаа бидэнд мэдэгдэхийг бүү мартаарай гэж гуйя!

*Чиний найз
Баярт.*

Жич: Сэр-Од эгч надад чиний захидлыг ийнхүү уншиж, орчуулж өгч байгаа явдал нь түүний англи хэлээ баяжуулахад туйлын их ашигтай, тустай байгааг заавал бичээрэй гэсэн юм.
«Өөрөө та яагаад энэ тухайгаа бичиж болоогүй юм бэ, эсвэл өчүүхэн зурвас бичээд хавсаргаж болно шүү дээ гэж асуухад, хэрэв тэр өөрийнхөө нэрийн өмнөөс бичвэл бидний захидлыг сонирхолгүй болгоно гээд, намайг чамд ийнхүү тусалсны чинь төлөө талархал илэрхийлж өгнө үү! гэж хүссэн юм.

Б.

Сайн байна уу, Баярт аа!

Бидний харилцаа дахиад нэг хэсэг тасарчихлаа. Одоо миний хамаг бие айхавтар өвдөж байна. Учир нь би Давжаатай дандаа зугаалдаг байсан нөгөө уулын хажуу руу уначихсан юм. Би бор шувууны үүр эрж харайж (түүнийг хоослох зорилгоор биш, харин сонирхох гэж) яваад халтирч уулын хажуу руу өнхөрч бүх биеэ айхавтар зулгалсан юм. Огт зогсохгүй талийж одох нь уу гэдэг бодол ч төрж байлаа. За тэр ч яах вэ. Өвөө, юуны өмнө чухал зүйлээ ярьж бай гэдэг! Тахийг заавал олж ирнэ гэдэг итгэлтэйгээр өвөө Франц явсныг

чи санаж байгаа байх. Гэвч тэр бээр бүтэн хоёр долоо хоног морьдынхоо тухай сураг чимээ сонсох, ул мөр гаргах гэж хөөцөлдсөний эцэст сүүлийн хоёр хоногт нь тэдний явсан зүг чигийг дөнгөж тодруулжээ. Тэр бээр тэдний байгаа газрыг ч олж илрүүлж чадалгүй, гар хоосон гэртээ буцаж ирлээ.

— Нэг зэрлэгтэй хамт нийтдээ гурван морь францын нутагт ор сураггүй алга болно гэдэг бол хүний ухаанд багтамгүй зүйл юм. Энэ бол яах аргагүй Тахийн ухаан заль мөн. Тэд шөнө болохоор аялж, өдөр болохоор нуугдаж яваагаас зайлахгүй. Яаж түүнээс ийм ухаан гарч байгааг би одоо болтол бодоод ойлгохгүй байна.

Өвөө тасалгаа дотроо холхин, гар хуруугаа нужигнуулан дуугаргаж, өөрөө өөртөө уцаарлан уурлаж, өөрөө өөртэйгөө маргалдан цухалдана.

— Одоо бидэнд адуу малын эрэлчин юунаас ч эрхэм чухал байна. Ямар нэгэн адал явдал үйлдэх хөрөнгө мөнгө байхгүйгээс хойш ноён Фаноны ухаан самбаанд л найдахаас өөр арга алга.

Ноён Фанон бол терьер нохойтой төсөөтэй хүн гэж өвөө ярьдаг. «Өндөр намаараа зуун тавин см-ээс хэтрэхгүй. Туйлын эрэмгий бөгөөд шуурхай, хамт явахад ямагт хаяад явчих гээд болдоггүй. Ямар нэг зүйлийг лавлаж асуух нь үхэл ба амьдралын асуудал тулгарч байгаа мэт сэтгэгдэл төрүүлнэ. Энэ талаар эд юу ч мэдэхгүй улс байна гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой байхад ч тэр салахаа үзэхгүй. Хүмүүсийн уураг тархинд байгаа юмыг ёстой нэг хоосолж байж санаа нь амарна. Тахийг олж барих хүслэн түүнд ёстой нэг асаж байсан нь мэдээж юм».

Энэ мэтчилэн бидний мэдэж байгаа бүхэн цөм манай шинэ найз ноён Фаноны мэдээнээс үндэс авсан зүйл болно. Тахийн энэ бүх үйл явдал бол ямар нэг тодорхой зорилго агуулж байна. Үүнийг юу гэж ойлгохоо би мэдэхгүй байна. Чухам тэр нь юу гэсэн үг болохыг энэ захидлыг уншиж дууссаныхаа дараа Баярт чи л харин төсөөлж магадгүй. Түүний бичсэн нь: «Дарвуулт завь эхэлж дайвалзан мурилзаж байгаад зам шулууддаг шиг зэрлэг морь нэгэн чигийг шулуун барьж явахгүй, ийш тийш хөрөөлж буруулж яваа бололтой. Уг нь Тахид тодорхой нэгэн чиг байгаа нь илэрхий. Миний олж мэдсэнээр, тэр зүүн өмнө зүгийг хатуу барьж явсаар эцсийн бүлэгт Камаргт ирсэн байна. Камарг бол Европ тивд адуун сүрэг чөлөөтэй бэлчиж амьдардаг цорын ганц нутаг бөгөөд Францын хамгийн том

дархалсан газрын нэг юм. Камаргийн алдартай давжаа адуу энд нутагладаг.

Хөрс нь хуурай бөгөөд элсэрхэг, зарим газраа намгархаг, харин монгол адууны хамгийн дуртай хужиртай хөндий, хоолой элбэгтэй нутаг юм.

Камаргийн төв хэсэгт гурван адуу байхыг адуучны хүү харсан байна. Энэ нь чухам ямаршуу адуу байсныг адуучны хүү мэдсэн бол тэднийг хэдийнээ бариад авах байсан. Эхлээд тэр хүү тэднийг төдий сайн ажигласангүй. Холоос тэд Камаргийн давжаа адуутай адилхан харагдсан байна. Энэ бол Камаргийн хамгийн алслагдсан өнцөг буланг эргэж тойрч байдаг нутгийн адуучин хүү байжээ. Хэдэн долоо хоногийн турш, магадгүй сар ч байж мэднэ, түүний адуун сүргийн энэ тэр хэсэгтэй хамт идээшилж байгаа «Камаргийн онцгой хачин давжаа адууг» тэр олж харсан байна. Харин тэдэнд ойртон очиж чухам юун адуу байсныг нь нягтлан харж, таньж мэдэх бололцоо түүнд огтхон ч олдсонгүй.

Нэг удаа түүнд дөрвөн азарга үрээ барьж ирэхийг даалгасан тул тэр бээр араас нь гэнэдүүлэх зорилгоор намаг дундуур чигээрээ гатлан очжээ. Энэ үед маш сонин тулалдаан болж байсныг тэр бээр олж харжээ. Түүний ярьснаар «сармагчин шиг жижигхэн адуу» өөрөөсөө биеэр том нутгийн нэгэн азарга үрээтэй тулалдаж байжээ. Нэг үгээр хэлбэл, танай монголын зэрлэг үрээ камаргийн азарга үрээтэй тулалджээ. Адуучин хүү амьдралдаа хэзээ ч тийм ширүүн тулалдаан үзээгүй гэж надад хэллээ. Камаргийн адуу бол ууртай догшноороо алдартай. Гэтэл «тэр сармагчин дүртэй навтгар морь» камаргийн азарга үрээг хайр найргүй хазаж, өшиглөн, зайлж зугтах буюу зодооноо зогсоох ч зав зай өгөхгүй дайрч давшлан байжээ. Камаргийн адуу бол ялагч нь нэгэнт тодорхой болмогц зодооноо зогсдог заншилтай ажээ. Зэрлэг монгол морь өөрийнхөө хань ижлийг (Давжаа ба хээр халтар хоёрыг) хамгаалан үхлээс айхгүй тулалдсан бололтой. Камаргийн азарга үрээ найгүй доройтсон байлаа. Монгол үрээ түүнийг унагаж аваад, урд хоёр хөлөөрөө цавчиж, дэвсэлж алахаар завдан байхад адуучин хүү дэргэд нь хүрч очжээ.

Тэгэх нь ээ тэр зэрлэг адуу, адуучин хүү рүү дайрч түүний морийг хазжээ. Хэрэв тэр залуу том ташуурынхаа амтыг үзүүлээгүй бол тэр бээр дахин дайрч ч мэдэх байжээ. Тэгээд ашгүй нэг юм зайлж

оджээ. Үүнээс хойш адуучин хүү нэг ч удаа түүнийг олж хараагүй байна.

Би Камаргт бүтэн долоо хонолоо. Тэднийг олно гэж найдсан юм. Цыганууд, адуучдын гэрт хоноглож, тосгон сууринаар орж явлаа. Харамсалтай нь монгол морь түүний сүрэг ор сураггүй алга болжээ.

Дараачийн хэл мэдээг тэндээс зүүн тийшээ барагцаалбал хоёр зуун км зайтай орших Грас хотын цагдаагийн газраас авлаа. Уулархаг газрыг дамжин өнгөрсөн өндөр хүчдэлийн шугам дээр ажиллаж байсан мастер нарсан ойн цоорхойд гурван давжаа адуу наадаж тоглон идээшилж байхыг олж харжээ. Гэвч би Грас хотонд хоёр хоногийн дараа хүрэлцэн очлоо. Хүмүүс надад энэ бол гурван долоо хоногийн өмнө болсон хэрэг гэж ярилаа. Би дахиад л хэдэн долоо хоногоор хоцорлоо.

Эцсийн эцэст би Соспель хотоос холгүй орших Италийн хил дээр байдаг цэргийн харуулаас нэгэн мэдээ хүлээж авлаа.

Тэр харуулын нэгэн офицер мэдээлсэн нь: Хилийн шугамын дагуу байдаг яггүй өндөр хавцлыг давж биеэр багахан шиг гурван адуу орж ирснийг тэдний хоёр цэрэг харжээ. Цэргүүд өөрсдийн автомат винтовын алсын тусгалыг шалгаж үзэх гэж хэд хэдэн удаа буудсан байна. Буун дуу сонсоод тэдний нэг нь бараг галзуурах шахаж байжээ. Хавцлын дагуу өөд уруугаа давхиж бусдыгаа түрж түлхэн, яаруулан элдэж байсан байна. Тэр офицерын ажигласнаар тэдний нэг нь эргэж зугтахыг завдсан боловч нөгөө солиотой намхан амьтан түүний замыг хааж хөндөлдөн, хазаж хайрсаар байжээ. Ийнхүү тэр гурав Италийн талд байдаг үйсэн бөглөө хийдэг царс мод ургадаг бяцхан төгөлд ороод бараа харагдахыг больжээ.

Профессор минь, би өөрийн эрэл сурлыг аль болох алс холд хийх боловч италийн нутагт тэр маань төдий л их газар авахгүй болов уу гэж айж байна. Миний эрэл хийх боломжтой албан ёсны хязгаар бол хилийн шугам болно. Би Италид байдаг өөрийн найз нөхдийн боломжтой бүхэнтэй нь холбоо барина. Таныг ч гэсэн бас тэгж оролдоно байх гэж найдаж байна. Зэрлэг адууны нэгэнт сонгож авсан зүг чигийг л алдахгүй байх явдал бол хамгийн чухал зүйл гэж би бодож байна. Хэрэв та Итали найз нөхдөөсөө ямар нэг хэл мэдээ авбал надад заавал мэдэгдэхийг хүсье гэжээ.

Баярт минь, ноён Фаноноос одоохондоо авсан хэл мэдээ бол ердөө л энэ байна. Өвөө Италид байдаг зоологийн мэргэжил бүхий

эрдэмтдээс өөртөө тус болох хүнийг эрж олох санаатай бандгар бандгар лавлах онгичиж, газрын зураг гөлрөн ширтсээр байна.

Миний гар цуцан хурууны үзүүр чимчигнэх нь модон дээр төмөр хадаасаар юм сийлсэн шиг санагдаж байна. Би бичгийн машин цохиж чадах нь чадна. Тэгэхдээ одоохондоо төдий хурдан биш. Миний ухаан санаа надаас ямагт түрүүлчхээд байдаг болохоор машинаар удаан цохино гэдэг бүүр ч бүтэшгүй ажил юм.

Өчигдөр Эванс ахай надад «Хэрэв толгой чинь чамаас арван милийн урд түрүүлж яваагүй, мөрөн дээрээ байсан бол чи уулын уруу гулсан унаж, ингэтлээ шархдахгүй байсан сан» гэлээ.

Эванс ахайн зөв ч байж болно. За, унтах цаг маань хэдийнээ өнгөрч орхижээ. Тайван нойрсоорой!

*Чиний адгуу найз
Китти.*

Жич: Миний бодоход, Тахийн тухай танай ээжийн нууц онц сонирхолтой байна. Ээж чинь чамаар тэгж тоглоом тохуу хийж байгаа нь надад туйлын таалагдаж байна. Хэдийгээр аливаа зүйлийг урьдчилан тааварлахад бэрх байдаг боловч хэрэв би хүүхдүүдтэй болбол тэднийг элдвээр молигодож зовооно гэж боддог.

К.

Сайн байна уу, Китти!

Эцсийн эцэст бид Тахийн тухай ээжийн нууцыг хэрхэн хэлүүлж авсан тухай сонсоход чамд туйлын сонирхолтой байх нь мэдээж.

Сэр-Од эгч чиний сүүлчийн захидлыг уншиж байхад түүний хажууд сууж байсан манай ээж яг ингэнэ гэдгийг хэдийнээ мэдэж байсан юм шиг «мөндөө», «ухай» гэж уулгалж, ямагт толгой дохисоор байлаа. Энэ нь өвөө аавын уурыг ихэд хүргэсэн бөгөөд тэр бээр Сэр-Од эгчийн уншихыг зогсоож байгаад хэлсэн нь:

— Гэрэл ээ! (манай ээжийн нэр) Чи биднээс юу ч нуух ёсгүй. Хэрэв чи энэ морины учир явдлыг тийм сайн мэдэж байгаа юм бол бидэнд хэлэх хэрэгтэй. Хаанаас чи түүнийг олж мэдсэн юм бэ? Хэрэв чи бидэнд хэлэхгүй бол чамд гомдоно шүү гэв.

Өвөө бол туйлын их өтөлсөн хүн (үнэндээ ч бараг өвөөгийн өвөө юм даа) юм бүхнийг хуучнаар бодож сэтгэдэг хүн. Тэр бээр маш их сүсэг бишрэлтэй, аливаа таавар, далдын юманд туйлын дургүй. Миний бодоход, тийм юмнаас айдаг байх.

Тэгэхэд ээж зөрүү зан гаргаж, өвөөг гомдоохоос болгоомжлон уучлалт гуйгаад хэлсэн нь:

— Бааваа (өвөөг тэгж ахайлдаг) түүнийг мэдэж цөхөөд байх юу вэ, манай зэрлэг адуу нутаг руугаа л гүйж байна гэж хэдийгээр нүдэнд нь инээмсэглэл тодорч байсан боловч түвшин төлөв дуугаар өгүүлэв.

— Юу гэнээ! гэж бид гайхан дуу алдав.

— Тэр морь гэр өөдөө ирж явна. Өөрийнхөө төрөлх ууланд буцаж ирэхээр эрс шийдвэрлэжээ. Миний мэдэж байгаа зүйл энэ л байна. Бааваа! Иймээс тэр хаа ч торж хэзээ ч зогсохгүй, бүх саад бэрхшээлийг даван туулж нутагтаа ирнэ гэдэгт бат итгэж байна. Харин түүний төлөө санаа зовох хэрэггүй гэв.

Мэдээжийн хэрэг, бид тэр доороо шуугилдаж, айхавтар маргаан дэгдэв. Хивсэн дээр газрын зураг дэлгэж тавиад түүнийг тойрон бүчив. Хэрэв Тахь нутаг руугаа гүйж яваа бол тэр бээр Атлантын далайгаас Номхон дөлгөөн далай хүртэл бүх Европ, Азийг туулж мянга мянган км урт замыг туулна гэдгийг ээжид зураг дээр зааж үзүүлэв. Гэвч ээж түүнийг огтхон ч ойшоож үзсэнгүй, өөрийнхөө хэлсэн дээр хатуу зогсож: Манай зэрлэг адуу гэр өөдөө буцан ирж явна гэж давтан өгүүлэв.

Чи үүнд итгэж байна уу, Китти? Хэрэв хүний толгойд ямар нэг санаа урган төрсөн бол түүнээс салж хагацахад туйлын бэрх байдгийг хүлээхээс өөр арга алга! Гэвч би тэр тухай бодохоос ч халширч байна. Энэ талаар Гарьд юу гэж бодож байгааг үнэнээ хэлэхэд, хараахан сонирхон асууж амжаагүй байна. Энэ талаар чиний өвөө юу гэж бодож байгаа бол? Тэр тухай мэдэхийг би маш их хүсэж байна.

Ямар ч атугай, ээжийн нууц бас арай дуусаагүй байх. Ээж өөр ямар нэг нууц бас бодож олно гэдэгт би итгэж байна. Манай эндэх нэг голын хөвөөнд байгуулсан хиймэл цөөрөмд би сэлж сурч байна. Усанд сэлнэ гэдэг чинь үнэхээр тэнцвэрийн хууль мэдэх асуудал байдгийг өнөө болтол ойлгохгүй явжээ. Инженер болохоор суралцаж байгаа миний нэг ах энэ талаар их ярьдаг байсан. Хэдийгээр тэр өөрөө тэнцвэрийн хуулийг сайн мэддэг байсан ч бас сэлж чаддаггүй л юм.

Өвөө чинь юу гэж бодож байгаа тухай надад бичээрэй! Би өөрийнхөө юу гэж бодож байгааг чамаас хариу авахаас нааш огт хэлэхгүй.

Ёсолсон Баярт.

Жич: Чи шатар тоглодог уу? Өнгөрсөн долоо хоногт адуу хариулж яваад би Гарьдтай шатар тоглосон. Тэр бээр чи бид хоёрыг монгол, английн хоорондын шатрын тэмцээн явуулах нь зүйтэй гэж санал гаргав.

Б.

Сайн байна уу, Баярт аа!

Өвөөд би чиний захидлыг уншихад тахийн тухай танай ээжийн гайхамшигтай сонин таамаглалыг сонсоод түүний сэтгэл ихэд хөдлөн хоёр өвдгөө алгадан «Гайхамшигтай сонин авгай байна. Түүний хэлдэг түмэн зөв. Зэрлэг морь гэр өөдөө харьж яваа нь маргаангүй үнэн. Ийм бодол бас миний сэтгэлд ургаж байсан юм. Гэвч шинжлэх ухааны үүднээс тайлбарлахад надад хэцүү байсан юм. Харин Баяртын ээж яг оножээ» гэв.

Баярт минь, гайхаад байх зүйлгүй. Ийнхүү бүх асуудал ойлгомжтой боллоо.

— Тахь хамгийн сайн зам сонгож авсан нь чамд одоо тодорхой ойлгогдож байгаа биз дээ. Европ, Азийн хязгааргүй уудам нутагт газар сайгүй хэрэн хэсэж явсан эрт дээр үеийн адууны эцэг өвгөдийн танин мэдрэхүйн барилыг тэр яах аргагүй уламжлан авчээ гэж өвөө өгүүлэв.

— Тэр төрсөн нутагтаа очиход хэчнээн жил хэрэгтэй бол? гэж өвөө бас эргэлзсэн янзтай асуув.

— Хэн мэдэх вэ дээ? Нэг, хоёр жил. Магадгүй түүнээс ч олон жил хэрэгтэй байж мэднэ.

Баярт минь, өвөөгийн хариулт гэвэл ийм л байна. Бид бас та нарын нэгэн адил газрын зураг дэлгэж тавиад, Тахийн явах замыг тодорхойлох гэж оролдов. Бүтэн жилийн турш тэр, хүн амьтнаас зугтаж явсаар өөрийнхөө төрөлх нутагт очих уу, эсвэл түүнийг ойрын хугацаанд барьж аваад Давжаагийн хамт бидэнд эргүүлж өгөх үү? гэдэг хоёр асуудлын алинд нь илүү итгэх хэрэгтэйг би одоо болтол мэдэхгүй байна.

Мэдээжийн хэрэг би түүнтэй хамт яваа Давжаа, хээр халтар хоёрын тухай бас бодож л байна. Тэд бол хоёулаа гэрийн мал шүү дээ. Хэрэв тэд Тахийг дагаад явах юм бол Монголд хүрэхээсээ өмнө эцэж турж үхэх нь лавтай байх.

Өвөө Италийн Турин Милан, Венеци, Триестийн амьтны хүрээлэнд болон эрдэмтдэд захиа бичсэн. Мөн түүнчлэн ноён Фанонд захиа бичиж танай ээжийн хэлснийг тэр бээр юү гэж үзэж байгааг асуусан. Ноён Фанон ч гэсэн ямагт тэгж бодож байсан гэдэгт өвөө бат итгэж байгаа юм. Баярт, чи юү гэж бодож байна? Тахь төрсөн нутагтаа очиж чадах уу? Эсвэл тэр замдаа баригдаад бидэнд эргэж ирэх бол уу? Давжаа маань одоо яаж яваа бол доо? Түүнийхээ төлөө л би сэтгэл их зовж байна.

За баяртай. Чухам юу болохыг бурхан тэнгэр мэдтүгэй!
Муу л юм битгий болоосой!

*Чиний хуучин танил
Китти Ж.*

Жич: Би шатар тоглож чаддаггүй. Өвөө надад зааж өгнө гэж хэлсэн. Эванс ахай хичээлээ яая гэж байхад нь бас шатар заахтай манатай гэхэд өвөө «боль доо» гэв.

Жич: Миний бодоход Тахь төрсөн нутагтаа харьсан л дээр санагдана. Харин Давжаа яасан нь дээрийг би одоохондоо мэдэхгүй байна. Харин ганцхан хүсэх зүйл бол Давжаа минь битгий төөрчхөөсэй! Хүний нутагт ганцаараа битгий л хаягдаасай. Зам зуурт нь хүн битгий л бэртээж, шархдуулж орхиосой!

Сайн байна уу, Баярт аа!

Тахь, Давжаа, хээр халтар гурав дорно зүгт аялсан зам мөрийг гаргахад ямар бэрх байсныг чи лав төсөөлөхгүй байгаа байх.

Бид Европын үл ойлгогдох янз бүрийн хэл дээр янз бүрийн хүмүүсээс мэдээ сэлт хүлээн авсныг ашгүй нэг юм франц, итали, герман хэлээс орчуулж амжив. Тэднийг ялгаж салгах гэж хэчнээн их цагаа үрсэн гэж санана. Харин энэ бүхний үр дүнд бид тэдэнтэй тохиолдсон аймшигтай адал явдлууд, наад зах нь гурван сүрхий тохиолдлыг олж мэдлээ.


Хэргийн гол эзэн Тахь байлаа. Юу ч түүний аялах замыг саатуулж чадсангүй. Тэр бээр дахиад маш ноцтой шархадсан байна. Магадгүй, одоо үхэж байгаа ч байж мэднэ. Цаашдаа тэр бээр юунаас ч буцахгүй гэдэг нь тодорхой боллоо. Харин энэ нь юугаар төгсөхийг бүү мэд. Анхныхаа аюултай тэр бээр Италид тулгарчээ. Ноён Фанон (манай эрэлч) энэ тухай бидэнд мэдээлэв. Бордо хотын амьтны хүрээлэнгийн дарга нар тэр зэрлэг амьтан энэ сүлжсэн олон зам, ширэлдсэн олон ферм, хот, тосгоны дотор арилж утсан ба амьд үлдсэний алин болохыг мэдэх сонирхолтой байсан тул Фаноны Италид явахыг зөвшөөрсөн юм гэж бичжээ. Ноён Фаноны бичсэнээр: Тахь францын нутгийг хэрхэн дайрч өнгөрснийг тодруулахад арай хялбар байжээ. Далайн эрэг орчмын Альпын зэлүүд нутгийг тэр бээр ажиг ч үгүй туулан өнгөрчээ. Харин хүн ам шигүү суудаг бөгөөд шавааралдсан олон тосгон суурин, сүлжилдсэн олон замтай Италид тэр гурав хүний нүдэнд өртөхгүй урагш алхахад ямар бэрх байсныг чи төсөөлж байна уу?

Иймээс ноён Фанон Италид тэдний явсан замыг эхлээд ачаа тээврийн машины жолооч нараас сурвалжлан мэджээ. Тэдний зарим нь үл ойлгогдох хачин амьтад замын хажууд байхыг шөнө олж үзжээ. Жолооч нарын яриа түүнийг хойд Италийг гатлах замын тэхий дунд орших Верона хотын ойролцоо буудалласан цыганы хот айлд хөтлөн авчирчээ. «Энэ чухам хэзээ болсныг хэн ч тодорхой мэдэхгүй байна. Та нар үнэмшинэ үү, эс үнэмшинэ үү өөрөө мэд! Харин цыганууд зэрлэг үрээг барьж чадсан байна» гэж ноён Фанон бичжээ.

Тэд бол усчин цыганууд байжээ. Тэд орон нутгаар тэнүүчлэн явж тосгон ба фермийн хүмүүсийн жимсний цэцэрлэг, усан үзэм, идэшний ногооны газрыг усалж үйлчлэх ажил хийдэг байв. Тэд өөрсдийн морьд, илжигтэй байснаас гадна тэр нэгэн талд бүхээгтэй автомашин, элэгдэж хуучирсан муусайн бүхээгт чиргүүлд амьдарч байсан байна. Тэдэнд бас ямаа, нохой, сармагчин ба өөр амьтад байжээ. Баярт минь, яагаад ч юм бэ, тэд Верона хотын ойролцоох хэсэг модонд нуугдаж байгаа тэнэмэл гурван адууг олж үзсэн байна. Тэдний ярьснаар бол адуунууд том сувгийг тойрч гарах зам сүвэгчлэн хайж байсан бололтой. Энэ байдлыг ашиглаж цыганууд тэр гурвыг барьж авахаар шийдсэн байна. Адууны явж өнгөрсөн зам дээр нь тэд төмөр утсан занга тавьжээ. Тэднийг отон хүлээж байгаад шөнө буцаж ирэх үеэр нь гар чийдэнгийн гэрэл тусгах, зэс төмпөн, данх сав нүдэх зэргээр үргээсэн байна.

Давжаа, хээр халтар тэрхүү занганд давхин орж төмөр утсан торонд орооцолдон унажээ. Харин Тахь төмөр утсан тор үзмэгцээ түүний дээгүүр харайн зугтжээ.

Дараа нь цыганууд нөгөө хоёрыг төмөр утсаар хүрээлсэн түр зуурын хашаанд хийгээд энэ нь тэр хоёртоо зөв гэж боджээ.



Гэтэл шөнө тахь хүрч ирээд нөгөө утсан хашааг нь нурааж гарчээ. Гэрээсээ цыганууд гүйлдэн гарч, түүнийг барихыг оролдов.

Тэднийг ойртон ирмэгц нь тахь урдаас нь дайрч давшилна. Ийм адуу урьд өмнө огт үзээгүй тул тэд үнэхээр гайхжээ. Тахь хашааг эвдэн орж Давжааг гарган авчээ. Дараа нь хээр халтрыг гаргахаар ирэхэд нь тэр нь харин тэндээс явах төдий л дуртай биш байжээ. Тэгэхэд нь тахь түүнийг өшиглөн албадаж зугтаалгасан байна.

Цыганууд гурван адууг цөмийг нь ядаж алдахгүйн тулд хээр халтрын толгойд бугуйл чулууджээ. Гэтэл бугуйлын үзүүрээс барьсан хүн рүү тахь дайрчээ. Харамсалтай нь цыганууд түүнийг ингэнэ гэж сайн мэдэж зэхээстэй байсан тул алхаар толгойг нь цохижээ. Тахь тэрийн унажээ.

— Ай хөөрхий! Баярт минь, энэ тухай би ярьж ч зүрхлэхгүй байна. Үнэхээр аймшигтай хэрэг болох нь эргэлзээгүй билээ.

Харин ноён Фанон бичихдээ: цыганууд юу хийхээ сайн мэднэ. Тийм цохилт бол адуунд ноцтой гэмтэл учруулдаггүйг цыганууд сайн мэддэг байна гэжээ. За, ямар ч байсан, тахь хэсэг зуур ухаан алдаж унасан бөгөөд Давжаа, хээр халтар хоёр зугтжээ.

Тахийг сэргэхэд нь түүний дөрвөн хөл хүлээстэй байсан бөгөөд тэр бээр өргөст тороор хүрээлсэн нэгэн хашаанд хэвтэж байжээ. Цыганууд юуны өмнө нэгэн хувин хүйтэн ус түүний дээрээс цацжээ. Түүний ухасхийн босож дайрахыг завдах болгонд нь нэгэн хувин хүйтэн ус цацаж байсан гэнэ.

Тахь, Давжаа хоёроос салсан маань олз гэсэн янзтай хээр халтар тэр мөртөө арилж өгчээ. Харин Давжаа явсангүй. Давжаа шөнө болгон торон хашааны дэргэд ирж хөлөөрөө газар цавчлан унгалдаж байжээ. Мэдээжийн хэрэг, цыганууд түүнийг бас барьж авахыг оролдсон боловч энэ удаа Давжаа урхи торонд орохоос ухаалгаар бултаж, харанхуй тийш зугтан одсоор байжээ (Хөөрхий муу Давжааг Тахитайгаа хамт үлдсэн явдалд Баярт минь би их баяртай байна).

Цыганууд тахийг эдэлгээнд сургах гэж бүхий л хүчээр оролджээ. Харин тэгэхдээ түүний хөлийн чөдрийг огт аваагүй байна. Учир нь хэрэв түүнийг авбал тэрээр нэг бол дайрна, эсвэл торон хашаан дээгүүр харайж гарна гэдгийг тэд сайн мэдэж байжээ. Тэд нуруун дээр нь арьсан борвитой ус ачихад Тахь хазаж, хайрч тонгочоод, болохгүй бол газар хөрвөөж уул ачааг унагаана.

Цыганууд урьдын адил тахийн дээрээс хүйтэн ус цацна. Учир нь тэд тахиар ус зөөх эдэлгээний морь хийж авах гэж бодсон тул түүнийг нойтон нуруутай явахад дасгах гэж боджээ. Харин тэд санаснаас Тахид

төдий л хатуу ширүүн хандсангүй. Цыганууд тэндээс цааш нүүх болжээ. Тэд Тахийг янгинатал хүлж нэг ачааны машинд ачаад хөдөлжээ. Аз болоход тэд өөрсдийн морь, нохой, илжиг, ямааг цөмийг нь ачиж нүүх боломжгүй байсан тул хөлөөр нь туужээ. Давжаа маань Тахиас салахыг үл хүссэн тул шөнө болоход дээрх сүргийн мөрөөр даган явсаар байжээ.

Энэ удаа цыганууд өөрсдийн лагерийг нэгэн голын хөвөөн дээр байрлуулжээ. Тэд өргөст төмөр утсаар дахин хашаа хийж түүнд Тахийг байрлуулсан бөгөөд энэ удаа зөвхөн хойд хөлийг нь тушжээ. Бороотой нэгэн шөнө, цыганууд бүхээгтэй чиргүүлдээ орж хоргодсон үед их өвдсөнөөс болсон болов уу гэмээр адуу, чарлах дуу гэнэт сонсогджээ. Тэд байрнаас гүйлдэн гарахад Тахь хүзүүндээ өргөст төмөр торны тасархайтай хашааны шонгийн хоёр том баганыг чирэн явж байжээ. Цыганууд гэрэл асаан харахад тэр бээр нөгөө хүзүүн дэх төмөр утсан торноосоо ангижрахыг ихэд чармайн оролдож байснаас гадна хойд хоёр хөлийн тушаа нь тас үсэрсэн байна.

Цыганууд түүнд тулж ойртохыг төдий л их яараагүй бөгөөд нэгэнт төмөр торонд орооцолдсон тэр амьтан зугтаж чадахгүй гэж найдаж байжээ. Түүнээс гадна бас өргөст төмөр торонд шархдаж хамаг бие нь цус нөж болсны зэрэгцээгээр хөл нь сүрхий доголсон байлаа Ийм үед хамаагүй ойртож очвол түүнд бүр ч муу юм болж мэднэ гэж тэд болгоомжилжээ.

Тахь ийм байдалтай байхдаа хүртэл ойртох гэж завдсан тэдний өөдөөс дайрч давшлан хазах, хайрахыг хичээж байжээ. Тэд Тахийг бахардаж унах буюу чирч яваа шон нь ямар нэгэн юманд тээглэж зогсохыг түр хүлээзнэхээр шийджээ. Тахь нөгөө шонгоо чирсээр хагас км орчим газар явжээ.

Тахь явсаар шороон замын хажуугаар ухсан гүнзгий сувгийн ирмэг дээр тулж очсон бөгөөд цыганууд түүнийг одоо л нэг барьж авна гэж баярлажээ. Гэтэл энэ найдвар нь талаар болжээ. Тахь ийм юманд тордог амьтан биш байжээ. Түүний шарх тэсэхүйеэ их өвдөж байсан ч тахь тэсвэрлэн, харин ч улам хурдаа нэмж, төмөр утсан тор ба тэр хүнд бетон шонг чирсэн хэвээр нөгөө сувгийг харайв. Тэр суваг айхавтар гүн байсан тул тахийн чирч явсан нөгөө бетон шон, төмөр утсан тор доош унаж тээглээд тэнд мултран үлджээ. Доголон Тахь, Давжаатайгаа нийлж аваад замаар тоос татуулан одохыг гайхаж гөлөрсөн цыганууд сүүлчийн удаа харжээ. Цыганууд хөөх бэлтгэлээ хийж, морьдоо

эмээллэж байх зуур Тахь, Давжаа хоёр үзэгдэх бараагүй арилжээ. Түүнээс хойш цыганууд тэднийг огт олж харсангүй.

Мэдээжийн хэрэг, бяцхан хээр халтар чухам ясныг чи сонирхож байгаа байх. Цыганууд түүнийг өөрийн лагериас гуч орчим км-ийн зайтай явахад нь барьж авчран, ус зөөврийн морь хийж авчээ. Энэ ч нядалгааны газар мах болсноос хамаагүй дээр биз дээ? Муу Давжаа минь Тахидаа үнэнч хэвээр үлдэж, хамт оргосонд би их баярлаж байна.

Анхны адал явдал ингэж төгсжээ. Үүнээс болж Тахь ноцтой шархадсан бөгөөд алхаж гишгэхэд нь хүртэл туйлын бэрхтэй болжээ. Гэвч тэр зогсохыг үзсэнгүй гэртээ харих, Дорно зүгт аялах аянаа үргэлжлүүлсээр байжээ. Ямагт Дорно зүгийг чиглэн явжээ. Яаж ингэж зүг чигээ алдахгүй явсныг нь би огт ойлгохгүй юм. Чи үнэмшинэ үү, эс үнэмшинэ үү өөрөө мэд! Тахь, Давжаа хоёр Италийг нэвт туулж гараад Австрид иржээ. Тэд энд хоёр дахь адал явдалтайгаа учирсан байна.

Энэ удаа тэд гартаа буутай ойн цагдаатай учирсан байна.

Миний бодоход, тэдний аз нэг л дутаад байна. Итали, Австри хоёрын хилийн уулархаг хэсэгт хэдэн хонь, ямаатай нэг өвгөн малчин амьдардаг байжээ. Тэрхүү хэсэгт хилийн хяналт шалгалт төдий л хатуу бишийг ашиглан өвгөн хэдэн хонь, ямаагаа заримдаа Италийн, заримдаа Австрийн нутагт сэлгүүлэн хариулдаг байжээ. Тэр өөрөө австри хүн боловч, түүний төрөл садны зарим хүмүүс Италийн нутагт амьдардаг ажээ. Тэд энэ уулаа өөрийн орон гэр гэж үздэг бөгөөд түүний хамгийн нууц, хамгийн хэцүү зам харгуйг андахгүй мэддэг, нэг үгээр хэлбэл ёстой нүдэлчихсэн улс байжээ.

Нэгэн орой нөгөө өвгөн хонь, ямаагаа Австрийн хил рүү, уулын хамгийн айхавтар хэцүү хэсгээр нэвтрүүлэн дорно зүгт тууж явтал араас нь ямар нэг зэрлэг амьтан мөрдөн дагаад байх шиг болжээ. Харин чухам ямар амьтан яваад байгаа нь тодорхой мэдэгдэхгүй байсан гэж тэр сүүлд профессор Шмидтэд ярьсан байна (проф. Шмидт манай өвөөд тэгээд энэ тухай бичжээ). Сүүлийн жаран жилд энэ нутагт баавгай огт үзэгдээгүй бөгөөд зэрлэг гахай гэвэл аль хэдийнээ хядаж дуусгасан байжээ. Нохойныхоо ааш занг ажиглахад чоно байж магадгүй санагджээ. За, юутай ч гэсэн сүргийн хойноос ямар нэг араатан амьтан мөрдөөд байна гэдгийг хонь малынхаа үргэж байгаа байдлаас өвгөн тодорхой ойлгожээ.

Өвгөн сүргээ улам яаруулан хөөж явахдаа ямаануудын хүзүүнд зүүсэн хонхны дуунаас болоод түүний хойноос мөрдөн дагаж явсан

нөгөө амьтны хөлийн чимээг ч олж сонсохоо болив.

Яг уулын хяр дээр гараад өвгөн түүний сүргийн хойноос мөрдөн дагаад байсан нөгөө амьтдыг олж харжээ. Адууны унгалдах дуутай төсөөтэй уянгалсан урт дуу гарах чимээгээр ийш тийш хартал, уулын сэрвэн дээр сарны гэрэлд хоёр үл танигдах сэгсгэр амьтан зогсож байжээ. Харин чухам ямар гээч араатан болохыг нь таньж чадсангүй. Баярт чи, Тахь, Давжаа хоёр ер нь биеэр жижигхэн болохыг сайн мэдэж байгаа шүү дээ. Европын энэ хэсэгт ийм биеэр жижигхэн адуу огт байдаггүй юм. Тахь Давжаа хоёр тэр малчинд хачин сэгсгэр үстэй зэрлэг амьтан мэт харагджээ. Тэгэх тусмаа Тахь толгойгоо яг сэгсэрч байх үеэр нь олж харжээ. Өвгөн хоньчин өөртөө ба сүрэгтээ аюул учруулах асар том хоёр чоно ирээд зогсож байна гэж ухаан сүнсгүй айж, хонь малаа орхин, уулын уруу, Австрийн ойн цагдаагийн бяцхан байшингийн зүг хар эрчээрээ гүйжээ.

— Юу болов? гэж цагдаа асуухад (энэ бол шөнө болсон үе билээ) өвгөн сандарч:

— Чоно, чоно! Би хэдэн хонь ямаагаа нохойдоо даатгаад орхичихлоо. Бушуулаарай, буугаа аваарай! гэж хашхирав.

Хэдийгээр өлсөж гурайтсан чоно хааяа Италийн талаас Каринтийн энэ хэсэгт хүрэлцэн ирж, хүн рүү дайрах явдал үзэгддэг боловч ойн цагдаа, өвгөний хэлсэнд төдий л итгэсэнгүй. Ойн цагдаа гутлаа өмсөөд, харанхуйд өвгөн хоньчныг даган алхжээ.

Эргэж ирэхэд энд тэндгүй үргэж тарсан хонины дунд хэдэн чоно зогсож байна гэж өвгөн хоньчин төсөөлөн бодож явжээ. Гэтэл харин тийм биш, нэгэн жалгад хуран бөөгнөрсөн хонийг ноход нь тойрон хуцаж байлаа. Ямар нэгэн чоно огт байсангүй, тэднийг ингэтэл айлган сандаргасан гол буруутан болох нөгөө Тахь, Давжаа хоёр ч алга болсон байжээ.

Айж үргэсэн хонь мал, хуцаж байгаа нохойны байдлаас үзвэл ойр орчинд ямар нэг зэрлэг араатан байна гэж ойн цагдаа тааварлажээ. Эцсийн бүлэгт өвгөн хоньчны үгэнд итгэж, чоно байгаа газрыг эрж олохоор шийджээ. Харин өвгөн хоньчин, юуны өмнө, хонь малаа аюул осолгүй газар олж хотлуулахаар тууж одов.

Би өвөөгөөс яагаад тахь тэр хоньчин ба сүргийг мөрдөн дагасан юм бэ? гэж асуув. Тахь нэвтрэхэд бэрхтэй даваатай тулгармагц хонь, ямааны мөрөөр хөөвөл нэг учир олдono гэдгийг өөрийн зэрлэг удмын совин таавраар ухаарч мэдсэн байна. Зэрлэг араатанд ийм нэг чанар

байдаг гэж өвөө хэлэв. Иймээс Тахь, Давжаа хоёр сүргийн хойноос хол зайтай бараадан дагаж явсан байна. Ойн цагдаа сарны гэрэлд тэднийг анх олж хараад сүрхий зэвүүцсэнээр барахгүй, чухам ямар амьтан болохыг нь таньж чадсангүй. Зэрлэг амьтан л болсон хойно аюултай байж таарна гэж боджээ.

Уулын зөрөг зам хоёр том хадан хясааны хоорондуур орж нарийсдаг хэсэгт нэгэн том хадны ард ойн цагдаа орж нуугдан, буугаа зэхэж суужээ. Зам дээр нөгөө хоёр «араатан» гараад ирмэгц нь нэгийг нь онилон шагайв. Гэвч яг энэ мөчид, өөрсдийгөө буудах гэж байна гэж тэр «араатнууд» мэдсэн юм шиг гэнэт ухасхийн хурдлав. Буудаад оносонгүй. Ойн цагдаа дахин буудахад тэр хоёр уулын хяр руу пажигнан давхиж буухдаа өвгөний хэдэн хонь, ямааг үргээн хөөжээ. Дараа нь тэд уулын хажуугийн өтгөн нарсан шугуйд шурган нуугджээ.

Хоньчин ба ойн цагдаад тэд дахин огт үзэгдээгүй гэнэ.

Дараа өдөр нь ойн цагдаа хоёр «зэрлэг араатан» үзсэн сонирхолтой явдлынхаа тухай Линце хотын ойн аж ахуйг удирдах газарт мэдээлсэн байна. Ойн цагдаа, хоньчин хоёр юу үзсэн тухай тэндхийн ажилтнуудын нэг нь уртаас урт илтгэл бичжээ. Энэ илтгэл нь эцсийн эцэст Вена хотноо суудаг профессор Шмидтийн гарт оржээ. Тэр бээр ойн цагдаа, малчин хоёрын аль алинтай уулзаж учир явдлыг тодруулаад тэр тухайгаа манай өвөөд бичсэн юм. Нөгөө илтгэлийн нэг хувь Вена хотын их сургуулийн зоологийн нийгэмлэгт ажилладаг үл таних доктор Шульц гэдэг хүнд бас очжээ. Харин энэ нь тэдэнд учирсан гурав дахь адал явдлын шалтгаан болжээ. Ямар нэг үл танигдах зэрлэг араатан түүгээр өнгөрч гэж доктор Шульц тааварлаад анчин хүний хувьд тэднийг мөрдөн хөөхөөр явжээ. Өвөөд бичсэн захидалдаа, нөгөө танай эрдэмтэд тахийг анх барихад хэрэглэсний адил нойрсуулагч сумаар тахийг буудахаар төлөвлөж байна гэж тэр өгүүлжээ. Харин өвөө надад ярихдаа: Энэ бол зэрлэг амьтныг барьж авах шилдэг арга огт биш гэлээ. Яагаад гэвэл зөвхөн туршлагатай буудагч л хэрэгтэй газрыг нь оноож чадахаар барахгүй, нойрсуулагч сум дэндүү лав тусах, шарх олсон амьтан унахдаа хөлөө, заримдаа хүзүүгээ ч хуга дарж унах явдал гардаг гэнэ. Иймээс би доктор Шульцийн нойрсуулагч сумаар буудна гэсэн захидлыг уншсанаас хойш нэг л зүрх түгшиж, санаа сэтгэлээр уналтын байдалд ороод байна. Тахид тэр ямар ч хор уршиг учруулахгүй, тэр унаж хүзүүгээ хугалахгүй, чи юундаа уйлж унжаад байгаа юм бэ? гэж өвөө намайг

зэмлэж, элдвээр тайвшруулахыг оролдоно. Хэрэв тахь хүзүүгээ хугалдаггүй юмаа гэж бодоход тэд тахийг бариад авахаар нөгөө муу Давжаа маань яах болж байна? Тахийг л барьж авбал Давжаа яасан ч яамай гэж та бодож байна уу? гэж би уулгалан чарлав.

Энэ бол тэнэг хэрэг гэдгийг би сайн мэдэж байна. Гэхдээ яагаад ч юм бэ, бүү мэд, доктор Шульц эхнээсээ л надад нэг таалагдаагүй байгаа юм. Тэр Давжаад ямар нэг хор учруулдаггүй юмаа гэхэд, түүнийг зүгээр хөөчихвөл яана.

Өвөө бид хоёрын маргааныг Эванс ахай сонсоод, түүнийг аливаа юманд ямагт тоомсоргүй, анхаарал халамж муутай байдаг гэж зэмлэв. Ийнхүү тэр хоёр үгээр толхилцож, нөгөө бие биедээ үргэлж хэлдэг «утгагүй юм» гэдэг үгээ хэрэглэж эхлэхэд нь харин би тэр хоёрыг эвлэрүүлэхэд хүрэв. Ингэснээрээ өөрөө ч тайвширлаа.

Өвөө бас сэтгэл түгшиж эхлэв. Учир нь доктор Шульц Зүүн Африкт олон жил суусан хүн. Түүнийг эрдэмтэн гэж хүн мэдэхээсээ анчин гэж илүү мэддэг. Энэ бүхнийг өвөө гэнэт санаад сэтгэл нь зовжээ.

— Түүнийг би юм алах дуртай хүн гэж хэлж чадахгүй. Гэхдээ тэр бол араатан амьтныг анчны хорхойтойгоор мөрдөн хөөх дуртай нь мэдээж. Тахийг шинжлэх ухааны зорилгоор барихаасаа Европт ирсэн зэрлэг адууг мөрдөн хөөх нь түүнд илүү сонирхолтой байгаа нь эргэлзээгүй гэж өвөө өгүүлэв.

Доктор Шульцаас бидний хүлээн авсан анхны мэдээнд: Тэрээр Тахь, Давжаа хоёрыг Австри, Унгарын хил залгах нутгаас хэдхэн км-ийн зайд очтол мөрдөн хөөсөн тухай дурдсан байлаа. Тахь бүх Австрийг нэвт туулаад бараг зүүн Европт хүрч очсон байна. Тэр бээр урьдын адил Дорно зүгийг чиглэн явсаар байна. Доктор Шульцын бичсэнээр тэр хоёр ийш тийш хөрөөдөн хөлхсөн маш сонин замаар явж байгаа ажээ (Ноён Фанон бас үүний урьд ингэж бичиж байсныг чи санаж байна уу). Харин нэг зүйлийг нэмэн тодруулсан нь тэд одоо өндөр уулаар дамжих биш, харин тал хөндийг барин аяллаа үргэлжлүүлж байна гэнэ.

— Энэ яагаад вэ? гэвэл нөгөө өргөст төмөр торноос авсан шарх нь тахийг улам улам шаналгаж байгаа, эсвэл ойн цагдаа нэмэн шархдуулсан ч байж болох юм гэж өвөө өгүүлнэ.

Доктор Шульц зэрлэг шувуу агнахаар яваа юм шиг тэдний хойноос мөрдөн мөшгөх аяллаа мөн үргэлжлүүлсээр байгаа гэнэ. Нэг

удаа зөөлөн бөгөөд нойтон хөрсөн дээр тэдний явсан мөр, шинэхэн баас байхыг олж үзсэн байна. Эцэст нь үдшийн бүрий болж байх үеэр тэдний барааг дурангаар олж харсан байна. Тэд Австри, Унгарын хилээс хол биш нэгэн уулын хөндийд орхигдсон алимын цэцэрлэгийн нэгэн үзүүрт хэвтэж байжээ.

Доктор Шульц, тэр бээр зүүн Африкт байхдаа сурсан бүх арга залиа хэрэглэн байж тэдэнд аль болохоор ойртож очихыг хичээсэн гэж бичжээ. Гол нь анчны бүх заавар дүрмийг баримтлахдаа биш тэдэнд тавь, жаран метрийн зайд ойртон очихын тулд биеэ үзүүлэхгүй, салхи авхуулахгүй, өчүүхэн ч анир чимээ гаргахгүй мярааж дөхөх хэрэгтэй байлаа гэж тэр бичжээ. Нойрсуулагч сумаар холын зайд буудаж болдоггүйг чи сайн мэднэ шүү дээ.

Зуухан метр урагш дөхөхийн тулд бүтэн цаг зарцуулж байсан гэж тэр бичжээ. Харин тахийг тэр маш сайн ажиглажээ. Тахийн үс ноолуур нь намрын байдлаар сэгсийж ургаснаас гадна дэл сүүл нь газар шүргэм унжжээ. Түүний бие эрүүл биш, тамир тэнхээ суларсан нь харваас илэрхий байжээ. Харин Давжаа ер бусын эрүүл саруул байдалтай байжээ. Түүний үс нь нягт бөгөөд сорлог харагджээ. Тахь нь зогсоогоор унтаж, Давжаа нь харуулд гарсан байдалтай байжээ.

Доктор Шульцад энэ үе хамгийн тохиромжтой мөч санагджээ. Учир юү гэвэл, гүү нь морийг бодвол соргог биш байдаг гэнэ. Дахиад зуун метр ойртвол тэрээр буудах бололцоотой болох байжээ. Гэвч Давжаа сэжиг авсан янзтай байжээ. Доктор Шульц тэдэнд тавин метрийн зайнд ойртож очихын тулд дахиад хагас цагийн хугацаа хэрэгтэй байжээ. Тэр бээр эцсийн эцэст боломжийн газар очсон боловч бууныхаа замгийг сойж бэлтгээгүй болохоо ухаарчээ. Замаг сойх чимээгээр Тахь сэржээ. Харамсалтай нь доктор Шульцад тухтайхан шагайх ч цаг олдсонгүй, тэр бээр давхиут дунд нь бууджээ. Гэвч тэр бээр нойрсуулагч сум тахийн зүүн мөрөн тушаа туссан гэдэгт бүрэн итгэжээ. Хэдийгээр харанхуй бүрэнхий болж байсан боловч Тахь нэг удаа зогтусан чичрэхийг тэр бээр ажиглажээ. Тэгсэн мөртөө цэцэрлэг дундуур тэр хоёр давхин далд оржээ.

Тахь хол явж чадахгүй гэдгийг доктор Шульц сайн мэдэж байсан учир огтхон ч яарсангүй. Тахь тавин метр хэртэй давхиад ухаан алдан унах ёстой байжээ. Хамгийн ойрхны тосгон гурван км-ийн зайтай байжээ. Доктор тэнд очиж Тахийг ачих ачааны машин хөлсөлж авахаар шийджээ. Тэр бээр тахийг ухаангүй байхад нь хөл хүлэх олс өөрөө авч

гарсан байжээ. Энэ нь үдшийн бүрэнхий болсон үе байсан тул эхлээд цэцэрлэг дундуур орж, гэрэл тусган тахийг олж авахаар шийджээ. Өөрийнхөө огт алдаагүй гэдэгт бүрэн итгэсэн доктор тавин метр яваад ч, зуун метр яваад ч тахь огт унаагүй байхыг олж мэдмэгцээ туйлын их гайхжээ.

Тахь ердөө ч унаагүй байжээ. Яагаад тэр билээ?

Доктор Шульц огт ойлгосонгүй. Дараа нь бүхэл өдөржин эрэл хайгуул хийсэн боловч Тахь, Давжаа хоёрын сургийг ч гаргаж чадсангүй. Тэр ч байтугай, тэдний ул мөрийг ч олж үзсэнгүй. Энэ хавийн газрын хөрс хатуу бөгөөд хуурай байсны зэрэгцээгээр хажуу талаас нь өндөр хадан хясаа шахсан байжээ. Бодвол, тэд эцсийн хүч тэнхээгээ шавхан тэр өндөр өөд авирч цааш алга болсноос зайлахгүй ажээ.

Доктор Шульцын бидэнд мэдээлсэн зүйл ердөө л энэ байна. Тахь тэрхүү нойрсуулагч сумын хамт уул хадыг дамжин улам цаашлан оджээ. Нойрсуулагч эм яагаад түүнд нөлөөлсөнгүй вэ? гэж чи асуух байх (энэ асуудлыг хүн бүхэн тавиад байгаа юм). Өвөөгийн бодож байгаагаар бол түүний сахлаг зузаан үс ноос нь түүнийг аварсан бололтой. Гэвч би үүнд итгэхгүй байна. Магадгүй түүнд хүний нүднээс далд, тохиромжтой газарт очиж унах тийм зориг тэвчээр байсан ч байж болно. Эсвэл тэр бээр өндөр ууланд авирч гараад, тэндээ үхсэн ч байж мэднэ. Магадгүй, доктор Шульц түүнийг алчхаад дараа нь Тахь алга болсон гэсэн яриа тараасан ч юм билүү? Намайг ингэж ярихад өвөө маш их уурладаг юм. Тэдний талаар мэдэж байгаа бүх зүйл маань энэ байна. Хэрвээ Тахь амьтан хүнгүй зэлүүд уулын тагт гараад үхчхээгүй бол тэд аян замаа үргэлжлүүлж байгаа нь лавтай.

Манай өвөө Унгарын бүх зоологийн нийгэмлэгт тэр хоёр адууг эрж сурвалжлахыг хүссэн захидал илгээсэн билээ.

Баяртаа, хэрэв тахь цаашид явах чадал тэнхээтэй байгаа бол нутгаа хүртэл хэдий чинээн удаан явна гэж чи бодож байна? Одоо бол би Тахийг хэн нэгэн хүн барьж аваад, түүнд эмнэлгийн тусламж үзүүлээсэй! гэж л хүсэж байна. Өөрөөр яах вэ дээ...

Эванс ахай намайг өргөст хэмх, улаан лоольтой хольж дарахад туслуулахаар дуудаж байна. Халуун ногооны хурц үнэр хамар цоргиж байна. Бид та бүхэнд хамгийн том мэндчилгээ, хамгийн сайн сайхныг бэлгэдсэн ерөөл дэвшүүлж байна. Баяртаа, хэрэв би өөр ямар нэгэн шинэ мэдээ сонсвол чамд яаралтай захиа бичнэ.

*Чиний эртний танил найз,
Китти.*

Жич: Нэмж хэлэх зүйл алга. Яарч байна. Эванс ахайн цуутай
дарсан өргөст хэмхэд би туйлын их дуртай.

К.

Сайн байна уу, Китти!

Сэр-Од эгч чиний захидлыг уншиж өгөхөд бид цөм чамтай санал нийлэв. Одоо юуны өмнө Тахийг барьж авч, тэдний аяллыг зогсоох хэрэгтэй. Тэгэхгүй бол Тахь өөрийгөө ба Давжааг үхэлд учруулж мэднэ. Харин бид, Китти минь, Тахиар бахархахгүй байж хэрхэвч чадахгүй. Манай аав туж толгой сэгсэрч, «Жинхэнэ адууны унага! Тэр нутаг өөдөө зогсолтгүй тэмүүлнэ. Амиа алдахаас нааш хэзээ ч бууж өгөхгүй. Зөвхөн монгол морь л үүнийг хийж чадна» гэж дуу алдана.

Тэгэхэд нь ээж Давжаа монгол морь биш ч гэсэн бас л хамт явсаар байна шүү дээ гэж сануулав. Дараа нь ээж нэмж хэлсэн нь «Магадгүй, зөвхөн английн бяцхан байдас л өөрийнхөө хань ижилд ийм үнэнч байдаг байж мэднэ» гэв.

Ямар ч байсан, би Тахийг үхсэн гэхэд итгэхгүй байна. Тэр бээр үхэлд хэзээ ч бууж өгөхгүй. Хаа нэгэн газарт амьд мэнд яваа л байх. Чухам хаа явааг нь мэдэхгүй байна.

Одоохондоо газрын зураг хараад л, энэ явдал сайнаар төгсөнө гэдэгт найдаад л сууж байхаас өөр арга алга.

Манайхан та нарт мэндчилгээ дэвшүүлж байна. Харин ээж урьдын адил Эванс авгайд онцгой том мэнд дамжуулж байна.

Чиний хэзээний найз

Баярт.

Жич: Надад ч бас нэмж хэлэх юм алга! Ерөнхийдөө нэг л уйтгартай байна. Тийм биз дээ? Нэмж бичих зүйл одоохондоо алга.

Б.

Сайн байна уу, Баярт аа!

Үүнд огт үнэмшихийн арга алга! Үнэхээр ер бусын тохиолдол. Дөрвөн сарын дараа бид Унгараас нэг мэдээ аваад, өвөө Будапешт орохоор яаралтай ниссэн юм. Тэр бээр одоо эргээд ирсэн. Харин би чамд шууд үнэнийг хэлэх хэрэгтэй байна. Харамсалтай нь тэр бээр Тахь, Давжаа хоёрыг авчирсангүй. Түүний оронд харин нэг урт, захиа авчирлаа. Тэр хоёрт юу тохиолдсоныг энэ захидалд өгүүлжээ.

Энэ захидлыг Като Кошут гэдэг нэртэй унгар охин бичсэн байна. Чи түүнийг өөрөө уншвал дээр биз. Иймээс Свонсийн их сургуульд хийсэн уул захидлын орчуулгын гэрэл зургийн хуулбарыг энд хавсаргав.


Эрхэм найз Китти Жемисон (тэр охин миний нэрийг Жамансон гэж дуудсан байна). Танай өвөө надад чиний бяцхан Давжаа, түүний найз зэрлэг азарга үрээ Тахийн тухай тодорхой ярьж өглөө. Энэ хоёр адууг анх хэрхэн олж үзсэн тухайгаа болон аливаа ер бусын сонин тохиолдолд хэрхэн ханддагаа чамд ойлгуулахын тулд би энэ захидлыг бичиж сууна.

Би бол унгар охин. Намайг Като Кошут гэдэг. Би эцэг эхтэйгээ хамт суудаг. Гэхдээ би гэртээ байнга суудаггүй. Яагаад гэвэл манай эцэг эх «Шапито» хэмээх нүүдлийн циркт ажилладаг учир бид бүх унгарын нутгаар өвөл, зунгүй үргэлж аялж явдаг юм. Манай цирк нь модон морь, цагариг шидэх, савлуур, буудлагын газар зэрэг биеийн тамирын янз бүрийн тоглоом наадам явуулах газартайгаас гадна акробатчин, бөхчүүл, хүндийг өргөгч зэрэг төрөл бүрийн мэргэжлийн жүжигчидтэй юм.

Манай нүүдлийн цирк маш эртний түүхтэй. Өвөөгийн өвөөгөөс эхлээд манайхан энэ циркт хэдэн зуун жилийн турш ажиллаж ирсэн юм. Энэ бол унгарт туйлын нэртэй цуутай цирк. Жил бүр янз бүрийн тосгоноос өдий төдий захидал урилга ирүүлж, биднийг үндэсний баяр, шашны баяр тохиолдуулан очиж тоглохыг урьдаг юм. Гэвч бид өөрийн тогтмол явдаг зам маршрут, өөрийн тодорхой хөтөлбөртэй тул тэр болгоны хүсэлтийг биелүүлж чаддаггүй юм.

Одоо бид сайхан амьдарч байна. Яагаад гэвэл, юм бүхэн төдий л үнэтэй биш, татвар төлөх нь багассан. Биднийг урьдын адил муусайн цыганууд гэж нүд үзүүлэж үзэхийг больсон. Биднийг аль дуртай

газраа очиж тоглохыг зөвшөөрдөг. Харин ганцхан бохир буюу шатах, тэсрэх аюултай зүйлийг циркт байлгахыг хориглодог юм. Манай циркийн бүх юм нь цэвэр цэмцгэр байдаг. Бид сургуульд сурдаг. Долоо хоногийн дөрвөн өдөр нь өглөө, хоёр өдөр нь оройн цагаар хичээллэдэг. Дараачийн жилээс би англи хэл үзэж эхэлнэ. Миний ах улсын циркийн сургуульд хэдийнээ ороод сурч байгаа.



Бидний ямар их зав муутай байдгийг чи өөрөө ойлгож байгаа биз дээ. Унгарын бараг бүх хот, тосгон, зам харгуйг бид сайн мэднэ. Тэд цөм биднийг андахгүй.

За, өөрсдийнхөө тухай яриаг азная. Одоо би чамд Давжаа болон Тахь хэмээх нэртэй зэрлэг морины тухай ярьж өгье.

Ийм хэрэг боллоо. Нэг удаа манай цирк Жиль хэмээх нэртэй тосгонд хүрэлцэн очив. Биднийг очихоос хэдэн долоо хоногийн өмнө тэр тосгоны хүмүүс нэг л өнчирсөн байртай, сэгсийж сагсайсан хачин атлаа хөөрхөн амьтныг барьж авсан байлаа. Тэр нутгийнхан урьд өмнө иймэрхүү давжаа адуу огт үзээгүй байжээ. Тэр тосгоноос хааш хаашаа тавин км-ийн дотор хэн ч түүнийг танихгүй, хэний адуу болохыг ч мэдэхгүй байсан тул түүнийг манай циркийн адуу гэж хүмүүс боджээ.

Тэд зөвхөн биднийг л давжаа адуу хэрэглэдэг гэж ойлгожээ (Бид давжаа морийг хүүхэд унуулж зугаацуулахад хэрэглэдэг юм).

Жиль тосгоны хүмүүс түүнийг жимсний хайрцаг үйлдвэрлэдэг орон нутгийн нэгэн фабрикийн арын өндөр хана хэрэм бүхий хашаанд агуулж байжээ. Манай аав түүнийг үзээд, бидний адуу биш гэж хэлсний дараа түүнийг хэрхэх тухай тус тосгоны хүмүүсийн дунд сүрхий маргаан дэгджээ. Янз бүрийн л санал гарчээ. Тэдний олонх нь хэрэв манай циркт хэрэгцээтэй бол энэ адууг бидэнд өгөх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлжээ.

— Хэн бүхэнд найз хэрэгтэй байдаг шиг адуунд бас найз хэрэгтэй. Энэ жижигхэн хөөрхөн адуу манай фермийн ясархаг хөгшин адуунуудын дунд биш өөртэйгөө ижилхэн циркийн жижигхэн адууны дунд байвал юутай тааламжтай байх вэ? Адаглаад, энэ адуунд цаана нь эзэн байдаг юмаа гэхэд газар сайгүй хэсэж явдаг Кошутынхан түүнд нь олгож өгөхөд амар. Түүнээс гадна энэ жижигхэн байдсыг унгарын бүх хүүхдүүд унаж, баясаж, хөгжиж болно гэдгийг бодох хэрэгтэй. Иймээс үүнийг циркт өгөх нь зүйтэй гэж тосгоны дарга хэлжээ. Ийнхүү манай гэр бүлд энэ бяцхан байдас олдсон юм. Энэ бол чиний нөгөө Шотланд давжаа байсан гэдгийг чи тааварлаж байгаа биз дээ. Бас тосгоны дарга бидэнд лав энэ нь зэрлэг адуу байх. Өөртөө хэнийг ч ойртуулахгүйгээр барахгүй, биедээ олс дээс хүргүүлэхгүй байна. Болгоомжтой бай! гэж анхааруулав. Хүүхэд унуулахаасаа наана удаан хугацаанд түүнийг сайн номхруулах, зүгшрүүлэх хэрэгтэй амьтан байна гэж манай аав хэлсэн юм. Харин манай гэр бүл бол үеэс үе уламжлан морь сургаж ирсэн туршлагатай тул түүнийг сургахад төдий л төвөгтэй биш гэж бодсон юм. Гэтэл үнэндээ бидний бодож байснаас нэлээд хэцүү байлаа. Давжаа хэний ч эрхшээлд орохгүй, түүний нуруун дээр олс хаях гэж оролдсон хүн рүү дайрах, тангарах зэргээр туйлж байлаа. Хүн бүхэн түүнийг ямар нэг зэрлэг сүргээс тасарсан байдас гэж бодож байлаа.

«Үгүй байлаа. Энэ уг нь гэрийн мал байсан бололтой. Гэрийн малын харц шал өөр байдаг юм. Үүний харцны төрх арай л зэрлэг биш» гэж аав хэлэв. Намайг түүнд ойртож очихыг хориглодог байлаа. Манайхан циркийнхээ тоног төхөөрөмжийг угсарч байх үеэр би явган хаалганы дэргэд зогсоод түүнийг харж байлаа. Гэнэт тэр миний дэргэд ирж, тоглож байгаа байртай хоншоороороо нэг нударч үзэв. Яг л манай давжаа адуунуудтай адил юм. Би түүнийг илбэж таалаад, дараа нь чихний нь арыг маажихад тэр туйлын таатай байлаа. Байрыг нь

ажиглавал намайг дэргэдээ байлгах дуртай байх шиг байсан. Үүнд би туйлын их баяр хөөр болж, сүмийн өмнөх талбай дээр циркээ байрлуулж байхад өөрийнхөн дээрээ хар гүйхээрээ очиж, энэ бүхний тухай эцэгтээ ярилаа. Нүүдлийн циркээ байрлуулж дуусаад, аав бид хоёр фабрикийн хашаанд очив. Өөрөө нэлээн зайдуу зогсож, намайг явган хаалганы дэргэд очуулав. Давжаа над руу давхин ирж хайсны завсраар хошуугаа шургуулахыг оролдов.

— Като, явган хаалгаа онгойлгоод ор! гэж араас аав хашхирав.

Би хашаанд орлоо. Давжаа шууд миний дэргэд ирж, хошуугаараа нүдчин, хашаан дотуур миний хойноос салахгүй мөрдөн дагасаар байлаа. «Үүний эзэн нь лав чам шиг нэг охин байснаас гарахгүй» гэж эцэг хэлэв. Харин манай аавыг хашаанд ороод ирэхээр, Давжаа дахин надаас холдож ууртай нь аргагүй толгой сэгсрэв.

Бүх юм үүнээс эхэллээ. Түүнд ойртож чаддаг цорын ганц хүн нь би боллоо. Би түүнийг Куду гэж нэрлэсэн юм. Манайхан адгуусан амьтныг өхөөрдөхөөрөө ингэж нэрлэдэг юм. Одоо бол түүнийг Давжаа гэж нэрлэнэ. Намайг бол яаж ч байсан Давжаа огт хөдлөхгүй. Би түүнийг аргамжаар тойруулан хүлнэ. Нуруун дээр нь бяцхан эмээл тохно. Харин одоохондоо би унаж зүрхлээгүй байгаа. Тэр бээр манай бусад адуутай ойртох тун дургүй. Хотын хүмүүс зөвшөөрсөн бяцхан шанданд бусад адууны хамт түүнийг бэлчээх гэж оролдсон боловч бүтсэнгүй. Тэр бээр хавьтсан ойртсоноо хазаж, хайраад тэднээс өөрөө зайлж зугтана. Манай эцэг адууны занг маш сайн мэддэг хүн. Энэ бол бас учиртай юм байна гэдгийг ажигласан байв.

— Мэдээжийн хэрэг, хаа нэгтээ ойр хавьд үүний хань ижил буюу азарга нь байна. Тиймээс энэ нь өөр адуу малтай хамт бэлчихийг хүсэхгүй байна. Ямар нэг өөр адуунаас салж хагацах дургүй байгаа нь ойлгомжтой гэв.

Маргааш өглөө нь босоход шөнөдөө өнгөцхөн царцаж хөлдсөн газрын хөрсийг өтгөн манан бүрхсэн байлаа. Манай аав, ах хоёр биднийг унтаж байхад Давжааг хашаанаас гарган сул тавьжээ. Эхлээд хаа очихоо мэдэхгүй байгаа бололтой нэлээд эргэлдэж байснаа тосгоноос гарсан нэгэн шороон замаар шууд хатиран оджээ. Аав, ах хоёр морио эмээллэж унаад хойноос нь морджээ. Давжаа хагас цаг хэртэй яваад нэгэн хоолой дахь хэсэг мод руу оржээ. Тэр моддын дээгүүр төмөр замын урт гүүр хөндлөн гарсан байжээ. Давжаа гүүрэн доор давхиж орон хэд янцгаагаад хүлгэлзэв. Гэтэл хаанаас гарч ирсэн

нь үл мэдэгдэх нэг адуу түүн дээр хүрч ирэхийг аав ах хоёр харжээ. Бодвол тэр гүүрний нуман тулгууруудын нэгний дор нуугдаж байснаас зайлсангүй. Энэ нь туйлын сульдаж доройтсон, өвчтэй адуу болох нь түүний арай чамай хөдөлж цөхөж байгаагаас ойлгомжтой байлаа. Манай аав урьд өмнө тийм адуу үзээгүй байжээ. Эхлээд энэ бол бие бялдар жижигтэй луус ч, эсвэл зэрлэг илжиг байна гэж боджээ. Бүүр нарийвчлан сайн ажигласны эцэст, жинхэнэ адуу мөн байна, гэхдээ айхавтар хүнд шархадсан, өвчилсөн мал байна гэдгийг нь ойлгожээ. Хэдийгээр тэнд өвс ус элбэг байсан боловч тэр нь ясан хэдрэг болтлоо эдлэгдсэн, яс арьс болтлоо турж эцсэн байлаа. Тэр нь зогсож ядан байлаа.

Эцэг маань намайг аваад ир! гээд ахыг явуулжээ. Би сур аргамж аваад ачааны машинаар очлоо. Давжаа хөдлөхгүй бөгөөд сүүлд миний Тахь гэдгийг нь олж мэдсэн нөгөө адуунд ойртож очихгүй байлаа.

— Миний охин, Кудугаа дагуулаад яв! Нөгөө адуу нь түүнийг дагаж магадгүй! гэж аав хэлэв.

— Заа! гэж би хариулав.

— Като, би урьд өмнө ийм адууг огт үзээгүй юм байна. Наадах чинь зэрлэг байж мэднэ шүү. Болгоомжтой байгаарай! гэж аав надад анхааруулав. Давжаагаа ногтолж аваад хөтөл! гэж аав хэлсэн бөгөөд намайг очиж ногтлоход Давжаа огт хөдөлсөнгүй. Харин түүнийг хөтлөөд явахад, хойноосоо нөгөө адууг дагав уу, үгүй юү гэх шиг үргэлж эргэн эргэн харна.

Зэрлэг адуу нь л зогсвол Давжаа зогсчхоод явахгүй байлаа. Энэ мэтчилэн аргаар оролдож, алхам алхмаар урагшлуулан замд оруулж, бас цааш ахин дөхсөөр явж арай чамай тосгоны захад хүрч ирлээ. Тосгоны яг дэргэд хүрч ирээд зэрлэг морь тэрийн уналаа. Тэр бээр хэт доор орсон тул цааш явж чадахгүй болжээ. Давжаа буцаж очоод түүний дэргэд зогслоо.

Бид тэр тосгонд дахиад хоёр хоносон бөгөөд харин тэр зэрлэг морь нөгөө л газраа босож чадахгүй, хэвтсээр л байлаа. Манай эцэг бүх морьдоо тууж аваачин түүний дэргэд зогсооход, тэд туйлын дургүй байжээ. Үүнийг зэрлэг адуу гэж мэдээд эд ийм дургүй байгаа юм гэж аав хэлэв. Гэсэн ч манай морьд тэндээс зайлж зугтсангүй. Хэрэв босож тэдний хамт явахгүй үлдвэл үхнэ гэж бодсон юм шиг зэрлэг морь эцсийн хүчийг шавхан босож тэдний дунд орж зогсов.

Зөвхөн энэ үед л бид түүнийг нэг сайн ажиглаж авлаа. Тэр бээр аймшигтай шархадсан байлаа. Бүх цээжин бие, урд хөл, хүзүү нь гүнзгий эсгэгдсэн байснаас гадна түүн дээр нь ялаа шавж, цус нөж нь барилдан хатсан байлаа.. Бүх баруун мөр нь цус нөж болсноос гадна хойд хөл нь гүнзгий шарх олсноос зарим газартаа яс нь харагдаад нүд халтирам аймшигтай болсон байлаа.

— Ийм болсон атлаа амьд байдаг нь гайхмаар юм. Ёстой л нэг ясны бөх адуу байна даа гэж аав хэлэв.

Бид түүнийг өөрсдийн морьдын хамт тосгоны ойролцоох бэлчээрт авчрав. Нөгөө шан-дан дээр авчирмагц тэр бас л хэвтээд өгөв. Энэ үед бүх тосгоныхон энэ ер бусын морийг үзэхээр хүрч ирэв. Үүнийг ингэж зовоож байснаас буудаад түргэхэн алчихсан нь дээр гэж хэн нэгэн хүн хэлэв. Үүнийг сонсмогц миний уур учиргүй хүрч, би шууд эцэг дээрээ гүйн очиж, түүнийг өмгөөлж хамгаалахыг хүсэв. Эцэг маань намайг тайвшруулан түүнийг буудах эрх хэнд ч байхгүй. Энэ морь эдгэрсний дараа манай циркт маш хэрэгтэй. Ер бусын энэ морийг улс амьтан хэчнээн их сонирхож байгааг чи хар л даа! гэв. Харин ганцхан түүнд туслахад л бэрх байлаа. Тэр бээр хэнийг ч биедээ үл ойртуулна. Бүүр хэвтээ байхад нь ч оролдоод нэмэргүй. Хэрэв түүнд хэн нэгэн хүн ойртож очвол тэр ухасхийн босохыг оролдоод зогсохгүй, хазах, хайрахад ямагт бэлэн байдаг юм. Давжаа хүртэл надаас бусдыг нь хазаж, хайраад биедээ ойртуулахгүй байлаа. Тийм учраас манайхан Тахид юуны өмнө намайг ойртож очих нь зүйтэй гэж үзэв. Энэ бол тийм амар ажил биш байлаа. Тэр бол ер бусын амьтан болохоор аргагүй биз. Миний сэтгэл маш их түгшиж байлаа. Гэвч би зүрхээ чангалж байгаад маш болгоомжтойгоор дөхөж эхлэв. Юу ч болоо билээ гээд, аав, ах хоёр нэг нэг том мод бариад зэхэж байлаа. Зэрлэг адуунд намайг нэн ойртож очих үеэр Давжаа маань түүнийг тайвшруулсан янзтай зөөлөн янцгаав. Хөөрхий тэр морь босох гэж ч, намайг хазах гэж ч оролдсонгүй.

Яг энэ үед би түүний мөрнөөс ямар нэг зүйл санжганан унжиж байхыг харлаа.

— Үүний мөрөнд нь бяцхан ган сум зоолттой байна гэж би аавдаа хашхиран хэлэв. Энэ нь чухам юу болохыг тэгэхэд би мэдэхгүй байлаа.

— Чи түүнийг суга татаж чадахгүй, болгоомжтойхон оролдоорой! гэснээ гэнэт «Хүүе хүлээж бай! Би аргамж аваад ирье!»

гэж аав хашхирав. Тэр бээр ачааны машин дээрээс нэг эвхээстэй олс авч ирэн, надад чулуудаж өгөөд, үүний нэг үзүүрийг тэр сумны бөгсөнд бэхэлж уя, дараа нь би татаж түүнийг сугалъя! гэв.

Зэрлэг адуу намайг нүд цавчихгүй ширтэж байсан бөгөөд түүний харцанд нэг талаар уурлаж хилэгнэсэн, үзэн ядсан байдал, нөгөө талаар өвчиндөө шаналсан, өрөвдөлтэй байдал илэрхий байхыг үзээд би золтой л уйлчихсангүй. Түүний шарх нь өвдөж тэсвэрлэшгүй шаналгаа учруулж байгаа нь надад илт байлаа. Иймээс би түүнд эхлээд арга зүйгээр зөөлөн хандав. Энэ хугацаанд Давжаа түүнийг тайвшруулсан янзтай үе үе янцгааж байлаа. Ийнхүү би аргамжны үзүүрийг нөгөө сумны бөгсөнд бэхлэн уяж амжив.

— За одоо холд! гэж аав хашхирав.

Аргамжийг зугуухан сунгаж байснаа гэв гэнэт хүчтэй угзрав. Хөөрхий тэр морь өвдсөнөөс болж цочмог чарласан бөгөөд харин нөгөө ган сумыг аав суга татаж амжив. Энэ нь загасны дэгээ шиг сөртөн шүд бүхий аймшигтай эд байлаа. Ямар хүн, яах гэж энэ балиар сумаар харвасан нь бидэнд огт ойлгомжгүй зүйл байлаа.

Харин түүний аймшигтай шархыг угаах, боох боломж бидэнд тун ч байгаагүй билээ. Хэдийгээр надад хүсэл их байсан боловч зэрлэг адуунд дахин ойртохыг эцэг маань хатуу хориглов. (Китти минь чамд гэж хэлэхэд би эмнэлгийн сувилагч болох хүсэлтэй. Харин надад тийм авьяас билэг байхгүйгээс болоод энэ мөрөөдөл маань биелэхгүй болов уу гэж айх юм. Түүнээс гадна бид нэг газарт удаан тогтож байдаггүй, энэ бас саад болох нь мэдээж. Бид жилдээ хоёр удаа хажуугаар нь өнгөрдөг Сегеда хотын том больницод орж ажиллах сан гэж би их хүсдэг. Заримдаа шөнөд сэмхэн уйлж ч үздэг юм. Хэрэв би тэнд ажиллах юм бол төрөл төрөгсөд болон өөрийн циркийнхэнтэй үргэлж уулзах бололцоотой шүү дээ).

Хэдийгээр бид тэрхүү ган сумыг сугалж авсан боловч зэрлэг морь тэр дороо амархан тэнхэрсэнгүй. Үүнээс болж бид нэлээд саатсан юм. Манай эцэг тэр морийг тэнхэрч байна гэдэгт бүрэн итгэхээс нааш явахыг хүсээгүй юм. Давжаа түүнтэй байгаа цагт зэрлэг морь тогтвортой тайван байна гэдгийг бид сайн мэдэж байлаа. Бид өвөл цагийн ердийн аяллыг эхлэв. Давжаа, зэрлэг морь хоёр манай адуун сүргийн хамт л явж байлаа. Бид дорно зүгийг чиглэн аялж явсан юм. Бид танай өвөөтэй уулзсаны дараа сая тэр учрыг ойлгосон юм. Тэр яагаад манай адуунаас оргосонгүй вэ гэхээр бид түүний хэрэгтэй зүгт

нь аялж байжээ. Хэрэв манай цирк хойд, баруун зүгт аялж байсан бол тэр бээр өөрийн бие сул, шарх сорвитойг үл хайхран Давжааг дагуулж аваад шууд оргох байсан гэдэгт бид бат итгэж байгаа юм.

Китти минь, эцсийн эцэст би Давжаа байдсанд хүүхдүүд унуулан зугаацуулах ажлыг гүйцэтгэж чаддаг болов. Яагаад гэвэл надаас өөр хүнийг тэр өөртөө хавьтуулахгүй байсан юм. Харин намайг энэ ажлаа гүйцэтгэхэд тэр бээр туйлын уриалган хөдөлдөг байлаа. Энэ хугацаанд зэрлэг морь манай бусад морьдын хамт бэлчээрт байсаар нэлээд тэнхэрсэн юм. Харин бид сургууль хийхээр анх удаа Давжааг авч одоход зэрлэг морь бузар ууртай байсан. Харин Давжаа байнга эргэж ирээд байгааг үзээд сүүлдээ тайвширсан. Харин тэгэхдээ одоо болтол хэн ч түүний биед халдан хүрч, өөртөө ойр дотно дасгаж (би ч гэсэн) чадаагүй байна. Тэр бээр бусад адуутай хамт байхдаа ямагт онцгой зогсдог буюу тухайлбал онцгой хэвтдэг байсан гэж хэлж болно. Тэр бээр жинхэнэ ёсоор зогсдог болоод удаагүй учир би хэвтдэг гэж хэлж байгаа юм. Яагаад гэвэл нойрсуулагч сумны хор тахийн цуснаас удтал гарахгүй байсан учраас тэр! гэж танай өвөө бидэнд тайлбарласан юм.

Бид аяллаа үргэлжлүүлэн байх энэ хугацаанд зэрлэг морины биеийн байдал улам улам сайжирсаар байснаас гадна түүний санаа сэтгэл улам бүр тогтворгүй болсоор байсан юм. Тэр бээр хашааны хана дагаад л зогсоо жолоогүй холхиж байдаг болсон.

Тахь, Давжаа хоёрыг эрж сурвалжлах зорилгоор бүх гүүр гармаар нэвтрэх ачаа хөсгийг нягтлан шалгах заавар тушаал хэдийнээ өгөгдсөн атал та нарыг Дунай мөрөн гатлахад яагаад зогсоож шалгаагүй юм бол? гэж танай өвөө сонирхон асуусан юм.

Энэ бол аргагүй юм. Такс гэдэг тосгоны хажууд хөвдөг гүүр гэмээр ч даа, нэг бярвааз байдаг. Тэр голын нэг эргээс нөгөө эрэг рүү дизель моторын хүчээр хөдөлж явдаг ухаантай юм. Энэ бярвааз бидний яг замын чиглэлд байдаг учраас бид ямагт түүнийг ашигладаг юм. Адуу малыг ажиглаагүй учир нь ийм аргаар гол гатална гэж хэний ч ухаан санаанд ороогүй биз.

Гол гаталсны дараа бид Дунапартай гэдэг тосгонд циркээ байрлуулсан юм. Харин тэгэхэд л хашаан дахь адуун дотор зэрлэг адуу алга байсныг бид ажигласан юм. Тэр бээр хашааны хэд хэдэн сараалж модыг хуга өшиглөж хэмхлээд оргосон байлаа. Бид цөм эрэл сурал болоод түүнийг олж чадаагүй юм. Дунапартайд бид дөрөв хонох байсан боловч бас нэг илүү хонож эрээд ололгүй хөдөлсөн. Бид туйлын

уйтгар гунигтай явсан. Өөр яах ч билээ дээ? Дараа өдөр нь бид Кишкөрш орох замд явж байлаа. Гэтэл бидний араас замын хажуугийн цасан дундуур нөгөө зэрлэг морь давхиж явахыг би тэрэгний бүхээг дотроос харлаа. Бид түүнийг барьж авахыг оролдсон боловч бүтсэнгүй. Тэр бээр нэлээд зайдуу дагаад байлаа. Бид түүгээр оролдохоо больё гэж шийдсэн.

— Түүний хойноос хөөцөлдөхийн хэрэг байхгүй. Хань ижил нь энд байхад тэр хаа холдох вэ гэж манай эцэг хэлсэн юм.

Тахь биднийг салахгүй дагаж байлаа. Бид тосгонд орж буудаллахад тэр бээр ойр хавийн ой шугуйд нуугдана. Нэг удаа бид түүнийг бүтэн долоо хоног огт хараагүй. Бид тосгоноос нүүдэллэхэд тэр бээр бас гараад л ирдэг байлаа. Манай орны хамгийн алслагдсан өнцөг болох Украйнтай хил залгаж буй нутаг хүртэл Дорнод Унгараар аялж явахад энэ байдал үргэлжилсээр байлаа. Тэндээс бидний зам ямагт баруун тийш эргэдэг байлаа.

Баруун зүгт эргэсэн анхныхаа шөнө бид интоорын цэцэрлэгээр нэрд гарч алдаршсан Нагдед тосгонд ирж хоноглосон юм. Интоорын нэгэн бяцхан цэцэрлэгт адуугаа бэлчээж хоноглохыг бидэнд зөвшөөрсөн болно. Тэр шөнө л Давжаагийн талаар бидний анхаарал жаахан суларсныг тэр овжин ашиглажээ.

Чухам юу болов? Өглөө бид Давжааг авахаар цэцэрлэгт ирэхэд тэр бээр алга болсон байлаа. Цэцэрлэг их цастай байсан тул бид тэдний мөрөөр мөшгөсөөр яваад түүний зэргэлдээ орших нэгэн гүнзгий сувгийн дэргэд ирэв. Тэр суваг маш их гүнзгий бөгөөд адуу түүнийг гатлаагүй гэдэгт бид итгэж байлаа. Бид эрлээ цааш үргэлжлүүлэн байж, сувгийн ус нэгэн газарт хөлдсөн бөгөөд түүгээр Тахь цэцэрлэгт орж ирэн Давжааг дагуулан оргосон мөр байхыг олж илрүүлэв. Бид тэр тосгоны хүмүүсийн тусламжтайгаар тал, хөндий, ой цэцэрлэг бүгдийг нэгжин дөрөв хоног хайгаад эрэл мухардав. Түүнээс хойш зэрлэг морь, Давжаа хоёрын алины нь ч барааг бид олж харсангүй. Тэд лав манай унгарын цагаан цастай хамт хайлчихсанаас зайлаагүй биз. Тэднийг оргон орготол нь бид туйлын их дасаж, хайрлаж байсан бөгөөд ингэнэ байх гэж өчүүхэн ч сэжиглээгүй юм даа. Хэдийгээр Давжаа манайд ирээд удаагүй ч гэсэн түүнд би чамаас дутахгүй их дассан гэж бодож байна. Түүний хойноос харамсаж, бас яг л чам шиг уйлсан. Давжаа чухам хэний морь байсан. Тахь тэр хоёр хаанаас ирснийг нь огт мэдэхгүй байсандаа би их харамсаж байна. Тэд

ирсэн замаараа сурсан дуугаа дуулаад л явчихлаа. Одоо яая гэхэв дээ. Хэдэн долоо хоног өнгөрсний дараа, бид өөрсдийн нэг морийг Мишкольц хотын малын эмчид үзүүлэх үеэр манай аав ер бусын хоёр адуутай тааралдсан тухайгаа түүнд хуучилжээ. Малын эмч маш их олзуурхаж, тэр тухай Будапештад утсаар мэдэгдсэн байна. Дөрөв хоногийн дараа танай өвөө бидэнтэй уулзахаар Лондоноос хүрэлцэн ирлээ. Тэр бээр бидэнд зэрлэг адуу-Тахь, Давжаа хоёрын түүхийг ярьж өгсөн юм.

Танай өвөө нэг оройжин манайд байж, тэр хоёр морь болон чиний тухай хуучилсан юм. Чухам юу болсон тухай чамд дэлгэрэнгүй захидал бичихийг тэр бээр гуйсан юм. Би өөрийнхөө багш Надийн тусламжтайгаар ийнхүү унгараар бичив. Нэлээд зүйлийг би орхигдуулсан байж болно. Гэхдээ гол чухал зүйлүүдийг энд багтааж чадсан болов уу гэж найдаж байна.

Тэр зэрлэг морь монгол нутгаа зорьж явааг мэдсэний хувьд одоо бодож үзэхэд, Тахь, Давжаа хоёр өдийд Карпатын нурууг даваад (туйлын хүйтэн бөгөөд мөс цасаар бүрхмэл байгаадаа) украины тал нутгийн хаа нэгтээ яваа бол уу даа. Тэнд ч гэсэн бас их цастай, хүйтэн байгаа даа.

Хэрэв тэдний тухай чи өөрөө, чиний монгол найз ямар нэг хэл мэдээ сонсвол надад захидал бичээрэй! Танай өвөө бас ямар нэгэн мэдээ сэлт дуулбал захиа бичихээр амласан юм. Анх бид Тахийг олж харахад тэр бээр өвчтэй, аймаар турж эцсэн амьтан байсан тул хүмүүс хэдийгээр түүнийг өрөвдөж байсан боловч тэр бээр хүмүүст төдий л таалагдаагүй нь мэдээж билээ. Харин түүнийг таргалж тэвээрсний нь дараагаар цөм түүнд хайртай болсноор барахгүй, тэр бээр цаанаа нэг л ухаантай, чиглэсэн тодорхой зорилготой, түүнээс бусад юуг ч үл тоомсорлож байснаас л түүнд хүмүүс ийнхүү дуртай байсан байж болох юм.

Хэрэв надад захидал бичвэл би туйлын их баярлах болно. Бидэнд түүнийг орчуулж өгөх хүн мундахгүй. Манай тосгонд Америк, Австрали, Канад болон бүүр Англид сууж байсан хүн ч олон бий. Дьома гэдэг тосгоны нэг иргэн «хүний арал» нэртэй гайхалтай сонин бөгөөд сүүлгүй мууртай оронд арван жил сууж байсан гэнэ. Чи тийм орныг дуулсан уу? Энэ бол талхчин хүн.

Тахь, Давжаа болон бусад бүх зэрлэг ан амьтны дотнын найз чамд чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье!

Жич: Би захиа хүлээж авдаг өөрийнхөө бүх хаягийг тусгай цаасан дээр бичиж явуулав. Чи хувцасныхаа шүүгээн дотор хадаж орхи! Би бүх чухал зүйлээ хаяж гээхээс болгоомжлохдоо ингэж хадгалдаг юм.

Баярт минь, энэ нэг уйтгартай захидлыг уншсанаас хойш золтой л миний хэл татчих шахлаа. Хэрэв Тахь Давжаа хоёр одоо Украйнд яваа бол надад биш, харин чамд ойртож очжээ. Чи тэдний сургийг гаргахыг хичээгээрэй! Үүнийг гүйцэтгэхэд чамд надаас илүү хялбар байна байх.

Өөр надад нэмж бичих зүйл огт алга. Тэд Украйны цаст өргөн тал, хүйтэн жавар, олон гол мөрнийг яаж гатлан туулахыг би огт ойлгохгүй байна. Газрын зураг дээр харахад тэдний явсан зам дэлхийн бөмбөрцгийн тэн хагастай тэнцмээр санагдах юм. Манай өвөө Украйны нийслэл Киев хотын хоёр профессорт захидал бичсэн байх. Манай хоёр морины тухай тэднээс ямар нэг сураг дуулдана байх гэж бид найдаж байна.

К.

Сайн байна уу, Китти!

Чиний сүүлчийн захидлыг манай найз Гарьд (одоо тэр англиар уншиж чаддаг болсон) ачааны машин дээр суугаад уншиж байснаа, газар үсрэн бууж, «Баяртаа, түүний хэлдэг түмэн зөв. Тэд одоо замынхаа бараг тэн хагасыг туулсан байна. Мэдэж байна уу?» гэж дуу алдав.

Түүний сэтгэл туйлын их хөдөлж, Тахь, Давжаа хоёр Украинд хүрэлцэн ирснийг өөрийн профессорт очиж сонсгохоор Улаанбаатар руу яаралтай явлаа. Профессор тэр тухай хэдийнээ дуулсан байжээ. Танай өвөө түүнд цахилгаан утас ирүүлсэн гэнэ. Улаанбаатарт байдаг тэр профессор Тахь Давжаа хоёрыг сурвалжилж олох талаар чадах бүхнээ хийнэ гэж амлажээ.

Гэсэн ч Китти минь, миний хувьд гэвэл төдий л итгэл төгс биш байна. «Болоогүй, бүтээгүй зүйлийг урьдчилан хэлэхэд бэрх» гэсэн нэг зүйр үг монголд байдаг юм. Цаад утгаараа бол «Дэгдээхэйг намар тоолдог» гэсэн английн зүйр үгтэй ойролцоо юм. Энэ зүйр үгийг би өөрөө номоос олж сурсан юм. Миний нагац эгч намайг англи хэлний талаар чи багагүй амжилт олж явна, гэхдээ ой тойгоор базаахгүй сурагч юм гэдэг. За, тэр ч яах вэ, Тахь, Давжаа хоёрын тухайд бол, ямар ч байсан бид хүлээж байхаас өөр зам алга!

Тэр хоёрыг эрж сурвалжлах ажилд оролцохоор Гарьд Украин руу нисэх хүсэлтэй л юм шиг байна. Миний бодоход ашгаар бага л байх. Хаанаас эхлэх гэж бодож байгаа юм бол? Като Кошутын захидлыг би уншаад, Тахь Давжаа хоёр гэртээ ирэхэд ойртож байгаа ч гэсэн тэд хаа нэгтээ баригдах нь зайлшгүй юм байна гэж ойлгов. Тэдэнд дэндүү олон адал явдал тохиолджээ. Шинэ адал явдалтай учирч, шинэ шарх олсон доор бол харин тэд хаа нэгтээ баригдсан ч дээр санагдана.

Ямар нэг мэдээ олж сонсвол чамд тэр доор нь захиа бичнэ. Бүгдэд мэнд хүргээрэй! Баяртай.

*Чиний итгэлт найз
Баярт.*

Жич: Өнгөрсөн долоо хоногт зэрлэг адуун сүрэг маань бас нэг эр унагатай болсон. Одоо тэд зургуул боллоо. Адуун сүрэг үзтэл өсөж эхэлж байгаа биз дээ. Одоохондоо нөгөө нэг

таван морьдыг олоогүй л байна. Магадгүй, би тэгэхэд алдаж
тоолсон ч байж болох юм.

Б.

Эрхэм найз Китти!

Эцсийн бүлэгт нэг мэдээ сонслоо. Энэ тухай би юу гэж хэлэхээ мэдэхгүй байна. Миний бодоход, бүх юм ёсоороо л болж байх шиг байна. Чамайг би зэргэлдээ тосгонд суудаг ч болоосой, тэгвэл давхиж очоод энэ тухай юу гэж бодож байгааг нь асуух сан гэж санагдана. Украйны төмөр замын салбарт эргүүл хийдэг нэг авгай Тахь, Давжаа хоёрын тухай анхны мэдээг Киевт (Украйны нийслэл) ирүүлжээ. Цасан шуургатай нэгэн шөнө толгодын дундуур өнгөрдөг, замын хамгийн бэрхшээлтэй хэсэгт галт тэргийг угтахдаа (замын эргүүлүүд бас ийм үүрэгтэй байдаг гэнэ) энэ авгай галт тэрэгний гэрэлд замын далан дээгүүр хоёр хачин адуу хатирч явахыг олж харжээ.

Иймэрхүү эзэнгүй мал галт тэрэгний хөдөлгөөнд аюул учруулж болдог тул тэр эмэгтэй энэ тухай Умань станцад мэдэгджээ. Аз болоход галт тэрэгний жолооч бас энэ хоёрын тухай мэдээлжээ. Энэ мэдээ Киевт хэдэн долоо хоногийн дараа хүрсэн бөгөөд чухам юун адуу байсныг хүмүүс тааварлан мэджээ. Харин энэ завсар тэр хоёр дахиад алга болжээ.



Дараа нь Черкассы хотын ойролцоо орших хамтралынхан тэднийг олж үзсэн байна. Хоёр, гурван хоногийн хүчтэй шуургыг тэд хамтралын дархны газрын хашааны нөмөрт хоргодон өнгөрүүлжээ. Тахь хамтралын агуулахын үүдийг хэмх өшиглөж, тэд хамаг овьёос, улаан буудайг нь идээд алга болсон байжээ. Дараагийн мэдээг Градскийн хамтралын шувуу ферм дээр ажиллаж байсан хоёр авгай ирүүлжээ. Тэд галуунуудаа харуулдан байтал нь гэнэт хаанаас ч гарч ирсэн нь үл мэдэгдэх бага шиг биетэй хоёр адуу хажуугаар нь давхин өнгөрч хамаг галууг нь үргээжээ (хэрэв түүнийг харсан бол ямар хөгтэй байсан бол).

Хэдийгээр энэ мэдээ төдий л чухал биш байсан боловч тэдний байгаа газрыг олж тогтоох боломж украины эрдэмтдэд олгожээ. Ийнхүү Украйны Шинжлэх Ухааны Академи тэднийг олж барих ажлыг зохион байгуулах хэргээр профессор Немченког зориуд тийш нь илгээжээ. Мөн Гарьдыг урьсан тул тэр бээр Улаанбаатар руу яаралтай нисэж, тэндээсээ Киев, Киевээс Харьков орж тэнд профессор Немченкотой уулзжээ.

Эхлээд Гарьд, Немченко хоёр (Немченко нь бас зоологийн мэргэжилтэй хүн) морьдын явж өнгөрсөи ул мөрийг гаргахыг оролдов. Гэвч энэ үед цас хайлж украины тал нутаг хэдийнээ шавар шавхай ихтэй болсноос болж засмалаас огт гарах аргагүй байжээ. Ийнхүү тэд тал газраар мөрдөн хөөх ямар ч найдлага тасарчээ. Ганцхан трактороор явж болох бөгөөд гэтэл бүх тракторууд нь хаврын хагалгаа, тариалалтын ажилд орсон тул ийм ажилд гуйх боломжгүй болсон байжээ. Тахь, Давжаа хоёрыг олох арга зам ийнхүү мухарджээ.

— Ганцхан л зам байна. Бид улаан армийн нөхдийг туслаач! гэж гуйх хэрэгтэй байна гэж профессор Немченко хэлжээ.

— Юү гэсэн үг билээ? Бидэнд тэд яаж тус хүргэх юм бэ? гэж Гарьдын асуухад:

— Мэдэхгүй байна. Гэхдээ тэдэнд нисдэг тэрэг бий шүү дээ. Нөгөө талаар энэ шавар шавхайтай тал, үерлэж савнаасаа хальсан голыг зам ч үгүй, гүүр ч үгүй газраар гаталж чадах хүмүүс бол зөвхөн армийн нөхөд л байгаа юм гэж Немченко хэлэв.

За, тэгээд өдөр шөнөгүй тувт аялсаар талийж одсон Тахь, Давжаа хоёрыг мөрдөн сурвалжлах ажилд улаан армийн хоёр салаа орлоо. Зөвхөн тэдний ул мөрийг гаргах гэж армийн нөхөд бүтэн долоо хоног хөөцөлджээ. Эцсийн нэг өдөр үерлэж хальсан мөрөн голын эрэг дэх

бяцхан хусан шугуйд хоёр адуу нуугдан байхыг нисдэг тэргэн дээрээс харжээ. Үнэн хэрэгтээ, ус бороонд норж дэвтсэн газрын хөрс, ямар ч өөр машин тэрэг дээгүүр нь явж тэнд хүрэх нөхцөлгүй болсон байлаа. Ийм учраас салааны дарга газар уснаа явагч хоёр танк тийш нь явуулахаар шийджээ.

Тэдэнд саатах юм огт байхгүй. Нэг танктай нь Гарьд, нөгөө танктай нь профессор Немченко явжээ. Тэд энэ хоёр адууг гурван талаасаа усаар хүрээлэгдсэн голын нэгэн тохой руу шахаж оруулан дараа нь цэргүүдээр бүслүүлэх санаатай хойноос нь хөөжээ. Танкнууд нөгөө зорьсон газартаа тулж ирэхэд хэдийнээ харанхуй болсон байлаа. Гэтэл Тахь Давжаа хоёр ул мөргүй алга болжээ. Гарьд Немченко хоёр тэднийг гол, гатлах гарам хайж яваа гэж боджээ. Иймээс тэд салж, нэг нь гол өгсөн, нэг нь гол уруудан хайжээ. Танк дээр маш хүчтэй гэрэлтүүлэгч зоосон бөгөөд тэдний гэрлээс юу ч мултарч гарах ёсгүй байжээ. Түүнээс гадна танкны чимээгээр (түүний чимээ ч гэж хачин юм байгаа л даа) Тахь заавал айж зугтана, энэ үед нь түүнийг олж харна гэж эрдэмтэд найдаж явжээ. Гарьдын сууж явсан танк голын эргийг гэрэлтүүлэн, Гарьд өөрөө цамхаг дээр нь зогсоод дурандаж явжээ. Гэвч тэд бүтэн хоёр цагийн турш айсан шувуу, туулайнаас өөр юу ч олж харсангүй. Дараа нь гэрлийн үзүүрт ямар нэг юм бүртэлзэн хөдлөх шиг болоход нь энэ бол лав Тахь мөн гэж Гарьд боджээ. Тэр бээр танкны жолоочид:

Зогсоорой! гэж хашхиран хэлэхэд танк зогсов. Гарьд нэг цэрэгт тэр зугтаж байгаа адууг гэрлээс битгий алдаарай гэж гуйв. Яах аргагүй энэ нь Тахь мөн байлаа. Ингэхэд Давжаа хаачдаг билээ?

Тахь айсандаа болоод хандсан зүг рүүгээ зугтаж байна гэж эхлээд Гарьд боджээ. Дараа нь сайн ажиглаад байвал тэр бээр нэгэн газраас холдохгүй тойрч гүйгээд байжээ. Тэд гэрэлтүүлэгчийн тусламжтайгаар нарийвчлан ажигласны эцэст тэр тойрч байгаа газрын гол дунд нь Давжаа байдас гэдсэндээ тултал нойтон хар шаварт шигдчихээд хөдөлж ч чадахгүй байсныг олж харав. Тахь түүнийг тойрон шавар үсэргэн давхиж байх нь нэг харахад бидний анхаарлыг Давжаагаас холдуулах гээд байх шиг, нэг харахад түүнийг өмгөөлөн бидний танк руу дайрах гээд байх шиг санагдаж байлаа.

Ямар ч гэсэн шаварт шигдсэн Давжаагаа орхих янзгүй байлаа. Немченкогийн танктай холбоо баримагцаа Гарьд:

— Бид тэднийг оллоо! гэж микрофоноор хашхирав.
Немченкогийн танкийг хүлээж байх зуур Гарьдийн суусан танк
Давжаад ойртож очихыг оролджээ Гарьд танкны даргад

— Зогс! гэж хашхиран өгүүлэв.

— Яагаад?

— Цаадах чинь бидэн рүү дайрна.

Танкны дарга учиргүй хөхрөв. Танк руу дайрдаг адуу байна гэдэгт тэр бээр огт итгэсэнгүй. Тиймээс «Санаа зоволтгүй. Тэр бээр биднийг яаж ч чадахгүй» гэв. Гарьд сандран уулгалж, «Эргээд! Нөгөө тийшээ! Цаадах чинь бидэн рүү дайрахдаа өөрөө амь сүйднэ. Эргээд! гэж хашхирав.

Тахь танкны өөдөөс эгцээрээ ирж явахыг хараад танкны дарга Гарьдын хэлсэнд үнэмшиж, бушуухан эргэж зугтахад, Тахь түүнийг галзуу юм шиг мөрдөн хөөж байлаа. Зөвхөн нэлээд холдсоны дараа, тэд зогсож гэрлээ унтраагаад чимээ чагнав. Тахь маш ууртай тургиж янцгааж байгаа нь дуулджээ.

— Үүр цайтал эндээ хүлээе! гэж Гарьд танкны даргад хэлээд сэтгэл нь амарсан байдалтай санаа алдав.

Мориноос танк зугтана гэдэг мөн ч сонин юм даа гэж хачирхан бодсоноо:

— Ёстой галзуу адуу байна. Дайрч ирээд яах байсан юм бол? гээд танкны дарга инээв.

Үе үе тэд хайгуулын гэрлээ асааж, Давжаа шаварт хэр гүнзгий шигдэж байгааг шалгаад бүхэл шөнийн турш хүлээж хонов. Тахь л түүнийг яаруулаад байгаа болохоос биш, Давжаа үүр цайж гэгээ гэрэл ортол тэндээ тэсвэртэйгээр хүлээж чадна гэдгийг Гарьд сайн мэдэж байлаа. Яг үүр цайх үеэр тэдний хүлээж байсан нөгөө танк нь хүрэлцэн ирлээ.

Бүхэл шөнө өчүүхэн ч цурам хийж амраагүй Тахь энэ үеэр Давжааг улам тэвдүүлж эхлэв.

Тахь Давжаа хоёрын ийнхүү алс хол аялсныг цэргүүд мэдмэгцээ Давжаад туслах сэтгэл төрөв. Үүний тулд Давжаагийн дэргэд очиход саад хийж байгаа Тахийг л барьж авах хэрэгтэй байлаа. Тэд эхлээд Тахид сэмхэн дөхөж очмогц бугуйл шидэж барихаар төлөвлөв. Тахь бол зөвхөн туйлын их ухаантайгаар барахгүй бас аюултай амьтан тул энэ аргаар түүнийг барьж дийлэхгүй гэж Гарьд хэлэв. Дараа нь тэд нутгийн хамтралчдын хүчийг дайчлан түүнийг бүсэлж барих тухай

ярилцав. Харин үүр цайсны дараа Гарьд орчин тойрны байдлыг ажиглаад, ийм тэгш тал газар түүнийг бүслэн авах замаар барихгүй юм байна гэдгийг ойлгов. Тэгээд түүнийг барихад пуужинт тор бүхий нисдэг тэрэг дуудахаас өөр замгүй гэж Гарьд шийджээ. Пуужинт торыг аливаа зүйлийг хурдан хугацаанд нуун далдлах шавар намагтай замыг туулах, эгц өндөр эрэг, эвдэрч хэмхэрсэн байшин барилгын дээр авирч гарах зэрэгт хэрэглэдэг ажээ. Түүнийг нисдэг тэргээр тээж яваад, пуужингаар буудаж дэлгэдэг тор юм гэнэ. Тийм торыг Тахийн Дээрээс чулуудах юм бол Тахь торонд орсон загас шиг хаашаа ч бултаж чадахгүй амархан баригдана гэж танкны дарга боджээ. Өглөөний найман цагт нисдэг тэрэг хүрэлцэн ирэв. Гарьд танкны радиогоор нисгэгчдэд бүх учрыг тайлбарлав.

— Тороо хаяхдаа тун сайн голлуулж хаяарай, тэгэхгүй бол цаадах чинь бултаад гарахаас сийхгүй амьтан шүү. Нэг удаа өргөст төмөр торноос хүртэл мултарч гаран айхавтар сүрхий туршлагатай болсон амьтан тул дахин тийм байдалд хүргэхгүй байхын тулд хашир үзэх хэрэгтэй гэж Гарьд хэлэв.

— Битгий сэтгэл зов. Бид зааныг ч барьж дөнгөнө гэж нисгэгч хариулав.

Эхлээд нисдэг тэрэг нөгөө хоёр адууных чанх дээр нь очоод тогтов. Энэ үед тахь ёстой л галзуурахаас наахнуур байлаа. Тэр бээр туурайгаараа газар цавчлан янцгааж, байн байн Давжаа дээр давхин очиж байх нь түргэл! гэж шаардах мэт. Харин Давжаа яаж ч чадахгүй улам доошоо лав шигдэнэ. Тэр бээр өөрийн хүчээр гарч чадахгүйгээ мэдэгдэж байгаа бололтой өрөвдөлтэй унгалдана. Тахь ч түүнийг ойлгосон янзтай байж цөхөн бачимдана.

Нисдэг тэрэг улам доошлон ойртоход түүний сэнсний хүчтэй салхинд нялцгай шавар, ус үелэн бидэрлэнэ. Тахь хэдхэн алхмын зайд Давжааг тойрон давхиж, толгойгоо ууртайгаар сэгсчихээс гадна урд хоёр хөл дээрээ гозойх шахан нисдэг тэргийг тангарах гэж оролдоно.

Гарьд радиогоор холбоо барьж, бурхан минь болгоомжтойхон оролдоорой. Гэхдээ удааширч болохгүй шүү! гэж нисгэгчээс гуйв. Нисдэг тэрэгнээс пуужин харваж маш том дөрвөлжин нейлон тор газрыг бүрэн дэлгэгдэж унахыг хараад Гарьд үнэхээр бишрэн гайхав. Тэр бээр урьд өмнө хэзээ ч ийм юм үзээгүй байжээ.

— Яг нүдийг нь олж онов! гэж нисгэгч радиогоор хашхирав.

Палигар том гарын алгаар базаад авах мэт тэрхүү тор Тахийг хумхин дарж авав. Тахь түүний хүндэд дарагдан эхлээд өвдөг сөхөрснөө, дараа нь хажуулдан ойчив. Тэр бээр ууртайгаар чарлан тонгочиж, эрүү нь хавчганан, шүд нь тачигнана. Хэдий чинээ тонгочих тутам төдий чинээ орооцолдоно. Үүгээр хэрэг явдал бас дууссангүй.

Тор зөвхөн Тахийг бүрхэж аваад зогссонгүй, түүний нэг үзүүр нь Давжаа дээр унажээ. Торыг шидсэн хүчинд болон түүний хүндийн жинд дарагдаж шаварт шигдсэн Давжаа улам доошоо живж зөвхөн түүний толгой нь цухуйж байжээ. Гарьд танкны даргад хандан,

— Аль вэ, түргэлж үзээрэй! Түүний дэргэд бушуухан явж очоорой гэв. Шөнийн хүйтэнд хөрсөн танкны мотор тийм ч амархан ассангүй. Нисдэг тэрэг Давжаагийн дээр эргэлдсээр л байлаа. Нисгэгч нь радиогоор яаралтай арга хэмжээ авахыг зөвлөж байлаа. Тэгээд өөрөө газар хаясан торыг эвхэж авдаг дэгээгээр Давжаагийн дээрээс унасан торны үзүүрийг татаж авахыг оролдьё гэж хэлэв. Харин тэр нь амжилттай боллоо.

Одоо хоёр танк Давжаад аль болохуйцаар ойртож очив. Шаварт дэлгэж хаясан брезент хүүдий дээгүүр нэг цэрэг явж Давжаагийн дэргэд очоод, энэ адуу чуутай чаатай амьсгалж байна. Бодвол шавартаа сүрхий шахагдаж байгаа бололтой гэж хашхирав. Тэр цэрэг танк дээрээ эргэж ирээд: «Тэр адуу удаан тэсэхгүй байх шүү» гэв.

Гарьд Тахиас дутуугүй Давжаагийн төлөө сэтгэл бухимдаж байлаа. Китги, бид, чиний захидлыг уншсаар байгаад Давжаад бүүр дасчихсан юм. Гарьдын хувьд Давжаа бол Тахиас дутуугүй чухал зүйлийн нэг болох нь ойлгомжтой. Тэрхүү мөчид Гарьд: «Энэ нэг бяцхан хөөрхөн англи байдас ингэж зовж байх ямар үйлийн үртэй амьтан бэ? Гэр орноосоо алс хол украин нутгийн шавар намагт юугаа хийх гэж ирж шигддэг юм бол?» гэж бодож байсан гэж бидэнд хуучлав. Гарьд Давжаагийн шигдсэн газрыг нарийвчлан ажиглаж хуучин тойром байсан хонхорт хаврын цасны нялцгай шавар урсан орж дүүрсэн байсныг олж мэджээ. Энэ нь маш гүнзгий байснаар барахгүй хэрэв Давжааг яаралтай гаргаж аваагүй бол далд ортлоо шигдэж болох байжээ.

— Энэ байдас урагшаа ч үгүй, хойшоо ч үгүй ягджээ. Бид түүнд тусалж чадахгүй. Харин түүнийг эгц дээш нь татаж гаргах цорын ганц арга байна гэж Давжаа дээр очсон цэрэг өгүүлэв.

Энэ бүх ажлыг гардан хариуцаж байсан Гарьдп

— За тэгэхээр намайг нисдэг тэргээр Давжаагийн чанх дээрээс буулгах хэрэгтэй байна. Брезент хүүдийнүүдийн нэгийг би түүний өөхийн доогуур шургуулна. Дараа нь түүнийг нисдэг тэргээр дээш нь татаж гаргая гэв.

Энэ бол туйлын аюултай ажил байлаа гэвч өөр арга зам байсангүй.

Гарьд ган татлагад бэхэлсэн суран бүс бэлхүүсээрээ уяв. Түүнийг нисдэг тэрэгнээс нөгөө ган татлагаар унжуулан доош буулгахад Гарьд Давжаагийн дэргэд тулан очиж хөлөөрөө нөгөө брезент хүүдийг түүний доогуур шургуулав. Нисдэг тэрэг Гарьдыг дахин өрнөж, нөгөө талд нь буулгав. Гарьд брезентийн үзүүрийг хөлөөрөө татан гаргаж эс чадсан тул бүх биеэрээ шаварт шурган орж брезентийн үзүүрийг Давжаагийн гэдэс доороос татан гаргах ажлыг гүйцэтгэв. Энэ бол үнэхээр аминд тулсан ажил байлаа. Татлагын дэгээ мултрах ч, Давжаа түүнийг дарчихыг хэн байг гэхэв дээ! Энэ бол жирийн ус биш, хөл алдан живэх нялцгай шавар байлаа. Танкны даргын тушаалаар нисдэг тэрэгний нисгэгч ган татлагыг дээш татахад шавар дотроос эхлээд Гарьдийн толгой мөр дараа нь брезентийн үзүүрээс барьсан гар нь гарч ирлээ. Нисдэг тэрэг дараа нь Давжааг суга татан гаргалаа. Тэр нь Гарьдын доорхонд дүүжлэгдэн байлаа. Бүх юм ёсоор болсон боловч хэрэв Давжааг газар буулгавал тэр бээр тэр дороо зугтааж арилахыг Гарьд сайн мэдэж байлаа. Тийм учраас түүнийг агаарт дүүжлээстэй байхад нь Гарьд түүний хөлд чөдөр хийж авчээ, Түүний дараагаар Давжааг газарт буулгав.

Одоо торон дотор тийчилж байгаа Тахийг ногтолж авах хэрэгтэй болов. Гарьд цэргүүдтэй хамжиж, дөрвөн хөлийг нь маш сайн тушсаныг дараа түүний торыг хуулан авчээ, Ажилдаа улайрсаар байгаад үд өнгөрснийг хэн ч ажигласангүй. Нисдэг тэрэг буусны дараа цэргүүд, нисэгчид, профессор Немченко, Гарьд цөм хоол идэхээр шийджээ. Харин нэг цэрэг хоол идэхээ жаахан хойшлуулж Давжаагийн шаврыг угааж цэвэрлэв. Дараа нь адуунуудаа нисдэг тэргэнд ачаад профессор Немченко, Гарьд хоёр цэргийн анги дээр хамт хүрэлцэн ирэв. Тэнд Тахь Давжаа хоёрыг маш өндөр хана бүхий хашаанд хашив. Китти минь, одоо тэд тэндээ байгаа. Энэ бол тэднийг барьсан газраас зүүн тийш дөрвөн км орчимд оршдог гэнэ.

Тахь, толгой цээж, гэдэс, мөр зэрэг газартаа аймшигтай олон шарх сорви олсон байна. Сүүл нь хагас болтол зулгарч унаснаас гадна

нойрсуулагч сум орсон нөгөө мөрний нь шарх одоо болтол эдгээгүйгээр барахгүй идээ татсан байна гэж Гарьд ярив. Харин Давжаагийн биед шарх сорви байхгүй ч гэсэн турж ядарсан шинж илэрхий байжээ. Түүний туурай нь мөлийж улдсанаас гадна хагарсан байжээ. Бас сүүлийг нь хэн нэгэн хүн зулгаачихсан юм шиг шодойгоод харваас өрөвдмөөр байсан гэнэ. Улаан буудай, овъёос идэхгүй зөвхөн өвс иддэг болсон байна гэнэ.

Тахийг дөнгөж суллаж тавимагц, ийш тийш цойлж давхиад гарч зугтах нүх сүв хайж байсан гэнэ. Гэвч энэ хашаанаас гарна ч гэж саналтгүй гэж Гарьд ярив. Тэднийг тэнд нь нэг хэсэгтээ байлгаж байгаад дараа нь тэндээс зүүн тийш гурван зуун км-ийн зайтай орших Никольскт байдаг карантины станцад аваачих гэнэ. Тэнд тэднийг эмнэлгийн үзлэгт оруулж, ямар нэг өвчин байгаа эсэхийг нь шалгах юм байх. Түүнд бас нэлээд хэд хоногийн хугацаа хэрэгтэй байлгүй дээ.

За, Китти минь, ажил явдал иймэрхүү л байна. Гарьд бид хоёр чамд энэ захидлыг бүтэн долоо хоногийн турш бичлээ. Удахгүй чи Тахь Давжаа хоёрыг хүлээж авна байх! Тэднийг хүлээн авмагцаа яаралтай захиа бичээрэй! Харин тэгэхдээ тэд яаж байгаа, тэдний өнгө зүс ямар байгаа тухай болон ааш зан нь хэрхэн өөрчлөгдсөн тухай зэргийг дэлгэрэнгүй бичээрэй! Давжаа чинь чамайг үзээд яаж байгааг маш нарийн тодорхой бичээрэй!

*Баяртай мэндчилгээ дэвшүүлж үлдсэн чиний найз
Баярт.*


Жич: Давжааг маш хөөрхөн гүү байна гэж Гарьд ярьсан. Тэр бээр цэргүүдэд Тахийн ухаантай, зөрүү зантай болох тухай тодорхой ярьж өгөөд түүнд туйлын болгоомжтой хандахыг сануулжээ. Хэдийгээр тэд ойлгож байна гэж хэлсэн боловч Тахийн хүчийг нэг л дутуу үнэлээд байна уу гэж би бодсон гэж Гарьд ярилаа. Урьд өмнө тэд ийм амьтантай учирч таарч явсан биш, яаж ч мэдэх вэ дээ! Түүний бодож байгаагаар бол, Тахь бол зэрлэг адуу учраас нутагтаа ойртож ирснийг андахгүй мэднэ. Иймээс тэр бээр одоо яаж ийгээд л мултрахыг бодно. Тэр бээр хуучин, шинэ арга залиа бүгдийг хэрэглэнэ. Энэ учраас танай өвөө хурдхан шиг ирж, тэднийг Уэльст байдаг нөгөө дархан цаазтай амьтан нутагшуулах

газартаа аваачвал арай л найдвартай байх бол уу гэж бид бодож, тэр өдрийг тэсэж ядан хүлээж байна.

Б.

Эрхэм Баярт аа,

Чиний захидлыг намайг чанга дуугаар уншихад өвөө шүүрс алдан Эванс ахай нулимс цийлгэнүүлсэн шүү. Миний бол сэтгэл амарч санаа алдлаа. Яагаад гэвэл хэрэв тэд аяллаа үргэлжлүүлсэн бол хөөрхий муу Давжаа л тэсэхгүй байсан. Одоо бид тэднийг хүлээн авахад бэлтгэж байна. Өвөө хашаа хороог нийтэд нь засаж сэлбэхээс гадна хашааг гурван тохой өндөрлөх тухай үүрэг өглөө. Бүх чулуун хануудыг дахин шалгаж цементээр бэхлэн гагнаснаас гадна гарц газруудыг хоёр давхар хаалгатай болголоо. «Хэрээний үүрний» Питерийг чи лав санаж байгаа байх? Тэр бээр харуулын гурван өндөрлөгтэй болсон. Тэндээс одоо бүх хөндий хоолой, ой шугуйг шалган харах боломжтой болов. Бид гурав шинэ улаан бугатай болсон. Одоо бид хоёр оргодлоо л сэтгэл догдлон хүлээж байна. Миний хувьд сэтгэл догдлох бас нэг шалтгаан бий юм. Яагаад гэвэл аав минь нэг сарын дараа нутагтаа эргэж ирнэ. Гэхдээ бүрмөсөн биш. Дөчин таван хоногийн хугацаагаар. Ирэх жил л бүрмөсөн буцаж ирэх ёстой. Лав намайг танихаа больсон байхдаа. Тэр бээр намайг бараг үзээгүй юм. Ийм учраас миний сэтгэл ялимгүй догдлоод байна. Би яахыгаа ч өөрөө мэдэхгүй байна. Ер нь би өвөө, Эванс ахай нараас хэзээ ч салж чадахгүй байх. Хэрэв чи зэргэлдээ тосгонд байдаг сан бол ямар гоё вэ? Замын дунд болзож уулзаад бүх юмаа ярилцах сан. Надад сургуулийн олон найз нар бий. Яагаад ч гэх юм бэ дээ, би тэдэнтэй тэр болгоны тухай зөвлөж ярьдаггүй юм. Бүх зовлонгоо ганцхан чамд л хуучилмаар санагдах юм. Гэхдээ чи бид хоёр ямар хэлээр ярилцах билээ? Би хэзээ ч монгол хэл сурахгүй байх. Чи бид хоёрын ярих хэл мон-англи ч эсвэл ан-монгол хэмээх хэл л байх болов уу.



Энэ бүхэн бол голчлон надаас хамаарна гэдгийг би ойлгож байна. За, ингээд санаа сэтгэл хямрахаасаа өмнө захидлаа төгсгөх үү дээ. Амьдрал улам нарийн төвөгтэй болж байна. Тийм биз дээ? Эхлээд би улам бүр хялбархан болно гэж боддог байлаа. Хорин тав ч, хорин зургаа түүнээс хэтрэхээр яана даа гэж бодоход айдас хүрэх шиг болох юм.

За, тэр ч яах вэ. Тахь Давжаа хоёрын тухай ямар нэг сураг чимээ сонсмогцоо чамд яаралтай захиа бичнэ.

*Бүгдэд мэнд хүргээрэй!
Китти.*

Сайн байна уу, Китти!

Дахиад л гай зовлон учирчээ! Яагаад юм бүхэн ингэж буруугаар эргээд байгааг би огт ойлгохгүй байна. Чухам юу болсныг ч мэдсэн юм надад алга. Украин руу Гарьд өчигдөр яаралтай явлаа. Ямар нэг хэрэг түвэг гарсан л байх. Түүнд ч тодорхой учрыг тайлбарласангүй, карантины станц дээр яаралтай ирэх хэрэгтэй гэсэн гэнэ.

Гарьд өөрөө бол явах тийм ч их дуртай биш байлаа. Учир нь энд байгаа түүний зэрлэг сүрэг тарж явчих гээд болохгүй байгаа юм. Тэд дархан цаазтай газрын хашаалалд орсон гэдгээ ухаарсан бололтой. Манай эрдэмтэд оргох замыг нь хааж далан буюу хана босгох зэрэгт ихээхэн цаг зарж байгаа юм. Түүнээс гадна нөгөө хөгшин азарга нь саявтархан үхсэн, түүнийг орлож үлдсэн азарга үрээ нь тийм ч их ухаантай адуу биш юм. Тэр бээр ямар ч зорилгогүй сүргээ ийш тийш нь хуйлруулж хөөхөөс өөр юмгүй бололтой. Сая төрсөн унага, хөгшин хөвөө гүү зэрэг нь түүний энг даахгүй байна. Үүнээс болж адуун сүрэг сарниж ч болно. Хайлган цагаар эцэж турсан адуу өвлийн хүйтнийг яаж туулах вэ дээ.


Ийм учраас Гарьд тэднийхээ төлөө туйлын их зовж яваа хүн. Битүүдээ тэр бээр Тахийг буцаад ирээсэй л гэж бодож яваа байх. Тахь эргээд ирвэл ч яахыгаа мэднэ. Миний чамд сонирхуулах зүйл ердөө л энэ байна. Гарьдаас би мэдээ сэлт авмагцаа чамд захиа бичнэ.

*Чиний үнэнч найз
Баярт.*

Эрхэм, Китти!

Тэр хүмүүсийг зэмлэх хүсэл надад алга! Гэхдээ хэдий чинээ олон удаа Тахийг нэг хашаанаас нөгөө хашаанд шилжүүлэх тусам түүнд төдий чинээ оргож булгах боломж олдох нь дамжиггүй гэдгийг би дээр мэдэж байсан юм.

Энэ хэрэг нь морьдыг онгоцны буудлаас Ижил мөрний цаана орших Никольск хотын карантины станц руу аваачих хооронд гарчээ. Цэргийн нөхөд тэднийг тээврийн том онгоцоор хамгийн ойрхон орших нэг аэропортод хүргэж иржээ. Яагаад гэвэл нисдэг тэргээр аваачихад хэтэрхий хол байжээ. Адуу мал тээдэг тусгай төхөөрөмж бүхий ачааны машин станцаас онгоцны буудал руу ирүүлсэн гэнэ. Тэр машины жолооч, зоотехникч хоёрт Тахийн аргатай зальтай гэдгийг урьдчилан анхааруулсан байжээ. Тэгэхдээ тэд Тахийг арай ч ийм гэж бодсонгүй явжээ. Тэд Тахийг ачааны машинд ачихдаа түүний хөлийг тушсангүй. Нэгэнт битүү бүхээгтэй машинд ачиж байгаагаас хойш тушиж хүлэхийн хэрэг юү байх вэ? гэж боджээ.



Гучаад км явсны дараа машины бүхээгийг тэдний нэг нь туурайгаараа нүдэж байгааг олж сонсжээ. Яагаад ингэж нүдээд байгааг нь шалгахаар шийджээ. Тахид ойртож огт болохгүй гэж тэдэнд

анхааруулсан боловч зоотехникч машины арын хаалгыг ялимгүй онгойлгож юу болж байгааг шалгаж харахаар шийджээ. Тахид зөвхөн энэ л хэрэгтэй байжээ. Хаалгаа хаагаад түгжиж амжаагүй байхад нь Тахь хаалганы хавтас руу хүчтэй өшиглөсөн байна. Гэмтсэн зоотехникч ухаан алдан унажээ. Энэ мөчид Тахь үсэрч буюугаад янцгаан унгалдаж Давжааг хүлээж байхад нь машины жолооч шархадсан нөхөртөө туслахаар гүйж иржээ. Тахь толгойгоо нугдайлган түүн рүү дайрч Тахь Давжаа хоёр түүнийг дайрч унагаагаад эрдэнэ шишийн тариалангийн талбай дундуур зугтан алга болжээ. Түүнээс хойш тэдний барааг хэн ч олж хараагүй байна.

Улсын карантины станцын дарга эрэл хайгуулыг чадах чинээгээр зохион байгуулсан боловч сураг чимээ гаргаж чадсангүй, юутай ч болов Монголоос Гарьдыг дуудах нь зүйтэй гэж шийджээ. Тэд Тахь Давжаа хоёрын мөрийг ч гаргаж чадахгүй байсан тул юуны өмнө зэрлэг адууны зан араншны талаар Гарьдаас зөвлөгөө авах нь хэрэгтэй байжээ. Харин Гарьд тэдэнд, тэр хоёр өдөр нуугдаж шөнө явна. Ганцхан Дорно зүгт явах болно гэж л зөвлөж чадна.

Энэ явдал гурван сарын өмнө болжээ. Дээрх хугацаанд Никольск хотоос зүүн тийш орших бүх нутгийн аль эгзэгтэй нууц газар, өнцөг булан бүрийг нарийвчлан нэгжиж үзжээ. Хамтрал, тосгон суурин, төмөр замын өртөөний хүмүүст захиж, дахиад цэргийн ангиудаас тусламж гуйжээ. Бүх ой тайга, тал хөндийг ачааны болон суудлын машинаар хэрэн хэсэж, зарим үед морь, нисдэг тэрэг хүртэл хэрэглэж үзжээ. Утсан холбоо цахилгаан шугам зогсоо жолоогүй ажиллажээ. Гэвч Тахь Давжаа хоёр газар цөмрөөд орчихсон юм шиг ор сураггүй арилсан байлаа. Ийм л сонинтой байна даа. Китти минь! Тэр хоёрын одоо байгаа нутаг нь тэгш тал нутаг бөгөөд тосгон суурин маш ховор тохиолдоно. Тэд дорно зүгийг барин явсаар Казахстаны хязгааргүй цөл тал буюу магадгүй, киргизийн уулархаг нутагт очно. Тэнд ч ёстой тэд баригдана гэж ярихгүй. Энэ бол атаршсан нутаг. Үнэн хэрэгтээ энэ бол ёс-той л адуу их үржүүлдэг, адууны нутаг даа. Өвс ургамал нь тачирхан, цаст өндөр уултай ийм л нутаг даа.

Китти минь, энэ удаа бол би Тахь ямар ч байсан төрөлх нутгийн ууландаа ирнэ гэж бодож байна. Одоо түүнийг юу ч хорьж, тогтоож чадахгүй.

Удахгүй би уулын бэлчээрээ орхиж явна. Ховд хотноо очиж суралцан арван жилийн сургууль төгсөнө. Бид бараг хоёр жил

захидлаар харилцаж байгааг чи лав анзаараагүй байх. Үнэмшмээргүй юм. Ердөө л өчигдөр эхэлсэн санагдана. Хамгийн сайн сайхныг хүсэн ерөөсөн чиний хэзээний найз

Баярт.

Жич: Чиний нөгөө Скип нохой яасан бэ? Чи түүний тухай ер бичихээ больчихсон байна. Тэр чинь зүгээр биз дээ? Миний нохой (хойлог нэртэй) ногтруу хөөж яваад өнгөрсөн оны таван сард үхчихсэн. Нүх ухахдаа сурмаг, сүүлээ хөдөлгөх дуртай, цовоо сэргэлэн, ааш зан сайтай бяцхан хөөрхөн нохой байсан юм даа. Хэдийгээр нүдний нь харцанд уйтгар гуниг дүүрэн байсан боловч үхэж байхдаа хүртэл биднийг битгий гашууд! гэж тайтгаруулахыг хичээж байсан юм. Тэр бээр хадсан өвс зөөж явсан тракторын урдуур гүйж ороод дайруулчихсан юм. Манай хөдөө нутагт нохойг оршуулдаг заншил байхгүй. «Нар л түүнийг оршуулна» гэж ярьдаг юм. Гэсэн ч миний дүү Минжээ бид хоёр түүнийг оршуулахаар шийдсэн юм. Шөнөөр бид хоёр ууланд гарч хойлог нохойгоо манай өвгөд дээдэс яаж өөрийн хайртай сайн морийг оршуулж байсан яг тэр маягаар оршуулсан юм. Хойлог минь, юутай ч хөгжилтэй сайн нохой байлаа. Зарим үед ёстой атаа жөтөө хөдөлгөмөөр сайн нохой байсан юм.

Б.

Эрхэм нөхөр Баярт аа!

Дөрвөн сар хагасын дотор би чамаас ганц ч үг олж сонссонгүй. Юу болох нь энэ вэ? Чи мэдээ сэлт хүлээгээд байна уу? Эсвэл тэр мэдээ сэлт чинь дэндүү муу байснаас чи түүнийг надад сонсгох дургүй байна уу? Чиний сүүлчийн захидлыг уншсаныхаа дараа өвөө хүн бүхэнд уурлаж уцаарлаад нэг л биш болчихлоо. Тэд Тахийн заль мэх, зөрүү занг нэг л дутуу үнэлээд байна гэдгийг өвөө ч бас мэдээд байсан юм.

Хумсын төдийхөн сонин сонслоо ч гэсэн заавал бидэнд бичээрэй!

Ёсолсон Китти.

Эрхэм найз Китти,

Би физикийн томьёолол цээжилж, химийн шалгалт өгөх гээд ойрын өдрүүдэд тун завгүй байлаа. Түүний дээр нагац эгч Сэр-Од Свердловск хотын гадаад хэлний дээд сургуульд түр томилолтоор явсан. Иймээс би чамд захидал бичиж чадахгүй удлаа.

Гарьд дөрвөн сар эрэл хайгуул хийж яваад саявтархан гэртээ ирсэн. Түүнд унаж хэрэглээгүй хөсөг байхгүй гэнэ. Онгоц, нисдэг тэрэг, машин, трактор, морь зарим үед явган хүртэл явж хайхад хүрсэн гэнэ. Түүний үзэж байгаагаар бол тэр хоёр адуу Казахстаны нутагт хаа нэгтээ эцэж туйлдсанаас ч, хортой өвс ургамал идсэнээс болж үхсэнээс зайлахгүй гэнэ. Түүнээс гадна ус, унд хоол тэжээл дутсанаас ч үхсэн байж болох юм. Түүний ярьж байгаагаар казахын тэр зэлүүд нутагт амь алдах түмэн зүйлийн шалтаг таарч болно гэнэ. Ямар ч аюул тохиолдохыг хэн байг гэхэв.

Өөр тодорхой мэдээ сэлт алга байна.

*Чиний найз
Баярт.*

Эрхэм найз Баярт аа!

Энэ ил захидлын хуудсан дээр байгаа зүйл бол Лондоны өндөр гүүр юм аа. Би Лондонд дөрвөн хоногийн хугацаагаар миний шинэ ээж

болж магадгүй нэг авгайтай хамт ирсэн юм.

Энэ жил Монголд болон Хятадад маш хатуу ширүүн өвөл болж байна гэж сонинд бичсэнийг би олж уншлаа. Тахь Давжаа хоёр сүүлчийн удаа алга болсноос хойш бүтэн зургаан сар өнгөрлөө. Чи лав ямар ч найдлага тасарлаа гэж бодож байгаа байх. Харин би тэднийг үхсэн байх гэдэгт нэг л итгэхгүй юм даа.

Ёсолсон Китти.

Сайн байна уу, Китти!

Би энэ ил захидлын хуудсан дээр англиар өөрөө бичлээ. Энэ бол манай монголын үндэсний баатар Сүхбаатарын зураг юм. Би уулнаас явлаа. Ховд хотын 4-р дунд сургуульд суралцана. Өнгөрсөн жил урьд өмнө болж байгаагүй хүйтэн өвөл болсон. Хүйтний градус 40 өнгөрч байлаа. Хөдөө нутагт адуу мал их үхсэн. Зэрлэг адуу ч үхсэн. Тахь, Давжаа хоёр ор сураггүй алга болно гэдэг туйлын гунигтай хэрэг байна. Тэд алга болсноос хойш есөн сар өнгөрлөө. Ер бусын энэ хүйтэнд тэд лав хөлдөж үхсэн байх шүү!

Китти минь баяртай.

Баярт.

Сайн байна уу, Баярт аа!

Тахь Давжаа хоёр хэдийнээ үхсэн ч байлаа гэсэн тэр, би тэдний тухай бодохгүй байж огт чадахгүй нь гэдгээ чамд хэлэх гэж энэ захидлыг бичиж байна. Тэднийг бодоод үе үе уйлж ч үзэх юм. Тэд цасан шуурган дунд бие биеэ түшиж зогсоод үхэж байгаа ч, жавар салхинд нэвт үлээгдсэн нүцгэн уулсын дунд хөлдөж үхсэн ч гэж элдвийг л бодох юм Би шинэ ээжтэй болсон. Туйлын сайхан зантай хүн юм аа. Удахгүй би энэ дархан цаазтай амьтан нутагшуулах газраас бүрмөсөн явж, Портсмут хотноо суух болно. Эванс ахай туйлын дурамжхан байна. Өвөөгийн тухай бол яриад ч яах вэ. Ил захидлын хуудсан дээр илүү олон үг бичиж багтахгүй тул үүгээр төгсгөө! Чи англиар сүрхий бичдэг болжээ. Би шалгалт өгч эхэллээ. Аймшигтай хүнд байна.

Ёсолсон Китти.

Эрхэм найз Китти!

Улаанбаатар хотноо байдаг Монголын Шинжлэх Ухааны Академи манай уулнаас баруун тийш зуу орчим км-ийн цаана геологичид хоёр зэрлэг адуу олж үзсэн байна гэсэн мэдээ хүлээн авчээ. Энэ тухай надад Гарьд хэлсэн бөгөөд тэд нь Тахь Давжаа хоёр байж болох юм гэж тэр бээр үзэж байгаа ажээ. Гэвч би эргэлзэж байна. Мэдээжийн хэрэг, манай эндээс алдагдсан таван адууны хоёр нь л тэнд явсан байж таарна. Чи санаж байгаа биз дээ? Миний бодоход, тэд л байх. За тэр ч яах вэ. Хэрэв ямар нэг тодорхой мэдээ авбал захидал бичье!

Чиний үнэнч найз Баярт.

Эрхэм найз Баярт аа!

Хэрэв тэд манай нөгөө хоёр бол яаралтай цахилгаан явуулаарай! Тэглээ ч гэсэн би нэг л итгэхгүй байна. Гэсэн мөртөө сэтгэл хөдлөөд, найдвар байгаа санагдаад болохгүй юм. Хэрэв чи хүсвэл, мөнгийг нь бид үүгээр төлөхөөр зээл цахилгаан явуулж бас болно гэж өвөө хэлж байна.

Хариу хүлээж ёсолсон

Чиний найз Китти

УЛААНБААТАРААС УЭЛЬС, «ХАР УУЛ» ХЭМЭЭХ ДАРХАН ЦААЗТАЙ ГАЗАР КИТТИ ЖЕМИСОНД ЭРХЭМ НАЙЗ МИНЫ ТАХЬ, ДАВЖАА ХОЁР ГАРЦАА БАЙХГҮЙ МАНАЙ НУТАГТ ИРЖЭЭ. ОДОО ТЭДНИЙГ ЭРЖ БАЙНА. УЧРЫГ ОЛЖ БАЙГААД ТОДОРХОЙ БИЧЬЕ! СЭТГЭЛ ИХ ХӨДӨЛЖ БАЙНА.

*ЧИНИЙ НАЙЗ
БАЯРТ.*

Эрхэм найз Китти!

Тахь Давжаа хоёрын түүх дандаа л ер бусын байдаг болсон хойно доо, бас л нэг ер бусын юм эхэллээ. Энэ тухай өгүүлэхэд туйлын бэрх, зүрх шимширнэ. Гэсэн ч өгүүлэхээс өөр арга алга! Энэ тухай ярихад ямар их уйтгар гунигтай болохыг чи лав төсөөлөхгүй байгаа байх!

Гуравдугаар сарын таванд манай энэ ууланд ажиллаж байсан өөр нэгэн хэсэг геологичид урт гүнзгий хавцал уруудан хоёр адуу явж цөхөн байхыг олж хараад бааздаа радио холбоогоор мэдээ өгчээ. Энэ тухай бид олж мэдмэгцээ (энэ үед би улирлын амралтаар гэртээ ирчхээд байсан юм) бүгд тэр хавцал руу яаравчлан очиж тэр хоёрыг олж харахаар шийдэв. Ах, эгч, аав, нагац ах, ээж, өвөө хоёр хүртэл цөм л явахыг хүслээ. Бас нагац эгч Сэр-Од. Гэвч яаж тэд цөм явах вэ дээ. Аав, Гарьд, эгч Сэр-Од бид дөрөв л явлаа. Бид өглөө эрт гэрээсээ гарч яваад, нар жаргахын хэрд нөгөө урт хавцлын хамгийн алслагдсан үзүүрт хүрч очлоо. Бидний очиход тэнд зэрлэг адуун сүрэг бас яг бэлчээртээ гарч идээшлээд байлаа. Ямар нэг юм болж байна гэдгийг мэдсэн юм шиг тэд үргэж бусгаад нэг л янзтай байлаа. Залуу азарга үрээ циркийн тавцан дээр гарч ирсэн морь шиг адуугаа хэд тойрч давхиснаа бүх сүргээ гэнэт хумхиж хөөгөөд, арилж өгөх нь тэр! Арваад минутын дараагаар Тахь Давжаа хоёр гарч ирлээ. Китти, тэр үед миний зүрх яаж шимширснийг ёстой юутай ч зүйрлэх арга алга! Бид бүхэн цөм санаа сэтгэлээр унасан юм. Сэр-Од эгчийн хацар дээгүүр мөнгөн сувд шиг нулимс бөнжгөнөж байлаа (энэ бол яах аргагүй үнэн).

— Харав уу, нөгөө английн бяцхан хөөрхөн байдас чинь тэр байна гэж аавыг хэлэхэд бусад хүмүүс «А тийм, ёстой хувиршгүй үнэнч найз нь мөн дөө!» гэв.



Чи Давжаагийн тухай үргэлж бичдэг байснаас бид түүнийг өөрсдийнхөө адуу мал шиг андахгүй сайн мэддэг болсон юм. Магадгүй илүү ч байж болно. Энэ мөчид бид цөм, Китти чиний тухай бодсон. Цөм шүү!

— Харин энэ чинь хариугүй унагалах гэж байх шиг байна гэж Гарьд хэлэв Бид цөм сэртхийн цочив. Тахь дэргэд нь хэнэг ч үгүй чихээ хөдөлгөн, толгой сэгсэрч зогсоно. Тэр бээр түүнд яаж туслахаа ч мэдэхгүй байгаа нь илэрхий. Давжаа өөрийн хүндэрсэн биеийг дааж ядан, зовлонтойгоор арай чамай хөдөлж харагдана. Түүнийг харахад нүд халтирам байлаа. Хэдэн мөчийн дараа тэр бээр эхэлж өвдөг сөхрөөд, эцэст нь хажуулдан хэвтэв. Тахь түүнийг хошуугаараа нэг түлхэж үзээд, толгойгоо сэгсчин тачигнатал унгалдсаар хөндий уруудан давхив. Дараа нь толгойгоо цогнойлгон унгалдах ч биш янцаглах ч биш чарлав.

— Бүх сүргийг булааж авахын тулд залуу азарга үрээтэй тулалдах хэрэгтэй болсныг тэр бээр таамаглан мэджээ гэж аав хэлэв.

— Магадгүй, цаадах чинь зөвхөн Давжаатайгаа л хамт байхыг хүсэж байгаа юм биш үү? Харин бусад сүрэгтэй нийлэхээс болгоомжилж байвал яана? Цаадуул нь гэнэт ирчих гээд байгаа юм биш биз...

— Үгүй. Тахь сүрэгтэйгээ нийлэхийг хүсэж байгаа. Хар л даа одоо...

Энэ бүхэн миний эзэмшлийн газар гэх шиг Тахь үүгээр түүгээр хэрэн давхина. Ингэхдээ улам ч сэтгэл нь хөөрч, хөл нь хөнгөрч байгаа бололтой. Тахь өөрийнхөө эзэмшлийн газрыг эргэж тойрч үзэхээр одсон энэ үеэр бид ч буцахаар хөдөллөө. Давжаа л нөгөө газраа ганцаар торойж үлдсэн. Тэгэхээс ч өөр яах вэ. Тэсвэрлэх л хэрэгтэй боллоо.

Мэдээжийн хэрэг, уулзсан тааралдсан хүн бүхэн биднээс түмэн зүйл шалгааж гарав. Бид том хэмжээний газрын зураг дэлгэж тавиад, тэдний буцаж ирсэн замыг тогтоохыг оролдов. Хэдийгээр хүн бүхэн Тахийн эрс шийдвэр, эрэлхэг зоригийг бахдан бахархаж байсан боловч гэрийн тэжээмэл бяцхан англи байдас яаж ийм ер бусын урт замыг туулж чадсаныг бид бас гайхахгүй өнгөрч хэрхэн болох билээ.

Дараа нь бид тэднийг одоо хэрхэх тухай ярилцав. Тахийг дахиад Уэльсийн дархан цаазтай газарт явуулах уу? Ганцхан Давжааг л явуулах уу? Унагыг яах вэ? Унагыг зэрлэг сүрэгт үлдээж болохгүй, яагаад гэвэл тэр бол бас цэвэр зэрлэг цусны адуу биш. тэр бээр тавин хувь нь шотландын давжаа адууны хольцоотой. Үнэн хэрэгтээ, бидний санал бол юу ч биш. Энэ бүхнийг эрдэмтэд л шийдэх байх.

Хамгийн сүүлд миний охин дүү Минжээ, Давжаа чухам хэзээ унагална гэж та бодож байна? гэж ааваас асуув. Эцэг маань хар сахлаа имрээд унавал асуудал нэг л биш байдгийг бид андахгүй.

— За хариулаач! гэж ээж яаруулав.

— Англи байдас маргааш, нөгөөдөр хоёрын нэгэнд л унагалах болов уу гэж би бодож байна. Харин бид түүний тайван байдлыг алдагдуулж хэрхэвч болохгүй. Маш болгоомжтой хандах хэрэгтэй гэж хэлэв. Тэр бээр ямар нэг зүйлд сэтгэл зовж байна гэдгийг бид хэдийнээ мэдсэн юм. Гэвч тэр бээр өөр юм огт ярьсангүй. Маргааш өдөр нь аав, Гарьд бид гурав Давжаа яаж байгааг очиж үзэхээр явлаа. Уулын хажуу өөд сэмхэн авирсаар хяр дээр гараад нөгөө хөндий рүү өнгийж харвал, зэрлэг адуун сүрэг тэнд байлаа. Тахь, Давжаагийн дэргэд зогссон бөгөөд түүний өөдөөс сүргийн эзэн азарга халз тулан зогссон байлаа.

— Одоо эд тулалдана гэж Гарьд шивнэн өгүүлэв. Залуу азарга үрээ сүргээ холдуулах гэсэн янзтай байж цөхөн тойрно. Тахь Давжаа хоёроос бусад нь түүний аясыг дагана. Давжаа хөл дээрээ зогсож харагдах бөгөөд ганц алхвал л тэсэрчих юм шиг санагдана. Толгойгоо

унжуулан зогсох бөгөөд туйлдаж ядарсан байдал илэрхий байлаа. Тахь түүний хажууд зэрэгцэн зогсоод, залуу азарга үрээг ажиглан харна. Үнэн хэрэгтээ энэ бол тэдний анхны хүч сорих тулалдаан болж таарна. Тахийг би ажиглаж байгаад:

— Нэг бол одоо, эсвэл хэзээ ч үгүй! гэж шивнэв. Энэ үгийг бараг хэлж дуусаагүй байхад залуу азарга үрээ Давжааг сүргийн хойноос яв! гэж байгаа янзтай бөгс өөд нь хошуугаараа нударч үзэв. Тахь тэр хоёрын хоорондуур нугдайн давхиж оров. Эгшин зуур Тахь бөгсөө эргүүлэн тэрхүү азарга үрээг унах шахтал нь хүчтэй тангарав. Тэр бээр бас мөчөөгөө өгөхгүй тахийг хариу тангарах гэж оролдов. Тахь хажуу тийш бултан зайлж, азарга үрээ рүү дахин дайрав. Энэ удаа гайхамшигтай хурдан амжсан бөгөөд түүнийг бас л унах шахтал нь тангарав.

— Гайхалтай юм! Адуу ийм хурдан хөдөлгөөнтэй байхыг би урьд өмнө огт үзээгүй юм байна гэж аав хэлэв.

Азарга үрээ Давжааг дахиад л хурааж хөөхийг оролдов. Гэвч Тахь, тэр үрээ рүү галзуу юм шиг дайрч хэмлэхэд цаадах нь өвдсөнөөс болж учиргүй муухай чарлав. Жинхэнэ тулалдаан одоо л эхлэх ёстой байлаа. Тахь нэгэнт хүч давамгайлснаа ашиглаж түүнийг үлдэн хөөж тулалдахын оронд толгойгоо ууртай сэгсчин Давжаагийн дэргэд хоргодон үлдэв. Азарга үрээ газар цавчлан тургиж байсан боловч дахин дайрсангүй. Нэг сүрхий тургиад сүргийнхээ хойноос одлоо.

Тахь түүний хойноос элдэн хөөгөөгүйгээр барахгүй, зогссон газраасаа ч хөдөлсөнгүй.

— Байдас нь унагалах гээд чадахгүй байгааг тэр ойлгосон бололтой гэж аав хэлэв. Тэр бээр ямар нэг зүйл нуугаад байгааг хэдийнээ би тааж мэдсэн тул:

— Яагаад тэр билээ? гэж яаравчлан асуув

— Миний бодоход Давжаа бөгсөн биедээ ямар нэг гэмтэл олсон бололтой. Иймээс тийм амархан унагалчхаж чадахгүй байх.

— Бид түүнд тусалж болохгүй гэж үү? гэж Гарьд асуув.

— Хэрхэвч түүний тайван байдлыг алдагдуулж, айлгаж цочоож болохгүй.

— Хэрэв бид хөндий рүү бууж очвол Тахь уурлаж эхлэх бөгөөд Давжаа зугтахыг оролдоно. Энэ бол Давжаад маш аюултай. Бидэнд хүлээхээс л өөр зам байхгүй. Үнэхээр бид түүнд ямар ч тусламж үзүүлж чадсангүй. Бид бүтэн өдөр ажиглан харж өнжлөө. Давжаа

хөдлөхгүй зогссоор л байлаа. Тахь түүнийг тойрч, дэл, сүүлийг нь элбэн таалах мэт хошуугаараа оролдоно. Тэр орой бид маш уйтгартай бөгөөд сэтгэлийн шаналгаатайгаар гэртээ буцсан билээ. Давжаа английнхаа толгодоос харь хол нутагт ирээд ямар сул дорой ядруу байгааг бид ажиглаж мэдсэн билээ.

Маргааш өглөө нь бид дахиад нөгөө хөндийд очлоо. Тахь Давжаа хоёр байсангүй. Тахь уулынхаа бэлчээрийг биднээс илүү сайн мэдэх учраас хаачсаныг бүү мэд, бид хэдий чинээ гярхай нягт эрж хайсан боловч тэдний байгаа газрыг олж чадсангүй. Дараачийн өдөр нь бас эрээд эрээд олсонгүй.

Гурав дахь өдөр нь бид шинээр эрэлд гарах гэж байтал манайд нисдэг тэрэг хүрэлцэн ирлээ.

— Нисдэг тэрэг ирүүлэх арга байна уу? гэж би Академид хүсэлт явуулсан юм. Хэрэв бид их өндөрт гарч хайвал Тахь Давжаа хоёрыг айлгаж үргээх ч үгүй. Харин тэдний байгаа газрыг хялбархан олно гэж Гарьд тайлбарлан ярив.

Нисдэг тэрэг буулаа. Бид орж суув. Удсан ч үгүй тэр өндрөө авч уулын орой дээгүүр нисэв. Бид их өндөрт нисэж, гуу хавцал, хөндий хоолой, бут сөөг бүрийг нарийвчлан ажиглаж явлаа. Өдрийн хоёр цагийн орчимд нэг бяцхан дэнж дээр хоёр бүртгэр хар юм байхыг олж ажиглав.

— Тэд энд байна! гэж Гарьд моторын чимээн дунд хашхиран өгүүлэв. Эхлээд бид төдий л сайн ялган таньж чадахгүй байлаа. Харин жолооч нисдэг тэрэгнийхээ чигийг өөрчилж яг дээгүүр нь өнгөрөх үед хэдийгээр их өндөрт явсан ч гэсэн Тахь Давжаа хоёр мөн болох нь баттай танигдсан юм.

Газар дээр гурав дахь хар цэг байхыг би олж хараад:

— Давжаа унагалжээ! гэж би хашхирав.

— Өндрөө жаахан саа! гэж аав жолоочид хэлэв.

Энэ үед бид хайрга чулуун дээр хэвтэж байгаа Давжаа, түүний дэргэд хэвтэж байгаа унагыг тодорхой ялгаж танив. Нисдэг тэрэг ойртон очиход Тахь Давжааг тойрон хатирч эхэлсэн ба нялх унага ч босох гэж оролдсон боловч тэнцэж чадахгүй байлаа.

Харин Давжаа огт хөдлөхгүй байлаа, Китти минь, түүний хэвтэж байгаа байдал нэг л амьд биш болох нь ойлгомжтой боллоо.

— Бид хожимджээ. Давжаа үхчихсэн байна! гэж би хашхирав.

— Хэт туйлдаж ядарсандаа болоод босож чадахгүй байж болох юм гэж Гарьд Хэлэв.

— Үгүй. Үнэхээр үхсэн байна гэж, аав гунигтайгаар өгүүлэв.

Хэдийгээр хэчнээн сайхан үг хэлээд ч нэмэргүйг мэдэж байгаа боловч Китти минь би чамайг туйлын их өрөвдөж хайрлаж байна. Давжаа маань үхжээ. Бид нүдээрээ үзлээ. Харин унагыг аврахын тулд яарах хэрэгтэй гэдгийг бид ойлгож байлаа. Эс тэгвэл тэр унага бас үхэж болно. Манай эцэг жолоочид газар бууж, тэр унагыг авах хэрэгтэй байна гэж хэлэв.

— Хэрэв нисдэг тэрэг дэндүү ойрхон буувал тахь тэр унагыг зуугаад зугтаж магадгүй. Нэг удаа тийм явдал гарсан шүү! гэж Гарьд өнгөрснийг дурсан өгүүлэв.

— Дүүрсэн хэрэг, үзээд л алдахаас өөр зам алга! гэж хэлээд, нисдэг тэрэгний жолоочийг тэр гуравт аль болох ойрхон бууж үзээрэй! гэж аав гуйв. Тэр гурваас арван таван метрийн зайтай өвс, шороог хуйлруулан хийсгэсээр нисдэг тэрэг буухад Тахь байж ядан цовхчиж байлаа. Тэр бээр нисдэг тэрэг, Давжаа хоёрын хооронд ийшээ нэг, тийшээ нэг хөлхөн давхиж байснаа биднийг нисдэг тэрэгнээс гармагц дайран ирж өшиглөхийг оролдов. Бид дээлтэй нь дээлээрээ, костюмтай нь пиджакаараа түүнийг үргээхийг оролдон савчин дэвж, зүг зүг тийш зугтав. Нисгэгч гар пуужингаар хий буудаж айлгав.

Давжаа унага хоёрт бидний дөхөж очихыг Тахь хармагцаа гэнэт эргэж нөгөө унаган дээр очоод шүдээрээ зууж нэг удаа, хоёр удаа, гурван удаа урагш нь зайлуулж чулуудав.

Ингэж байгаад унагыг алж мэднэ гэж бид ойлгож байлаа. Бидний ойртох тутам тэр бээр улам омогшиж байлаа. Тахь заавал зугтана гэдэгт бид итгэж байлаа. Бид Давжаад 10-аад метр ойртож очиход тэр нөгөө унагыг орхин түүн дээр давхин ирж түүнийг шүдээрээ зууж босгохыг оролдов.

Энэ үед бид унагыг барьж авлаа. Тэр унага том жижгээр томоохон нохойны хэртэй байсан бөгөөд манай биерхэг нисгэгч түүнийг хүүхэд шиг гар дээрээ өргөн нисдэг тэрэг рүүгээ авч одов. Түүнийг хэдхэн алхаж ч амжаагүй байхад Тахь түүний хойноос ухасхийв. Хэрэв гүйцсэн бол нисгэгчийг лав алсан байх. Бид дээлээрээ ширвэн хашхичиж байснаас гадна нисгэгчдийн нэг нь гар пуужингаар дахин хий буудаж Тахийг айлгав. Ийнхүү нөгөө нисгэгч унагыг авч эсэн мэнд нисдэг тэргэн дээрээ хүрч ирэв.

Одоо бидэнд Тахиас зугтаж гарах л хэрэгтэй байлаа. Тахь биднийг нэхэн довтолсоор байлаа. Биднийг нисдэг тэргэндээ сууж хөөрөх завсар тэр бээр нисдэг тэргийг хоёр удаа айхавтар хүчтэй өшиглөж, туурайныхаа мөрийг түүн дээр үлдээв. Нисдэг тэргэнд суусан хойноо бид тэр унагыг нарийвчлан ажиглахад түүний нүд нь хөхдүү өнгийн хальсаар бүрхмэл байсан бөгөөд цаг алдсангүй амжсанаа ойлгов. Эс амжиж очоогүй бол өнчин үлдсэн нялх амьтан яаж тэсэх билээ дээ.

Китти, би чамд өөр юу ч гэх билээ дээ?

Бид унагыг сайтар угааж дулаахан нэхийгээр нэмнээд нэг гэрт оруулав. Бид түүнийг угжиж байлаа. Тэр бээр хэд хоног үхсэн амьдын хооронд байсан. Цаашид амьдарна гэдэгт итгэхэд бэрх байлаа.

Түүнээс гадна бид бас Тахь Давжаа хоёрын талаар бодох хэрэгтэй болов. Ижилсэж дассан адуу нэгийгээ үхэхээр яаж гутарч гуныж, эцэж турдгийг бид адуучин улс болохоор андахгүй мэднэ. Тиймэрхүү явдал бидэнд нэг биш удаа тохиолдож байсан. За, ингэхээр одоо Тахийг яах вэ? гэдэг бодолд бид дарагдлаа.

Дахиад бид тэр хөндий дээгүүр нисэж үзэхэд Тахь Давжаагийн дэргэд зогссоор л байлаа. Тэр бээр өөр яах вэ дээ? Давжааг өөрийн уулархаг нутгийн шаргал талд оршуулахаас өөр ямар ч арга бас бидэнд олдсонгүй. Бид Тахийг хөөж тууж холдуулаад, мод бороохой зэхэн барьж, манаж харуулдаж байж арай чамай чиний бяцхан Давжааг нутаглуулах нүх ухлаа. Давжааг бид ийнхүү оршуулав. За тэгэхээр, энэ бүхний буруутан нь Тахь мөн. Өссөн төрсөн нутгаас нь түүнийг салган, энэ алс газар дагуулж ирэхэд тэр бээр зовж зүдэрч, эцэж туйлдсанаас болон үхжээ. Үнэнч явснаас болж тэр бээр ямар их хатуу шийтгэл хүлээв дээ! Гэвч чи Тахийг уучилна байх гэж бид найдаж байна.

Манай нисдэг тэргийг хөөрсний дараа Тахь, Давжааг булсан тэр газарт эргэж ирэв. Тэр бээр чухам хаа булсныг андахгүй байснаар барахгүй хошуу ба туурайгаараа газрыг ухах гэж оролдож байлаа. Дөрөв хоногийн дараа эргэж үзэхэд тэнд мөн л зогссон хэвээр байлаа. Бид түүнд өвс хаяж өгөв. Зөвхөн арван нэг дэх хоног дээрээ тэр бээр тэндээс хөндийрөв.

Харин тэр унага мал болох нь гэдэг нь одоо бидэнд ойлгомжтой боллоо. Тэр бээр хэдийнээ зогсож чаддаг боллоо. Түүнийг өөр нэг

гүүнд «өргүүлэх» хэрэгтэй байна гэдгийг бид ойлголоо. Тэгээд нэг унагатай гүүг сонгон олж түүнд тэлээлүүлэхээр шийдэв.

Харамсалтай нь: Манай гэрийн адуу ямар нэг зэрлэг адууны цус холилдсоныг огт анддаггүй бөгөөд иймээс түүнийг «өргүүлэхэд» яггүй бэрхшээл тохиолдоно гэж бид айж байлаа. Харин Давжаагийн унага туйлын хөөрхнөөс гадна хүний зөнгөөр ялдам ааштай, аливаа амьтныг дагаж гүйх дуртай. Тэр гүүг хармагцаа түүний эх нь хүлээж байгаа юм шиг шууд хүрч очоод нэг үнэрлэж үзсэнээ цавь руу нь хошуугаа шургуулан хөхөж эхлэв.

Тахь, залуу азарга хоёрын хооронд зайлшгүй болох байсан бөгөөд эцсийн удаа болсон нэгэн айхавтар тулалдааныг долоо хоногийн дараа Гарьд олж харсан тухай эс өгүүлбэл миний чамд ярих гэсэн бүх зүйл ингээд дуусах нь энэ! Тэр тулалдаанд мэдээжийн хэрэг Тахь ялсан юм. Тэр бээр хазсан, хайрсан гэж жигтэйхэн, золтой л алчих шахсан байна. Залуу азарга хэдийгээр зоригтой тулалдсан боловч Гарьдын ярьж байгаагаар нэг л ухаалаг биш, болхи хөдөлгөөнтэй байжээ. Тэгээд эцэст нь тэр азарга зугтжээ. Түүний дараагаар Тахь бүх адууг, унага даагыг хүртэл сүрэгтээ нийлүүлэн хураажээ. Тахь бүх адуунуудыг долоосон гэж Гарьдын ярихад, манай аав, тэгэх ёсгүй гэж мохоов. Ямар ч байсан, Тахь одоо өөрийнхөө эргэж ирэх гэж тэгтлээ хүсэн мөрөөдсөн сүргийнхээ эзэн болов. Харин одоо сүргээ авч зугтах аятай таатай нүх сүв эрэн хайж байгаа бололтой. Одоо энэ сүргийг алдчихгүй бүрэн бүтэн байлгах айхавтар хүнд үүрэг бидэнд тулгарч байна. Нөгөө залуу азарга ч сүрэгтээ эргэж ирж нийлээд, одоо халуун амь бүрдэв. Тахийг дахин барьж авч танай руу явуулах бодолтой байгаа эсэхийг Гарьд Шинжлэх Ухааны Академиас асуув. Бүтэн долоо хоног ямар ч хариу өгөхгүй байсны дараа Улаанбаатараас манай нөгөө гайхамшигт зэрлэг амьтныг үзэхээр таван эрдэмтэн зэрэг хүрч ирлээ. Тэд Тахийн бүх түүхийг нарийвчлан судалж, түүнийг энэ уулнаас салгах гэж оролдоод ямар ч нэмэргүй гэж үзэв. Яагаад гэвэл түүнийг хааш нь ч явууллаа гэсэн тэр бээр ямагт нутагтаа харихыг эрмэлзэх болно гэв. За, тиймээс Тахь эндээ үүрд үлдэх боллоо.

Эхлээд бид нөгөө унагыг өөрийнхөө гэрийн адуун сүрэгт үлдээх гэж бодож байв. Тэгсний дараа нь зөвлөж цөм ярилцаж байгаад (манай гэрийнхэн, эрдэмтэд, Гарьд, айл саахалтын хүмүүс) түүнийг Китти, чамд өгөхөөр шийдвэрлэв. Тэр унага чамд биднийг болон Тахийн хамт

бүх Европ, Азийг туулсан чиний бяцхан байдас Давжааг үргэлж санагдуулж байг! гэж бид хүслээ. Чиний Давжаа үнэнч бөгөөд зоригтой адуу байжээ. Бид монголчууд морь малыг үнэнч нөхөр, сайн найзын дараа орох чухал амьтан гэж үнэлэн үздэг юм.

Тэр унагыг хэзээ явуулахаа бид хараахан мэдэхгүй байна. Бодвол «өргөмөл» эхийнхээ гарыг харахыг болиод алс хол аялж чадах болохоор нь явуулдаг байх даа.

Китти, үүний ялдамд сонирхоход, Портсмутэд очиж суурьшсан танай шинэ байшин чамд лав таалагдаж байгаа биз дээ. Бидэнд ямар нэг золгүй явдал тохиолдлоо ч, энэ дэлхийд хэчнээн олон сайн сайхан, шударга шулуун, ачтай тустай үйлс бүтэж байна вэ дээ?

Энэ захидал нэг л уйтгар гунигтай болчих гээд бичих гэхээс нэг л миний дургүй хүрч байлаа. Магадгүй, түүний төгсгөл нь аз жаргал авчрахыг хэн байг гэхэв. Би үүнд л найдаж байна, Китти минь!

*Чиний үнэнч найз
Баярт ёслов.*

Эрхэм найз Баярт аа!

Чиний захидлыг уншаад тэн хагаст нь орж явтлаа би уйлж эхлэв. Давжаад би ийм юм тохиолдоно гэж аль хэдийнээ мэдээд байсан юм. Одоо би намайг гомдоосон ямар нэг шударга бус, муу юм болохоос бусад үед уйлахаа бүүр больсон.

Гэсэн ч өвөө аав, Эванс ахай нар дээр (хагас бүтэн сайнд) очих болгондоо миний хойноос Давжаа дагаад яваа юм шиг санагдаад л сэмхэн уйлж гардаг юм. Өвөөгийн тэндэх толгодыг хармагц би Давжаатай тоглож наадаж байснаа санахгүй байж чаддаггүй юм.

Давжаа маань Тахийн зовлон жаргалыг хуваалцсанд би туйлын баяртай байна. Ер нь хэн нэгэн хүнд, ямар нэгэн юманд үнэнч байна гэдэг бол маш чухал зүйл, тийм биз дээ? Тэр хоёрыг холбоосон ямар нэг жинхэнэ нөхөрлөл байснаас л тэд ингэж хамт явсан гэж өвөө ярьдаг юм. Тахийг дахин үзэж чадахаа больсон тухай бодол санаа намайг нэг хэсэг зовоож байсан боловч одоо жаахан мартагджээ. Чиний захидлыг уншиж өгөхөд Эванс ахай шууд л уйлж эхэлсэн бөгөөд заримдаа Давжааг харааж, заримдаа түүнд харамсаж байлаа. Өвгөн тэгэхэд нь чи битгий нөгөө «утгагүй юм» гэдгээ л хэлчхээрэй дээ! гэж даапаалж байлаа.

Эванс ахай, бид цөм Давжааг эрхлүүлсээр байгаад эвдсэн юм даа. Би түүнийг жаахан тайтгаруулж орхисон. Одоо бид Давжаагийн унагыг тэсгэлгүй их хүлээж байна. Портсмутын шинэ байр надад таалагдаж байна. Гэхдээ би дархан цаазтай газар, өвөө болон Эванс ахайг туйлын их санадаг. Гэхдээ Скип нохой маань надтай байдаг учраас төдий л их уйтгартай биш байдаг. Би аавдаа болон хойд эхдээ дасаад ирэхээр юм бүхэн ёсоор болно гэж би итгэж байна. Тэд надад их сайн, миний санасан бодсоныг биелүүлж, туслахыг үнэхээр чармайдаг. Харин би өөрийгөө юү болж байгааг нэг л ойлгохгүй юм даа. Хэрэв мэддэг сэн бол уу?

За, ингээд миний бичих гэж бодсон зүйл дуусав бололтой. Урт бөгөөд уйтгартай захидал бичсэн явдалд чинь маш их баярлалаа. Чиний ээж, эгч Сэр-Од нарыг тэврэн ёсолё. Их тэсвэр гарган, англи хэлээр гайхамшигтай сайхан захидал бичсэн эгч Сэр-Одод чинь талархал илэрхийлье.

Ямагт чиний найз

Китти.

Жич: Би цанаар хоёр удаа гулгаж үзэв. Эцэг, эх маань намайг ирэх жил Швейцарт дагуулж очно гэлээ. За, тэр болтол нь унаад хөлөө хугалчихгүй л бол яамай! Цанаар гулгах ямар гоё юм бэ?

К.

Эрхэм найз Китти!

Бид «Гоц» гэж нэр өгсөн нөгөө унагыг, Тахид ялагдсан азарга үрээний хамт өнгөрсөн долоо хоногт явуулав. Арван таванд Англид онгоцоор очно. Тэр азарга үрээг танай өвөөд өгөхөөр шийдлээ. «Гоц»-ыг хүлээн авснаа мэдэгдээрэй? Тэдний хамт танайд очиж, чамайг үзэхсэн гэж би маш их хүсэж байлаа.

*Чиний найз
Баярт.*

Эрхэм найз Баярт аа!

Унагыг хүлээн авлаа (нөгөө азарга үрээ хараахан ирээгүй л байна). Би тэр унагыг хараад элгээ хөштөл хөхрөв. тэр бээр хөгтэй ч, хөөрхөн ч амьтан юм даа. Ер бусын эрлийз амьтан гарчээ! Миний ингэж их инээсэн нь баярын инээд юм шүү! Тэр бээр Давжаагийн дөлгөөн харц, Тахийн инээд хүрэм сахлыг авснаас гадна толгой нь яг Тахитай адил юм. Тэгээд тургилах нь бас яг Тахь гэсэн үг. Миний бодоход, алхаа гишгээ нь Тахийг дуурайжээ. Зэрлэг адууны омогтой алхаа лав байна. Тэр бээр яг гэрийн амьтан шиг наалинхай дөлгөөн зантай нь бүүр ч инээдтэй юм. Давжаагаас ч наалинхай юм шиг санагдлаа. Эванс ахай түүнийг гадагш нь огт гаргадаггүй. Хэрэв өвөө хориглоогүй бол лав түүнийг гал зуухныхаа өрөөнд байрлуулах байсан байх. Эванс ахай Гоцын төлөө ёстой хөл алдана. Эванс ахайд болон надад Гоц туйлын элэгсэг байдаг.

Би чиний тухай үргэлж боддог, бодвол энэ унаганаас болоод тэгдэг бол уу. Зарим үед чамайг ойрхон байдаг ч болоосой гэж бодох юм. Тэгвэл бид хууч хөөрөөд ямар гоё байх вэ? Заримдаа хэн нэгэн хүнтэй нэг их хууч хөөрмөөр санагдах юм. Чи ямар нэг шалтгаар энд ирж болохгүй юу? Манайд зочлох, унагаа үзэх нэрийдлээр ч юм уу?

Манай хоёр адуу цасан шуурга, намаг шалбаагтай тэмцэлдэн уулсын өндрийг давж, улсын хилийг нэвтрэн Европ Ази хоёр тивийг нэвт шувт гатлан нэг үгээр хэлбэл дэлхийн бөмбөрцгийн тэн хагасыг туулсан байхад чи бид хоёр зөвхөн захидлаар харилцаж суух нь туйлын инээдтэй биш үү? Чи заавал ирэхийг бодоорой! Би чамд ямар

нэгэн дэмжлэг үзүүлэх шаардлага байгаа бол бичээрэй! Үнэнээ хэлэхэд, би чамтай уулзахыг маш их хүсэж байна.


*Ямагт чиний найз
Китти.*

Жич: Ирэхийг л бодоорой!

Эрхэм найз Китти!

Мэдээжийн хэрэг, би чам дээр очихыг хичээнэ. Харин миний бодоход чи манайд ирэх нь хялбар байх. Манай гэрийнхэн бид цөм чамайг туйлын баяртай угтана. Хэрэв чи манайд ирвэл Тахь, Давжаа хоёрын наашаа тэмүүлдгийн учир утга ч ойлгомжтой болно гэдэгт би итгэж байна. Би чамд өөрийн нутгийн өндөр уул, өргөн талыг ч үзүүлнэ. Чи бид хоёр морь унаад гүвээ толгодыг дамжин давхина. Энд хэн ч бидэнд саад болохгүй. Магадгүй, чи бид хоёр нөгөө алдагдсан таван адууг эрэхээр ч явж мэднэ. Китти, чи ирэхийг бодоорой! Би чамд бүхий л талаар туслахыг амлая.

*Чиний дотнын найз
Баярт.*



Эрхэм найз Баярт аа!

Очно гэхэд нэг л сэтгэлд багтахгүй байна.

Гэхдээ бол бололцоотой л зүйл (үнэхээр бололцоотой). Хэрэв өвөөтэйгөө хамт очих зөвшөөрөл олдвол би танайд очиж болох л юм. Би түүнд энэ тухай хэлж, маш их шалгаасан. Эцсийн эцэст өвөө ямар нэг арга бодъё гэж хэлсэн. Магадгүй, би өвөөтэйгөө очиж болох л юм. За, бүү мэд! Гэвч би бүх хүчээрээ чармайна. Бүх хүчээрээ шүү...

Ямагт чиний

Китти.

Жич: Чамд би өөрийн ойрмогхон авхуулсан зургаа явуулав. Чи намайг нөгөө л хуучнаараа байх гэж битгий бодоорой. Юм бүхэн хувирч өөрчлөгдөж байдаг шүү дээ, тэгэх тусмаа би бүүр ч өөрчлөгдсөн байгаа нь мэдээж. Миний бодоход, үүнд л хамаг учир байна. Бүх юм юун ч амархан өөрчлөгдөнө вэ? Цаг ямагт шүү!

К.

Эрхэм найз Китти!

Би чамайг ирүүлэх зөвшөөрөл авч өгнө үү? гэж Гарьдыг гуйсан. Бололцоотой бүхнийг хийнэ гэж тэр бээр амласан. Профессоруудтай уулзах ажлаар тэр бээр одоо Улаанбаатарт байгаа. Чиний ирэх асуудлыг зөвшөөрүүлж чадна гэж Тэр бээр надад амласан.

Чиний найз

Б.

Эрхэм найз Б.

Бүх юм ёсоор бүтсэн гэдэгт нэг л итгэж өгөхгүй байна. Танай Шинжлэх Ухааны Академийн шугамаар Улаанбаатарт зэрлэг адууны асуудлаар зохиох олон улсын семинарт урьсан урилга-цахилгаан утас өвөө хүлээн аваад байна. Намайг түүний хамт бас тусгай зочноор урьж байна гэж бичжээ. Баяртаа, би маш их баяртай байна. Баярласандаа арай л уйлахаас наагуур л байна. Алс холын замд гарахынхаа өмнө Давжаа юу бодож байсан бэ, би яг тийм л юм бодож байх шиг байна.

Эцэстээ юу болохыг бүү мэд! Энэ юун тухай болох нь сонирхолтой байгаа биз дээ? Чи намайг угтахын тулд Улаанбаатарт ирэх нь зүйтэй байх шүү. Хэрэв чамайг угтахгүй бол би тэсэхгүй байх шүү. Юу хийхээ би огт мэдэхгүй байна. Намайг угтахын тулд Улаанбаатарт заавал очоорой! Би гуйж байна.

Жич: Гоц эцсийн эцэст манай галын өрөөнд орж авлаа. Эванс ахай түүнийг нэг буланд байрлуулав. Өвөө ч хөөж зүрхэлсэнгүй. Намайг очиход чи Улаанбаатарт заавал угтана шүү.

К.

Эрхэм найз Китти!

Би англиар бичиж байна. Би онгоцны буудал дээр заавал очно. Чамтай уулзахыг хүсэн хүлээж байна. Би юун тухай бичихээ ч мэдэхгүй байна. Энэ бол миний хувьд хязгааргүй баяртай үйл явдал болно гэж л хэлье! Би туйлын их баяртай байна. Чамайг ч гэсэн баяртай байгаа гэдэгт итгэж байна. Чи бид хоёр хамгийн гайхамшигтай, хамгийн сонирхолтой хоёр адуу болох Тахь Давжаа хоёрын тухай дурсах болно. Чи бид хоёр одоо салж хагацашгүй найз нар боллоо гэж би бодож байна. Чамайг хязгааргүй их хүсэн хүлээж байна. Хамгийн халуун дотно сэтгэлээр мэндчилэн ёсолсон чиний найз, ах дүү болсон.

Мөнхийн Баярт.

Уг номыг “[Болор дуран](#)” шалгуураар шүүсэн болно. Программтай танилцах бол сурталчилгаа дээр товшиж холбоос руу орно уу.



БОЛОР ДУРАН 2.0
АЛДА ШАЛГУУР

"БОЛОР ДУРАН" ЗӨВ БИЧИГ ШАЛГАХ ПРОГРАМ

- ✓ 60 сая үеийн сантай.
- ✓ Алдаатай үесийг илрүүлж, зөв үесийг санал болгоно.
- ✓ Хэлзүйн тайлбар тольтой.
- ✓ Хувийн үеийн сан үүсгэх боломжтой.



1980 оны хэвлэлийн Хэвлэн нийтлэлийн мэдээлэл

Жеймс Олдриж

ГАЙХАМШИГТ МОНГОЛ МОРЬ

УЛСЫН ХЭВЛЭЛИЙН ГАЗАР

УЛААНБААТАР

1980

Англиас орчуулсан Л. ХУУШААН

Редактор Д. АЛТАНГЭРЭЛ

Зураач САНАЛБАТ

Уран сайхны редактор В. ОДГИЙВ

Техник редактор Ц. ӨНӨР

Хянагч Х. ЦЭРЭНЦОО, Д. БОЛД

Өрөлтөд 1980— 2— 1.

Хэвлэлтэд 1980— 7 1.

Цаасны хэмжээ 70Х90 1/32.

Хэвлэсэн тоо 13,000

Х. х. 6,5

Х. н. х. 7,6

Т. х 6,51

ХГ. № 5/80.

Зах № 112

Үнэ 4 тө 10 мө

Улсын Хэвлэлийн Газар,

Улаанбаатар Их сургуулийн гудамж, 1.

Сүхбаатарын нэрэмжит Хэвлэлийн Комбинат

Улаанбаатар, Сүхбаатарын талбай, 6.

Заметки

[←1]

«Лэнд рова» — «Газар ухагч» гэдэг нь ГАЗ—
69-тэй төсөөтэй машин.

[←2]

Ярд — английн уртын хэмжүүр нэг ярд нь
91,44. см-тэй тэнцэнэ.